



**БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ
АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ
ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛЖ
БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН
ШИНЖИЛГЭЭ**

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

НАА 67.404
ДАА 347
Э-66

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛЖ БҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ БАГ:

Багийн ахлагч: БАТЗЭВЭГИЙН ЭНХБОЛД, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Судлаачид: СЭНГЭЭГИЙН ГАНТУЛГА, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор цагдаагийн хошууч
БААТАРЫН МӨНХЗУЛ, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн багш, хууль зүйн магистр, цагдаагийн ахлах дэслэгч

Энэхүү судалгааг ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэн нийтлэв.

© Б.Энхболд, С.Гантулга, Б.Мөнхзул, 2019 он

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9574-0-7

АГУУЛГА

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	8
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	9
НЭГ. УДИРТГАЛ	11
1.1. Судалгааны үндэслэл, шаардлага	11
1.2. Судалгааны зорилго, зорилт.....	12
1.3. Судлагдсан байдлын тойм.....	13
1.4. Судалгааны арга зүй.....	13
ХОЁР. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	17
2.1. Хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжилтэд хийсэн судалгаа	17
2.2. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлого.....	22
ГУРАВ. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	37
3.1. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал (харьцуулсан судалгаа)	37
3.2. Хүнийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт хохирсон бага насны хүүхдийн хувийн байдал.....	47
3.3. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл.....	54

ДӨРӨВ. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛСАН БАЙДАЛ.....	78
4.1. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй ерөнхий байдал.....	78
4.2. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт ял оногдуулсан байдалд хийсэн түүвэр судалгаа /харьцуулсан судалгаа/	91
4.3. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулсан байдалд хийсэн түүвэр судалгаа /харьцуулсан судалгаа/	138
ТАВ. ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧИДТЭЙ ХИЙСЭН ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН.....	187
5.1. Шүүгчидтэй хийсэн фокус ярилцлагын үр дүн.....	187
5.2. Прокуроруудтай хийсэн фокус ярилцлагын үр дүн.....	188
5.3. Мөрдөгчидтэй хийсэн фокус ярилцлагын үр дүн.....	189
ДҮГНЭЛТ.....	191
ЗӨВЛӨМЖ.....	194
НОМ ЗҮЙ.....	199

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 2.1	Хүнийг алах гэмт хэргийн түвшин (2009-2019)	22
График 2.2	Хүнийг алах гэмт хэрэгт холбогдсон хүний нас, хүйс	24
График 2.3	Хүнийг алах гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдал	24
График 2.4	Хүчиндэх гэмт хэргийн түвшин (2009-2019)	29
График 2.5	Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс	30
График 2.6	Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал	30
График 3.1	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний иргэний харьяалал	38
График 3.2	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний иргэний харьяалал	38
График 3.3	Гэмт хэрэгт холбогдогчдын нас	38
График 3.4	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт холбогдогчдын нас	39
График 3.5	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүйсийн харьцаа	40
График 3.6	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүйсийн харьцаа	40
График 3.7	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний төрсөн газар	41
График 3.8	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний төрсөн газар	41
График 3.9	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин	42
График 3.10	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин	42
График 3.11	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчийн гэр бүлийн байдал	44
График 3.12	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгчийн гэр бүлийн байдал	44
График 3.13	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүн урьд ял эдэлж байсан байдал	45
График 3.14	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүн урьд ял эдэлж байсан байдал	45
График 3.15	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын насны байдал	47
График 3.16	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын боловсролын байдал	48
График 3.17	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч айлын хэд дэх хүүхэд эсэх	48
График 3.18	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ямар хамааралтай болох	49
График 3.19	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч цэцэрлэг, сургуульд хамрагддаг эсэх	50
График 3.20	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч бие махбод, сэтгэцийн хувьд өвчтэй байсан эсэх	50
График 3.21	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогчийн нас	51
График 3.22	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогчдын боловсролын байдал	52

График 3.23	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч айлын хэд дэх хүүхэд эсэх	52
График 3.24	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэг үйлдсэн хүний хоорондын хамаарал	52
График 3.25	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч цэцэрлэг, сургуульд хамрагддаг эсэх	53
График 3.26	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч бие махбод, сэтгэцийн хувьд өвчтэй байсан эсэх	53
График 3.27	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газар.....	54
График 3.28	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байршил.....	55
График 3.29	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газар.....	56
График 3.30	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн цаг	57
График 3.31	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн улирал	57
График 3.32	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн гариг	58
График 3.33	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн үйлдлийн арга	59
График 3.34	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн давтамж	60
График 3.35	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэж удааширсан хугацаа	61
График 3.36	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт хамтран оролцогч	61
График 3.37	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйл.....	62
График 3.38	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг улмаас учирсан хор уршиг	63
График 3.39	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр (бүсээр).....	64
График 3.40	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн газар	64
График 3.41	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн газар (нарийвчилсан).....	65
График 3.42	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн цаг	66
График 3.43	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн улирал	66
График 3.44	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн гариг	67
График 3.45	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн үйлдлийн арга	68
График 3.46	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал	69
График 3.47	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн сэдэлт	70
График 3.48	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд.....	70
График 3.49	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж удааширсан хугацаа.....	71
График 3.50	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт хамтран оролцсон байдал	72
График 3.51	Гэмт хэрэг үйлдэхдээ зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашигласан эсэх..	72
График 3.52	Хохирогч нас барсан хугацаа.....	73
График 4.1	Бага насны хүүхдийг хүчиндэх гэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн хугацаа	78
График 4.2	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл...	79
График 4.3	Хорих ял оногдуулсан хугацаа	80
График 4.4	Хамтран оролцогчид ял оногдуулсан эсэх	81
График 4.5	Цагдан хоригдсон хугацаа.....	81
График 4.6	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн хөнгөрүүлэх нөхцөл байдал.....	82
График 4.7	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн хүндрүүлэх нөхцөл байдал	83

График 4.8	Хохирол нөхөн төлсөн байдал, хувиар	84
График 4.9	Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн хугацаа	85
График 4.10	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл	85
График 4.11	Хорих ял оногдуулсан хугацаа	86
График 4.12	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт хамтран оролцогчид ял оногдуулсан эсэх	87
График 4.13	Цагдан хоригдсон хугацаа	87
График 4.14	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн ял хөнгөрүүлэх нөхцөл байдал	88
График 4.15	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн ял хүндрүүлэх нөхцөл байдал	88

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1	Хүнийг алах гэмт хэргийн гаралт.....	23
Хүснэгт 2.2	Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирсон хүн.....	24
Хүснэгт 2.3	Хүнийг алах гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт	27
Хүснэгт 2.4	Хүчиндэх гэмт хэргийн гаралт	29
Хүснэгт 2.5	Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүн	31
Хүснэгт 2.6	Хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт	33
Хүснэгт 4.1	Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт ял оногдуулсан байдалд хийсэн түүвэр судалгаа	91
Хүснэгт 4.2	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулсан байдалд хийсэн түүвэр судалгаа	129

НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

- **Бага насны хүүхэд** гэж 14 насанд хүрээгүй хүнийг ойлгоно.¹
- **Өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор алсан** гэж өөрийн болон бусдын үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж байгаа гэмт хэргийг гэрчлэх буюу эрх бүхий байгууллагад мэдээлж болзошгүй, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд учирч болох саадыг арилгах, төгс үйлдэхэд шаардлагатай нөхцөл бүрдүүлэх зэрэг шалтгаанаар хүнийг алсныг ойлгоно.
- **Хоёр, түүнээс олон хүнийг алсан** гэж гэмт этгээд хоёр, түүнээс олон хүнийг алах гэсэн нэгдмэл санаа зорилгоо нэг цаг хугацаанд, эсхүл тодорхой цаг хугацааны дараа хэрэгжүүлсэн байхыг ойлгоно.
- **Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, эсхүл бага насны хүүхэд, эсхүл жирэмсэн болохыг мэдсээр байж алсан** гэж гэмт этгээд хохирогчийг бие махбодын болон сэтгэцийн хувьд өөрийгөө хамгаалах, түүнчлэн гэмт этгээдэд идэвхтэй эсэргүүцэл үзүүлж чадахгүй болохыг ухамсарлан ойлгож, 14 насанд хүрээгүй хүнийг, хохирогчийг жирэмсэн болохыг түүний гадаад төрх байдал, хоорондын харилцаа, бусад эх сурвалжаас мэдсээр байж алсныг ойлгоно.
- **Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн** гэдэгт гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүс² хамаарна.
- **Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан** гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн улмаас гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг алсныг ойлгоно. Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй.
- **Бэлгийн эрх чөлөө** гэж бэлгийн хамтрагчаа чөлөөтэй сонгох боломж юм.³
- **Бэлгийн халдашгүй байдал** гэж хүний хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлээс ангид байх явдал юм.⁴
- **Хүчиндэх** гэж бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа

¹ Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг

² Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйлийн тайлбар

³ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018. 66 дахь тал

⁴ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018. 66 дахь тал

нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах аргаар бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийхийг хэлнэ.

- **Бэлгийн харьцаа** гэж бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хийж буй бэлгийн харьцааны шинжтэй үйлдлийг ойлгоно.
- **Бэлгийн харьцаанд орох** хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бэлэг эрхтнээ оруулахыг ойлгоно.
- **Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл** гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулах; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулахыг ойлгоно.⁵
- **Биеэ үнэлэх** гэж төлбөртэйгөөр бусадтай бэлгийн харьцаанд орохыг хэлнэ.
- **Бэлгийн замын халдварт өвчин** гэж бэлгийн замаар нэг хүнээс нөгөөд дамжих халдвар юм.
- **Жирэмслэлт** гэж эмэгтэйн умайд үр тогтож, үр хөврөл, ураг бүрэлдэх үйл явцыг хэлнэ.

⁵ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны тоон мэдээллээс үзэхэд гэмт хэргийн улмаас 127 хүүхэд нас барж, 745 хүүхэд гэмтэж, 187 хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болжээ.⁶ Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага болох “Хүүхдийг ивээх сан”-гаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүүхдийн эрх чөлөөний төлөв байдал” судалгаагаар 2018 онд Монгол Улс 100,000 хүн амд 1.4 хүүхдийн амь нас хохирсон үзүүлэлтээр 176 орноос 76-д орсон байна.⁷ Уг судалгаагаар гэмт хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирч буй нөхцөл байдалд үндэслэн тухайн улс дахь хүүхдийн аюулгүй байдлын түвшнийг тодорхойлдог.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргийн нөхцөл байдал нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлтэй холбоотой бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогод эдгээр хүчин зүйлийг мөн харгалзан үзэх нь зүйтэй. Монгол Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийг 2002, 2015 онд шинэчлэн найруулж, 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр хуульд хүүхдийн эрх ашгийг хамгаалах, ялангуяа бага насны хүүхдийг алах болон хүчиндэх үйлдлийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт тооцож, оногдуулах ялын төрөл, хэмжээг тогтоож ирсэн. УИХ-ын Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороодын хамтран зохион байгуулсан “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал” сэдэвт Ерөнхий хяналтын сонголд оролцогчид 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, ялангуяа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялын бодлого сул, ижил төрлийн гэмт хэрэгт ялыг ялгамжтай оногдуулж байгаа

⁶ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. УБ., 2018. 112 дахь тал

⁷ Global childhood report 2019- Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report

талаар албаны хүмүүс шүүмжилж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг сануулсан.⁸

Иймд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээнд дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны хүрээнд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, оногдуулж буй ялын байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр санал, зөвлөмж боловсруулахыг зорилго.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиглав. Үүнд:

1. Монгол Улс дахь хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
2. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогыг шинжлэх;
3. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох;
4. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох зорилгоор мөрдөгчидтэй фокус ярилцлага хийж, дүгнэлт гаргах;
5. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг шинжлэн судлах;
6. Дээрх судалгаа, шинжилгээний үр дүнг нэгтгэн, санал, зөвлөмж бүхий тайлан боловсруулах зэрэг болно.

⁸ УИХ-ын Хууль зүйн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо хамтран “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал” Ерөнхий хяналтын сонсгол, УБ., 2019.05.29, Төрийн ордон

1.3. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Сүүлийн жилүүдэд хүүхдийн эсрэг бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн талаар хэд хэдэн судалгааны ажил хийгдсэн. Тухайлбал, 2017 онд Хөгжлийн академи төрийн бус байгууллагаас хийсэн “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ”, 2019 онд Монголын эмэгтэйчүүдийн сан, Дотоод хэргийн их сургууль, Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллагаас хийсэн “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс”, 2019 онд Улсын Ерөнхий Прокурорын газраас хийсэн “Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” судалгааны ажлыг тус тус дурдаж болно.

Дээрх судалгаанууд нь зөвхөн хүүхдийг хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, энэ төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналт, шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдсан асуудлыг судалж дүгнэлт, санал боловсруулжээ.

Бидний судалгааны ажил нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн хамгийн ноцтой хэлбэр болох бага насны хүүхдийг санаатай алах тохиолдлыг анх удаа хүчиндэх гэмт хэрэгтэй хамтатган судалснаараа онцлог бөгөөд бага насны буюу 14 насанд хүрээгүй хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, оногдуулсан ялын бодлого, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон эсэхэд дүн шинжилгээ хийснээрээ шинэлэг юм.

1.4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны арга: Судалгааны хүрээнд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг шүүхээс таслан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор шүүхийн шийтгэх тогтоол, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, статистикийн баримтад дүгнэлт хийх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх,

харьцуулалт хийх, санал асуулга, ярилцлага хийх зэрэг аргыг ашигласан.

Судалгаанд ашигласан мэдээлэл: Хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн ерөнхий нөхцөл байдал, түүнд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн бүтэц, түвшин, хөдөлгөөнд дүн шинжилгээ хийх зорилгоор Цагдаагийн ерөнхий газраас эрхлэн гаргадаг “Монгол Улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал (2014-2018)”, “Шүүн таслах ажиллагааны тайлан (2014-2018)”, Монголын криминологичдын холбооноос эрхлэн гаргадаг “Гэмт хэргийн цагаан ном-2016, 2017”, Монгол Улс дахь нөхцөл байдлыг олон улсын түвшинтэй харьцуулах зорилгоор “Save the Children Annual Report” буюу “Хүүхдийг ивээх сан” олон улсын байгууллагын сүүлийн таван жилийн тайланд тусгагдсан тоон мэдээлэл зэргийг ашиглан дүн шинжилгээ хийлээ. Мөн ялын бодлого, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хийсэн дүгнэлт нь шүүхээс шийдвэрлэгдсэн 108 хавтаст хэргийн мэдээлэлд тулгуурласан болно.

Түгэвэрлэлтийн хэмжээ: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дахь хэсэг (2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.15 дахь хэсэг), Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт (2002 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэг) заасан хэргүүдийг хамааруулан бага насны хүүхдийг алсан 40, бага насны хүүхдийг хүчиндсэн 68, нийт 108 шийтгэх тогтоолыг түүвэрлэн авсан. Түүвэрлэлтэд хамрагдсан хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бага насны хүүхэд байх шалгуурыг тавьсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд “бага насны хүүхэд” гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно”⁹ гэсэн тодорхойлолтыг удирдлага болгов. Энэ төрлийн гэмт хэрэг нь хүнийг алах болон хүчиндэх нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин бага бөгөөд ихэвчлэн онц харгис хэрцгий аргаар, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор үйлдэгддэг санаатай гэмт хэрэг тул нийгмийн хор аюул ихтэйд тооцогддог.

⁹ Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, оногдуулсан ялын үндэслэлийг тодруулах зорилгоор хийсэн фокус ярилцлагын судалгаанд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтсийн 11 мөрдөгч, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын 6 прокурор, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 9 шүүгчийг түүвэрлэн ярилцлага хийсэн. Түүвэрлэлтэд хамрагдсан мөрдөгч, прокурор, шүүгчдийг сонгохдоо бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэж байсан туршлага, ажилласан жилийг харгалзав.

Судалгааны ажлын загвар ба мэдээлэл боловсруулалт: Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн тойм судалгаа хийхдээ шүүхийн шийтгэх тогтоолын агуулгад нийцүүлэн “Гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал”, “Гэмт хэргийн хохирогч хүүхдийн хувийн байдал”, “Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл”, “Гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээ” гэсэн 4 бүлэг 53 асуулт бүхий тусгайлан боловсруулсан загварчлалын дагуу мэдээлэл цуглуулж, үр дүнг SPSS 21 судалгаа боловсруулалтын программ ашиглан дүн шинжилгээ хийж, үр дүнг тайлбарлалаа.

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлогын өөрчлөлт, төсөөтэй нөхцөл байдалд үйлдэгдсэн гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг харьцуулан дүн шинжилгээ хийхдээ үйлдлийн арга, гэмт хэргийн сэдэлт, зорилго зэргийг харгалзан хүнийг алах гэмт хэргийн 17, хүчиндэх гэмт хэргийн 22 онцлог тохиолдлыг түүвэрлэн авч 2002, 2015 оны Эрүүгийн хуулиар ял оногдуулсан байдалд судалгаа хийсэн. Мөн шүүгч, прокурор, мөрдөгчдийн дунд фокус бүлгийн ярилцлагыг урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу явуулж үр дүнг нэгтгэсэн.

Судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэсэн болно.

Судалгааны баг: Судалгааны ажлыг Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн профессор багш нараас бүрдсэн баг

2019 оны 5 дугаар сарын 10-наас 2019 оны 8 дугаар сарын 12 хүртэл нийт гурван сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

Судалгааны ажлыг хууль зүйн доктор (Ph.D) Б.Энхболд удирдаж, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор С.Гантулга, хууль зүйн магистр Б.Мөнхзул нар хамтран ажиллалаа.

ХОЁР. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА

Хүүхдийн эрхийн зөрчлийн ноцтой хэлбэр нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл юм. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр эрх бүхий байгууллагаас хэд хэдэн хууль, эрх зүйн баримт бичиг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Улсын Их Хурлаас 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай, 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталж, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан. Мөн Улсын Их Хурлаас 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтуудыг тус тус хуульчилсан.

Хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулах бодлого хэрэгжүүлснээр манай улс хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон дэлхийн 49 дэх орон болсон.¹⁰ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд болон эдгээрийг дагаж гарсан журмуудаар хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо болон хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хариу

¹⁰ Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт

үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. Мөн 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг, зөрчилд тус тус тооцсон.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхэд бүрийн эрүүл, аюулгүй орчинд өсөж хүмүүжих, хөгжих, сурч боловсрох, үзэл бодлоо илэрхийлэх, нийгмийн амьдралд оролцох, хамгаалагдах үндсэн эрхийг хангахад чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг 32 гишүүн, 4 дэмжигч гишүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалттайгаар хэрэгжүүлэх салбар дундын байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 218 дугаар тушаалаар байгуулсан. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 4 дүгээр тогтоолоор Хүүхдийн төлөө үндэсний газрыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болгон шинэчлэн зохион байгуулж улсын хэмжээнд нийслэл, 21 аймагт Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 9 дүүрэг тус бүрт хэлтэс байгуулагдсан нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалахад чухал алхам болжээ.

Мөн улсын хэмжээнд 12 аймаг, нийслэлийн Хан-Уул, Баянгол дүүргүүдэд түр хамгаалах байр ажиллаж, 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эдгээр байруудад нийт 889 хүүхэд хүлээн авч үйлчилсэн байна. Үүнээс Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоолоор байгуулсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр” 0-18 хүртэлх насны 675 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлжээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг Монгол

Улсын Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор байгуулж, сард дунджаар 10 мянга гаруй дуудлага хүлээн авч, хүүхэд өсвөр үеийнхэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, хүүхэд хамгааллын шуурхай тусламж үзүүлж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, салбарын хүний нөөцийг чадваржуулах чиг үүрэгтэй “Сургалт, судалгаа, мэдээллийн төв”-ийг байгуулан төрийн бүх шатны байгууллага, эцэг эхчүүд, олон нийтэд чиглэсэн хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн боловсрол олгох сургалт, “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлье” аян, “Эцэг эхийн зөвлөгөөн”-ийг үндэсний хэмжээнд зохион байгуулжээ.

Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн байцаагчийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж, сургалтад хамруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/181 дүгээр тушаалаар 32 албан хаагчид хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгожээ.

Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/476 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого” боловсруулжээ. Энэ ажлын хүрээнд сургуулийн орчин дахь үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл, орчны аюулгүй байдлыг дээшлүүлэх, багш, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс хүүхэдтэй зүй бус харьцсан зэрэг асуудалд дүн шинжилгээ хийх зорилгоор хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийг тогтмол ажиллуулж, мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд “Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлого, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм”-ийг тус тус баталсан байна. Түүнчлэн, “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын

үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”-ын хэрэгжилтийг хангахад анхаарал хандуулан ажиллаж байгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад чиглэгдсэн онцлог ажил гэж үзэж болно.

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газраас гаргасан судалгаанаас үзвэл 2018-2019 онд хүүхдийн эрхийн тухай, хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе” үндэсний аян өрнүүлж 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулсан 75 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 200 гаруй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага оролцож нийт 53650 эцэг эх, 3500 хүүхэд энэхүү аянд нэгдсэн байна. Аяны хүрээнд 855 удаагийн сургалт зохион байгуулж, 1628 сургагч багш бэлтгэж, 8240 боловсролын байгууллагын ажилтан, 53650 эцэг, эхэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, нөлөөлөл сурталчилгааны ажлыг тогтмолжуулжээ.¹¹ Мөн хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангахад ахмад настны оролцоог хангаж, 194 хүүхэд хамгаалагчийг нийслэлийн 152 хороо, 21 аймагт ажиллуулж “Хүүхэд хамгаалагч” төслийг Цагдаагийн ерөнхий газартай хамтран үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн нь төрөөс хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр олон талт арга хэмжээ явуулж байгааг харуулж байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 60 дугаар зарлигаар 2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарлаж, хүүхдийн эрхийг хүндэтгэх, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлд идэвх санаачилга гаргаж ажиллахыг ард иргэддээ уриалахын зэрэгцээ Монгол Улсын Засгийн газарт 9 чиглэл хүргүүлсэн нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх агуулгыг илэрхийлсэн байна. Үүнд:

¹¹ С.Тунгалагтамир. “Төрөөс хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлууд” Хүүхэд хөгжлийн орчин үеийн асуудлууд, Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018, 20 дахь тал

1. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, харилцан уялдаатай хэрэгжүүлэх;
2. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр болон Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажиллах;
3. Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс сэргийлэх, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах, эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх;
4. Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг дэмжих;
5. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, аймаг, дүүргийн өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлж байгаа хүүхдүүдэд сэтгэл зүйн болон бусад шаардлагатай зөвлөгөө, туслалцааг үзүүлж хэвших;
6. Хүүхдийг цахим орчны халдлагаас хамгаалах тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж, хэрэгжилтийг сайжруулах, энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
7. Хар тамхи, мансууруулах бодисоор өсвөр, залуу үеийг хордуулж байгаа нөхцөл байдлыг судлан шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
8. Хүүхдийн хүмүүжил, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх, гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах, үндэсний хэмжээнд гарч байгаа хүүхдийн хөгжил, хамгааллын бүх төрлийн хөтөлбөр (контент)-ийн агуулга, чанарыг сайжруулах;
9. Нийгмийн ажилтны (гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллага зэрэг бүх салбарт ажиллаж байгаа)


албан тушаалын тодорхойлолтыг хүүхэд хамгааллын чиглэлээр хүлээх үүрэгтэй нь уялдуулан шинэчилж, нэгдсэн арга зүй, хариуцлагын зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

Төрөөс хүүхдийн хөгжил, хамгааллын талаар хууль, эрх зүйн орчныг тодорхой хэмжээгээр бүрдүүлэн, арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурахгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

2.2. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЯЛЫН БОДЛОГО

Нэг. Хүнийг алах гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогын өөрчлөлт

График 2.1 Хүнийг алах гэмт хэргийн түвшин (2009-2019), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд¹² дунджаар 212, сард 18 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.¹³ Үүнээс 2018 онд хүнийг алах гэмт хэрэг улсын хэмжээнд 192 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3 хэргээр буюу 1.6 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 8 хэргээр буюу 6.8 хувиар буурч, орон нутгийн хэмжээнд 11 хэргээр буюу 15.5 хувиар өссөн байна.

¹² 2009-2018 он

¹³ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 169 дэх тал

Хүснэгт 2.1 Хүнийг алах гэмт хэргийн гаралт (нутаг дэвсгэр, хүний тоогоор)

	Хэргийн тоо		Өсөлт, бууралт (хувиар)	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2017	2018		2017	2018
Орон нутагт	71	82	15.5	37.6	42.7
Нийслэлд	118	110	-6.8	62.4	57.3

Орон нутгаас Сэлэнгэ (10), Дорнод (9), Орхон (8), Өмнөговь (6), Хөвсгөл (5), Сүхбаатар (5), Төв (5) аймгуудад хүнийг алах гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Увс (1), Хэнтий (2), Дорноговь (2), Баян-Өлгий (2), Завхан (2), Өвөрхангай (2), Баянхонгор (2), Говь-Алтай (2), Завхан (2), Говьсүмбэр (2) аймгуудад хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Нийслэлийн дүүргүүдээс Сонгинохайрхан (30), Баянзүрх (22), Чингэлтэй (19) дүүргүүдэд хүнийг алах гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Багануур (1), Налайх (4), Хан-Уул (6) дүүргүүдэд цөөн гэмт хэрэг бүртгэгджээ.

Хүнийг алах гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйсийн байдал

2018 онд хүнийг алах гэмт хэрэгт 201 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 буюу 2.6 хувиар өссөн байна. Холбогдогчдын 22 буюу 11 хувь нь эмэгтэй, 179 буюу 89 хувь нь эрэгтэй, тэдний 1 буюу 0.5 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 4.7 хувиар өсөж, эмэгтэй 12, хүүхэд 85.7 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм.

График 2.2 Хүнийг алах гэмт хэрэгт холбогдсон хүний нас, хүйс, тоогоор




График 2.3 Хүнийг алах гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдал, тоогоор



Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирогчдын статистик үзүүлэлт

2018 онд хүнийг алах гэмт хэргийн улмаас 196 хүн хохирч, үүнээс 168 нь нас барж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барса хүний тоо 1 буюу 0.6 хувиар буурсан байна.¹⁴

Хүснэгт 2.2 Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирсон хүн, тоогоор

№	Үзүүлэлт	Он				Өсөлт, бууралт ¹⁵		Хугацаа		Өсөлт, бууралт	
		2015	2016	2017	2018	Хүний тоо	Хувь	2018 оны эхний 4 сар	2019 оны эхний 4 сар	Хүний тоо	Хувь
1	Хүнийг алах гэмт хэрэг	204	174	189	192	3	1.6	58	73	15	25.9
2	Хүнийг алах гэмт хэргийн хохирогч	214	184	191	196	5	2.6	58	74	16	27.6

¹⁴ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 171 дэх тал

¹⁵ Сүүлийн 2 жилийн байдлаар

3	Хүүхэд хохирсон хүнийг алах гэмт хэрэг	7	2	8	3	-5	-62.5	0	1	1	100
4	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/	9	2	9	3	-6	-66.7	-	1	1	100
5	Үүнээс	0-7 нас	5	1	7	3	-4	-57.1	-	-	-
6		8-13 нас	2	-	1	-	-1	-100.0	-	-	-
7		14-17 нас	2	1	1	-	-1	-100.0	-	1	1

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Сүүлийн 4 жилд хүнийг алах гэмт хэргийн халдлагад 785 хүн өртөж, хохирогчдын 92 хувь нь нас барсан байна. Хүнийг алах гэмт хэрэг болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо сүүлийн 3 жил тогтвортой өсөж, хохирогчдын олонх энэ төрлийн гэмт хэргийн улмаас нас барж, эрүүл мэндэд нь хүнд хохирол учирчээ. Энэ гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх боломжгүй буюу хүний амьд явах эрх зөрчигддөг тул нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт тооцогддог. Энэ ч үүднээс дэлхийн улс бүр эрүүгийн хууль тогтоомждоо хүнийг алах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, энэхүү гэмт үйлдэлтэй ялын хатуу чанга бодлогоор тэмцдэг.

Сүүлийн жилүүдэд хүнийг алах гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2015 онд 7 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2016 онд 2 гэмт хэрэгт 2 хүүхэд, 2017 онд 8 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2018 онд 3 гэмт хэрэгт 3 хүүхэд, 2019 оны эхний 4 сарын байдлаар 1 гэмт хэрэгт 1 хүүхэд тус тус хохирсон байна. **Үүнээс 2015 онд 7, 2016 онд 1, 2017 онд 8, 2018 онд 3 бага насны хүүхэд хохирч, нас баржээ.**

Гэмт этгээдүүд ихэвчлэн бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж амь насыг нь хөнөөжээ.

Гэмт этгээдүүдийн дийлэнх нь хохирогчтой гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байгаа бөгөөд удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд байлган, тарчлаасны эцэст амь насыг хөнөөсөн нь анхаарал татаж байна. Мөн хүчиндэх болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө баллах зорилгоор хохирогч бага насны хүүхдийг алсан тохиолдол цөөнгүй бүртгэгджээ. Тухайлбал, Шүүгдэгч П.Т 2009 оны 8 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө Булган аймгийн Тэшиг сумын ... дугаар багийн нутаг ... гэх газар 13 настай Ц.М-ийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан заазуур болон гараараа зодож, толгой, нүүр, гар, хөлд нь олон тооны шарх, цус хуралт үүсгэж, онц харгис хэрцгий аргаар өвтгөн шаналгаж, зовоон тарчлааж хүчиндсэн, хүчиндэх гэмт хэргээ нуун далдлах зорилгоор хохирогчийг нуурын усанд живүүлж алсан¹⁶ (Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг түүвэр судалгаа №4).

Учирсан хохирол

Хүнийг алах гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 948.1 сая төгрөгийн хохирлын 78.3 хувийг нөхөн төлүүлж, 533.1 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохиролд хохирогчийн оршуулга, эмчилгээ, өмгөөллийн зардал, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн унааны зардал зэрэг материаллаг зардлыг шүүхээс нотлох баримтыг үндэслэн шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж байна.

Шүүхээс хянан шийдвэрлэсэн бүхий л гэмт хэргээс үзэхэд, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид шүүгдэгчээс сэтгэл санааны хохиролд 5-100 сая төгрөгийг нэхэмжилсэн боловч шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангалгүйгээр, гэм хорын хохирлыг иргэний журмаар шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхтэй болохыг шийтгэх тогтоолдоо дурдсан байна.

¹⁶ Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2010 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 84 дүгээр шийтгэх тогтоол

Хүснэгт 2.3 Хүнийг алах гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт

2002 оны Эрүүгийн хууль				2015 оны Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/				Ялын бодлогын өөрчлөлт	
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
91.1	Онц хүнд гэмт хэрэг	10 жил хорих ял	15 жил хорих ял	10.1 (1)	Хүнд гэмт хэрэг	8 жил хорих ял	15 жил хорих ял	-2	Үгүй
91.2	Онц хүнд гэмт хэрэг	15 жил хорих ял	25 жил хорих ял, цаазаар авах ял	10.1 (2)	Хүнд гэмт хэрэг	12 жил хорих ял	20 жил хорих ял, бүх насаар хорих	-3	-5 Цаазаар авах ялыг хасаж, бүх насаар хорих ял нэмсэн.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жилээр багасгасан, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой¹⁷ холбоотойгоор цаазаар авах ялыг халж, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг хуульчилсан. Ингэж хорих ялын хэмжээг урьд байгаагүйгээр зөөлрүүлсэн нь гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу чанга нь бус гарцаагүй байх нь чухал байхтай холбоотой бөгөөд шийтгэлгүй өнгөрөх болов уу гэсэн найдлага дагуулсан хатуу ялаар шийтгэгдэх айдсаас хөнгөн боловч гарцаагүй шийтгүүлнэ гэсэн мэдрэмж илүү нөлөөтэй гэсэн онол, олон улсын хандлагад нийцүүлсэн явдал юм.¹⁸

Практикт гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг тогтооход ихээхэн бэрхшээл тулгардаг. Гэмт хэрэг үйлдсэн хүний субъектив талд төдийлөн анхаарал хандуулалгүйгээр

¹⁷ 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.


¹⁸ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн хуулийн эмгэгийг эмчлэх нь. Үндэсний шуудан сонин 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн №008(2705). 14 дэх тал

гэмт үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учирсан хор уршигт анхаарах болсон олон улсын жишгийг харгалзан 2002 оны Эрүүгийн хуульд хүнийг танхайн, өс хонзонгийн сэдлээр алсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан байсныг 2015 оны Эрүүгийн хуульд хассан. Мөн хүнийг алах гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, давтан үйлдсэн бол хүндрүүлж үзэхээр заасныг хассан бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, эрүүдэн шүүж, бага насны хүүхдийг алсан; зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааныхаа явцад; үзэл бодол, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр хуульчилсан.

Судалгаанаас үзэхэд хүүхэд, ялангуяа биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд хүнийг алах гэмт хэргийн халдлагад өртөх явдал түгээмэл байна. Хүнийг алах гэмт хэргийн хохирогч хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл 1-10 насны хүүхэд дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алсан тохиолдлыг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан явдал нь цаг үеэ олсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн чухал алхам болсон гэж үзэж болохоор байгаа юм.

Хоёр. Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогын өөрчлөлт

График 2.4 Хүчиндэх гэмт хэргийн түвшин (2009-2019), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд¹⁹ дунджаар 345, сард 29, хоногт 1 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.²⁰ Үүнээс 2018 онд хүчиндэх гэмт хэрэг улсын хэмжээнд 519 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 143 хэргээр буюу 38 хувиар өсжээ. Нийслэлийн хэмжээнд 75 хэргээр буюу 38.6 хувиар, орон нутгийн хэмжээнд 67 хэргээр буюу 37 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2.4 Хүчиндэх гэмт хэргийн гаралт (нутаг дэвсгэрээр, хүний тоогоор)

	Хэргийн тоо		Өсөлт, бууралт (хувиар)	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2017	2018		2017	2018
Орон нутагт	182	249	36.8	48.4	48.0
Нийслэлд	194	269	38.7	51.6	51.8
Бусад		1			0.2

¹⁹ 2009-2018 он

²⁰ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 176 дахь тал

Орон нутгаас Орхон (22), Хөвсгөл (20), Сэлэнгэ (18), Дорноговь (18), Хэнтий (17), Баянхонгор (17), Дорнод (16), Төв (16) аймгуудад үчиндэх гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Говь-Алтай (2), Завхан (2), Говьсүмбэр (3), Дундговь (4), Булган (5) аймгуудад хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийслэлийн дүүргүүдээс Сонгинохайрхан (69), Баянзүрх (77), Баянгол (43) дүүргүүдэд хүчиндэх гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Налайх (4), Багануур (8) Хан-Уул (17) дүүргүүдэд цөөн гэмт хэрэг бүртгэгджээ.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн байдал

2018 онд 338 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 буюу 11.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Холбогдогчдын 3 буюу 0.9 хувь нь эмэгтэй, 335 буюу 99.1 хувь нь эрэгтэй, тэдний 24 буюу 7.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс хэрэгт холбогдсон эрэгтэй 10.9 хувиар, эмэгтэй 50.5 хувиар тус тус өсөж, хүүхэд 20 хувиар буурсан байна.

График 2.5 Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, тоогоор




График 2.6 Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал, тоогоор



Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогсдын статистик үзүүлэлт

2018 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 487 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 119 буюу 32.3 хувиар өссөн байна. Үүнээс 2 хүн нас барж, 89 хүний эрүүл мэндэд хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 1 буюу 2 дахин өсөж, эрүүл мэндэд хохирол учирсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Хүснэгт 2.5 Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүн, тоогоор

№	Үзүүлэлт	Хугацаа				Өсөлт, бууралт ²¹		Хугацаа		Өсөлт, бууралт		
		2015 он	2016 он	2017 он	2018 он	Тоо	Хувь	2018 оны эхний 4 сар	2019 оны эхний 4 сар	Тоо	Хувь	
1.	Хүчиндэх гэмт хэрэг	279	290	376	519	143	38.0	193	217	24	12.4	
2.	Хүчиндэх гэмт хэргийн хохирогч	287	295	368	487	119	32.3	178	210	32	18.0	
3.	Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг	134	140	183	235	52	28.4	75	110	35	46.7	
4.	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/	139	143	187	238	51	27.3	77	112	35	45.5	
5.	Үүнээс	0-7 нас	7	18	20	20	0	0.0	6	9	3	50.0
6.		8-13 нас	47	45	59	91	32	54.2	26	39	13	50.0
7.		14-17 нас	85	80	108	127	19	17.6	45	64	19	42.2

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл амьдрахын халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг

²¹ Сүүлийн 2 жилийн байдлаар

нийгэмд хор аюул их учруулдаг гэмт хэрэг юм. Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1437 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсжээ. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал 2015 онд 134 гэмт хэрэгт 139, 2016 онд 140 гэмт хэрэгт 143, 2017 онд 183 гэмт хэрэгт 187, 2018 онд 235 гэмт хэрэгт 238, 2019 оны эхний 4 сарын байдлаар 110 гэмт хэрэгт 112 хүүхэд тус тус хохирчээ. Үүнээс 2015 онд 54, 2016 онд 63, 2017 онд 79, 2018 онд 111 бага насны хүүхэд хохирсон байна.

Гэмт этгээдүүд ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай бага насны хүүхдийг биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байгааг далимдуулан хүч хэрэглэн заналхийлэх аргаар хүчиндсэн байна. Эцэг, эхдээ болон бусдад хэлбэл ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна хэмээн заналхийлж, бага насны хүүхдийг хүчиндсэн байх бөгөөд хохирогч айж эмээсний улмаас гэмт этгээдийн үйлдлийг нууж өнгөрдөг нь дахин хүчиндүүлэх, цаашид удаан хугацаанд энэ гэмт хэргийн халдлагад өртөх нөхцөлийг бүрдүүлж байна (Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг түүвэр судалгаа №4, 9, 10).

Бага насны хүүхдийг хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн тохиолдол цөөнгүй хувийг эзэлж байна. Тухайлбал, судалсан хэргийн дийлэнх хувийг хохирогч хүчиндүүлсний улмаас жирэмсэн болсноор гэмт хэрэг илэрсэн байх бөгөөд хэрэв хохирогч жирэмсэн болоогүй бол тэр хэрэг илрэхгүй байх магадлал өндөр юм.

Бага насны хүүхдийг хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэлсэн тохиолдолд бүгд (100 хувь) үр хөндүүлсэн байгаа нь хохирогчийн цаашдын эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны хөгжилд асар хортой талаар мэргэжлийн эмч хэлдэг. Мөн хохирогчийг хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчин халдаасан тохиолдолд бага насны хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн хохиролтой бөгөөд хохирогч хүчиндүүлсний улмаас сэтгэцийн өвчтэй болсон, амиа хорлосон, амиа хорлохоор завдсан, хүчиндүүлснээс хойш бусадтай замбараагүй бэлгийн харьцаанд орсон явдал түгээмэл

байна. Тухайлбал, насанд хүрээгүй хохирогч Ц.Б нь хойд эцэг С.С-д 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд удаа дараа хүчиндүүлсэн. Хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтээ “...Намайг харж хамгаалах ёстой хүн С.С-д хүчиндүүлсэндээ гутарч, сэтгэл санаагаар унасандаа асрамжийн газрын галч А.С, харуул К.Х нартай бэлгийн харьцаанд орсон.” гэжээ.²²

Учирсан хохирол

Хүчиндэх гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 482.6 сая төгрөгийн хохирлын 66.1 хувийг нөхөн төлүүлж, 65.9 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ.

Хүснэгт 2.6 Хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт

2002 оны Эрүүгийн хууль				2015 оны Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/				Ялын бодлогын өөрчлөлт	
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
126.1	Хүндэвтэр гэмт хэрэг	1 жил хорих ял	5 жил хорих ял	12.1 (1)	Хөнгөн гэмт хэрэг	1 жил хорих ял	5 жил хорих ял	Үгүй.	Үгүй.
126.2	Хүнд гэмт хэрэг	5 жил хорих ял	10 жил хорих ял	12.1 (2)	Хүнд гэмт хэрэг	2 жил хорих ял	8 жил хорих ял	-3	-2
				12.1 (3)	Хүнд гэмт хэрэг	5 жил хорих ял	12 жил хорих ял	Үгүй.	2
126.3	Онц хүнд гэмт хэрэг	15 жил хорих ял	25 жил хорих ял, цаазаар авах ял	12.1 (4)	Хүнд гэмт хэрэг	12 жил хорих ял	20 жил хорих ял, бүх насаар хорих	-3	-5 Цаазаар авах ялыг хасаж, бүх насаар хорих ял нэмсэн.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод, дээд хэмжээг өөрчлөөгүй, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар

²² Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар шийтгэх тогтоол

үйлдсэн этгээдэд оногдуулах хорих ялын дээд хэмжээг 2 жилээр нэмэгдүүлсэн, хугацаатай хорих ялын хэмжээ багассантай холбоотойгоор онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар энэ гэмт хэргийг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, цаазаар авах ялыг халж, харин үүний оронд бүх насаар хорих ялыг хуульчилсан.

Дээрх нэмэлт өөрчлөлтөөс дүгнэхэд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээг бууруулж, цаазаар авах ялыг халсан нь 2002 оны эрүүгийн хуулийн ялын бодлогыг зөөлрүүлэх, нөгөө талаас Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой²³ холбоотой. Олон нийтийн сүлжээгээр 2015 оны Эрүүгийн хуульд хүүхэд хүчиндсэн хүнийг 2 сая төгрөгөөр торгох ял шийтгэхээр хуульчилсан гэсэн мэдээлэл түгээгдсэн. Энэ нь худал мэдээлэл бөгөөд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого төдийлөн зөөлрөөгүй, гэмт этгээдэд ял завших боломж огт олгоогүйн зэрэгцээ хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг өргөн хүрээнд хамгаалж, олон улсын жишгийг харгалзан энэ гэмт хэргийн объектив талын шинжийг тодорхойлж, үйлдлийн аргыг дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан. Тухайлбал, хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг хүчээр бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн гэж тодорхойлж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг, хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан²⁴ үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцсон. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл нь бэлгийн харьцаанд орох үйлдэлтэй адил хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халддаг, нийгмийн хор аюул нь их үйлдэл учраас хүчиндэх гэмт хэрэгт тооцсон нь хүний эрхийг хангахад чухал алхам болсон гэж үзэж байна. Эмэгтэй хүний бэлэг эрхтэнд хуруу, бусад зүйлийг хийсэн, ам, шулуун гэдсэнд бэлэг эрхтнээ оруулсан зэрэг хүний бэлгийн эрх

²³ 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

²⁴ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

чөлөө, халдашгүй байдалд бүдүүлгээр халддаг үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуулиар бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулдаг байсан бол шинэ Эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэрэгт тооцсон.²⁵

Мөн 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно²⁶ гэж хүйсийн ялгаваргүйгээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг Эрүүгийн хуулиар хамгаалсан нь ихээхэн ач холбогдолтой. Шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө эрэгтэй хүн (эрэгтэй хүүхэд)-ийг шулуун гэдсээр хүчиндсэн тохиолдолд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, гэмт этгээдэд хөнгөн ял оногдуулж, ял завшуулж байсан.

Судалгаанаас үзэхэд хүүхэд, ялангуяа биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийн халдлагад өртөх явдал түгээмэл ажиглагдав. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл 4-10 насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхэд хүчиндсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэрэглэсэн, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдсэн зэрэг субъектив талын шинжийг хангасан байхыг шаардахгүй.²⁷ Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн объектив талын шинжээр нь зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнөх хуультай харьцуулахад илүү нарийвчилсан, ялын бодлогын хувьд чангарсан зохицуулалт юм.

Энэ төрлийн гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр үйлдсэн тохиолдолд 2002 оны Эрүүгийн хуулиар хүндэвтэр, 2015 оны Эрүүгийн хуулиар хөнгөн ангиллын гэмт хэрэгт хамаарах тул шүүхээс хуульд заасан болзол, шалгуурыг хангасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх

²⁵ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн хуулийн ялын бодлогын өөрчлөлт. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ., 2017. №1 (62). 39 дэх тал

²⁶ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

²⁷ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар

боломжтой. Практикт түгээмэл үйлдэгдэж буй байдлыг харгалзан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн, хохирогчийг жирэмсэн болгосон, хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хоёр ба түүнээс олон хүнийг хүчиндсэн бол тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хуульд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгасны нэг илрэл нь урьд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол хүндрүүлэхээр хуульчилсан явдал юм. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэхээс бусад гэмт хэргийг давтан үйлдсэн тохиолдолд зүйлчлэлээр нь хүндрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулахгүй.

ГУРАВ. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮНИЙ ХУВИЙН БАЙДАЛ (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)


Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг тогтоох нь тухайн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход ач холбогдолтой. Иймээс судалгааны хүрээнд түүвэрлэн авсан 108 хэрэгт ял шийтгүүлсэн ялтны хүн ам зүйн шинжийг тодорхойлж, бага насны хүүхдийг хүчиндэх болон алах гэмт хэрэг үйлдсэн хүний нийтлэг шинжийг харьцуулан судаллаа.

Гэмт хэрэг үйлдсэн хүний иргэний харьяаллыг авч үзвэл Монгол Улсын иргэн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэж ял шийтгүүлсэн 68 тохиолдлын 66 буюу 97.1 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 40 тохиолдлын 38 буюу 95 хувь нь тус тус Монгол Улсын иргэн байна (График 3.1. 2-ыг харна уу).

График 3.1 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний иргэний харьяалал, хувиар




График 3.2 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний иргэний харьяалал, хувиар



Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн нийт 66 хүнийг насны байдлаар нь авч үзвэл 19-40 насныхан 75 хувийг эзэлж байна. Үүнээс хоёр нь 14-18 насныхан, харин 11 нь 41-50, дөрөв нь 51 ба түүнээс дээш насны хүмүүс байна (График 3.3-ыг харна уу).


График 3.3 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хувиар



Дээрх графикаас үзвэл, 19-40 насны хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг ихээр үйлдэж байгаа нь харагдаж байна. Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн хамгийн залуу нь 17 настай байгаа бол хамгийн ахмад нь 74 настай хүн байна.

Хүүхэд алах гэмт хэрэг үйлдсэн 40 хүний насны байдлыг авч үзэхэд мөн л 19-40 насныхан өндөр хувьтай (90) байв. 14-18 насны 1 хүн байгаа бол 51-ээс дээш насныхан байхгүй байна. Үүнээс үзвэл хүүхэд алах гэмт хэргийг 19-40 насны хүмүүс хамгийн их үйлдсэн байна. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгчдийн хамгийн ахмад нь 46 настай байгаа бол хамгийн залуу нь 16 настай байна (График 3.4).

График 3.4 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт холбогдогчдын нас, хувиар



Дээрх судалгаанаас дүгнэхэд 19-25 насныхан бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт 42.5 хувийг эзэлж байгаа бол бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хувьд 19-30 насныхан 50 орчим хувийг дангаараа эзэлж байгаа нь ихэвчлэн залуучууд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгааг харуулна. Энэ нь хувь хүний биеэ барих чадвар, зан төлөвийн байдалтай холбоотой байх талтай.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүйсийн харьцааг авч үзвэл хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 67 буюу 98.5 хувь эрэгтэй байгаа бол (График 3.5), хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 55 хувь нь эрэгтэй, 42.5 хувь эмэгтэй хүмүүс байна. (График 3.6)

График 3.5 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүйсийн харьцаа, хувиар





График 3.6 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүйсийн харьцаа, хувиар



Түүвэрт сонгогдсон хүчиндэх гэмт хэргүүдийн 54 орчим хувийг 2002 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэсэн байна. УИХ-аас 2002 онд баталсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлд хүчиндэх гэмт хэргийн хохирогчийг ямар хүйсийн хүн байхыг тодорхой зааж өгөөгүй, шүүхийн практикт энэ гэмт хэргийн хохирогч эмэгтэй хүн байна гэсэн агуулгаар ойлгож ирсэн. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно” гэж заасан. Гэсэн хэдий ч хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь эрэгтэй хүн байх тохиолдол маш бага хувийг эзэлж байна. Харин бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн этгээд эмэгтэй хүн байх тохиолдол харьцангуй өндөр байна.


Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнийг төрсөн газраар нь авч үзвэл, Улаанбаатар хотод 27.9 хувь (19 хүн), орон нутагт 64.7 хувь нь (44 хүн) төрсөн байх бөгөөд гадаад улсад төрсөн хүн байхгүй байна. (График 3.7).

Харин хүүхэд алсан гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тухайд 70 хувь нь хөдөө орон нутагт, 24 хувь нь Улаанбаатар хотод, 6 хувь нь гадаад улсад төржээ (График 3.7, 8).

График 3.7 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний төрсөн газар, хувиар




График 3.8 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний төрсөн газар, хувиар



Дээрх судалгаанаас харахад орон нутагт төрсөн, тэнд өссөн хүмүүс хүчиндэх болон хүн амины гэмт хэргийг үйлдэгчдийн 70 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Монголчууд нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор хөдөө, орон нутгийн хүмүүсийг уужуу сэтгэлтэй, холч ухаантай, ёс зүй, зан заншлын хэм хэмжээг эрхэмлэх чанараараа хотын хүмүүстэй харьцуулахад өндөр байдаг гэх таамаглал энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн хувьд үгүйсгэгдэж байна. Энэ нь боловсролын түвшин, түүний чанараас хамаарах магадлалтай.

Иймээс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн боловсролын түвшнийг авч үзсэн болно. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 64,6 хувь (44 хүн) нь огт боловсролгүй, бага болон бүрэн бус дунд боловсролтой хүмүүс байна. Харин 29,4 хувь (20 хүн) нь бүрэн дунд боловсролтой байгаа бол дээд боловсролтой нь 5,9 хувийг (4 хүн) эзэлж байна (График 3.9-ийг харна уу).


График 3.9 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин, хувиар



Дээрх графикаас харахад, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн дунд дээд боловсролтой хүн бага хувийг эзэлж байгаа бол бага болон бүрэн дунд боловсролтой насанд хүрсэн хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг их үйлдэж байгаа нь харагдаж байна.

Харин хүүхэд алах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг боловсролын түвшнээр нь авч үзэхэд 20 хувь (8 хүн) нь боловсролгүй, 7.5 хувь (3 хүн) нь бага боловсролтой, 25 хувь (10 хүн) нь бүрэн бус дунд боловсролтой, 47.5 хувь (19 хүн) нь бүрэн дунд боловсролтой хүмүүс тус тус үйлдсэн байна (График 3.10-ыг харна уу).

График 3.10 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин, хувиар



Графикаас харахад, гэмт хэрэг үйлдсэн хүний 25 хувь нь 8 дугаар анги төгссөн, 47.5 хувь нь 10 дугаар анги төгссөн хүмүүс байна. Бидний судалсан 40 тохиолдолд бага насны хүүхдийг алах гэмт хэргийг дээд боловсролтой хүн үйлдсэн тохиолдол байхгүй байгаа нь сонирхол татаж байна.

Боловсрол гэдэг нь шинжлэх ухааны мэдлэг чадвар, дадал, зан суртахууны үнэт зүйл, биеэ авч явах хэм хэмжээг нийгмийн гишүүдэд эзэмшүүлэх үүрэг бүхий сургалт, хүмүүжлийн бие даасан тогтолцоог хэлнэ.²⁸ Тиймээс боловсролын түвшин ба гэмт хэрэг үйлдэгчийн хамаарлын талаар олон тооны судалгааны ажил байдаг бөгөөд гэмт явдал судлаач Хасан Букер боловсрол эзэмших үйл явцаас хөндийрсөн, хамрагдаж чадаагүй хүн сэтгэлгээний хоцрогдол, зан суртахууны доголдолд орж, өөрийгөө хянах чадваргүй болох магадлал ихтэй гэж дүгнэсэн²⁹ нь бидний судалгааны дүгнэлттэй санал нийлэхээр үр дүн юм.

Гэмт хэрэг үйлдсэн хүний гэр бүлийн байдлыг авч үзэх нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход ач холбогдолтой. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 55.9 хувь (38 хүн) нь гэрлэсэн, 36.8 хувь (25 хүн) гэрлээгүй, 7.3 хувь нь бэлэвсэн гэсэн судалгаа гарчээ (График 3.11). Харин бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгчийн 55.0 хувь (22 хүн) нь гэр бүлтэй, 40.0 хувь (16 хүн) нь гэр бүлгүй, 5 хувь (2 хүн) нь бэлэвсэн хүмүүс байна (График 3.12).


²⁸ Lochner, L. (2011a), "Education Policy and Crime", in P. Cook, J. Ludwig and J. McCrary, eds., *Controlling Crime: Strategies and Tradeoffs*, University of Chicago Press, Chicago, 465–515

²⁹ Hasan Buker (2011). "Formation of self-control: Gottfredson and Hirschi's general theory of crime and beyond".16 (3): 265–276

График 3.11 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчийн гэр бүлийн байдал, хувиар



График 3.12 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгчийн гэр бүлийн байдал, хувиар



Дээрх графикаас харвал, гэр бүлтэй хүмүүс хүчиндэх болон хүүхдийг алах гэмт хэрэгт илүү холбогдож байна. Гэр бүлтэй хүн нийгэм, гэр бүлийн гишүүдийн өмнө хүлээсэн үүрэгтэй байдаг тул гэмт хэрэг үйлдэх магадлал багатай байдаг³⁰. Харин бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад насанд хүрсэн хүмүүсийн хяналтад байдаг онцлогтой. Тиймээс гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсээс энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх магадлал ихтэй.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн ял шийтгэл эдэлж байсан эсэхийг авч үзвэл, 16.2 хувь (11 хүн) нь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний 22.5 хувь нь ял шийтгэл эдэлж байсан байна (График 3. 13, 14).

³⁰ Ronald.L.Akers. Criminological theories. fifth edition Newyork, 2009, 130. page

График 3.13 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүн урьд ял эдэлж байсан байдал, хувиар





График 3.14 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүн урьд ял эдэлж байсан байдал, хувиар



Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 22.5 хувь, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 16.2 хувь урьд нь ял шийтгэгдэж байсан нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Урьд нь шийтгэгдсэн хэргийн төрлийг харахад хулгайлах, дээрэмдэх, бусдын эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг үйлдэж, 5-аас дээш жилийн хорих ялаар шийтгүүлж байсан нь анхаарал татаж байна. Түүнчлэн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 4.4 хувь (3 хүн) нь улсаас авсан гавьяа шагналтай, 85.3 хувь (58 хүн) гавьяа шагналгүй байна. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хувьд улсаас авсан гавьяа шагналтай хүн байхгүй байна. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, нийгэмд эзлэх байр суурь, насны байдлаас хамаарч байгааг харуулна. Тухайлбал, хүчиндэх гэмт хэргийн хувьд 40-өөс дээш насныхан холбогдсон тохиолдол цөөнгүй байгаа бол хүн алах гэмт хэргийн хувьд харьцангуй цөөн байна.

ДУГНЭЛТ

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдалд дүн шинжилгээ хийхэд дараах нийтлэг болон ялгаатай шинжтэй байна. Үүнд:

Нийтлэг шинж:

1. Иргэний харьяаллын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүний 95-аас дээш хувь нь Монгол Улсын иргэн;
2. Төрсөн болон өссөн, боловсрол эзэмшсэн нутаг дэвсгэрийг нь авч үзвэл 70 орчим хувь нь орон нутгийн иргэд байгаа бол Улаанбаатар хотын иргэд энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн тохиолдол харьцангуй цөөн;
3. Боловсролын байдлыг авч үзвэл гэмт хэрэг үйлдэгчдийн 90 хувь нь бүрэн дундаас доош, 53 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой байгаа бол дээд боловсролтой хүн энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдол маш бага хувийг эзэлж байна;
4. Гэр бүлтэй, эсхүл гэрлэсэн хүмүүс энэ төрлийн гэмт хэргүүдийг үйлдэх магадлал их байна;
5. Урьд ял шийтгэл эдэлж байсан хүмүүс дээрх хоёр төрлийн гэмт хэргийг үйлдэх тохиолдол 16 орчим хувь байна.

Ялгаатай шинж:

1. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 98 орчим хувийг эрэгтэй хүмүүс үйлдэж байгаа бол бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 45 хувийг эмэгтэй, 55 хувийг эрэгтэй хүмүүс үйлдэж байна.
2. Хүчиндэх гэмт хэргийн тухайд 19-30 насныхан нийт гэмт хэргийн 50 хувийг үйлдсэн бол бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 62.5 хувийг дээрх насныхан эзэлж байна. 51-74 насны хүмүүс бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдол цөөнгүй байгаа бол харин бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хувьд энэ насны хүмүүс ял шийтгэгдсэн тохиолдол байхгүй байна.


3.2. ХҮНИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХУВИЙН БАЙДАЛ

Хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн хувийн байдлыг судалж, харьцуулан дүн шинжилгээ хийх нь дээрх гэмт хэргүүдийн нийтлэг болон ялгаатай шинжийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой. Иймд судалгааны хүрээнд хохирогчийн нас, хүйс, боловсролын байдал, айлын хэд дэх хүүхэд, гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ямар хамааралтай байсан эсэх, эрүүл мэндийн байдал гэсэн үзүүлэлтээр хувийн байдлыг тодорхойлов.

А. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч

Хүчиндэх гэмт хэргийн хохирогчдыг насны хувьд авч үзвэл хамгийн бага нь 3 настай байгаа бол 13-14 насныхан хамгийн их буюу 47 хувийг (нийт 32 хүүхэд) эзэлж байна (График 3.15).

График 3.15 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын насны байдал (хүүхдийн тоогоор)



Судалгааны дүнгээс үзвэл, 10 ба түүнээс доош насны хохирогч 32 хувийг эзлэж байгаа нь (24 хүн) анхаарал татсан асуудал юм. Түүнчлэн, 11-14 насны хохирогч 51 буюу 66.2 хувийг тус тус эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Үүнээс үзвэл 11-14 насны хүүхдүүд энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй бүлэгт хамаарч байна.

Хүчиндэх гэмт хэргийн хохирогчдыг боловсролын хувьд авч үзвэл 85.6 хувь нь бага боловсрол эзэмшиж байгаа, 10.2 хувь нь боловсролгүй буюу сургуулийн өмнөх насны хүүхдүүд байна. Харин 4.4 хувь нь сургуульд сурах насанд хүрсэн боловч сургууль завсардсан байна. (График 3.16) Хохирогчдыг хүйсийн хувьд авч үзвэл хүчиндэх гэмт хэрэгт 66 буюу 97.1 хувь эмэгтэй хүүхэд хохирсон байна.

Хохирогчийг айлын хэд дэх хүүхэд болох талаар авч үзвэл том хүүхэд 43 буюу 63.2 хувь, дунд хүүхэд 14 буюу 20.5 хувь, бага хүүхэд 8 буюу 11.7 хувийг тус тус эзэлж байгаа бол 3 буюу 4.5 хувь нь айлын ганц хүүхэд байжээ. (График 3.17)

График 3.16 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын боловсролын байдал




График 3.17 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч айлын хэд дэх хүүхэд вэ?





График 3.17-оос үзвэл айлын том хүүхдүүд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болох нь их байна.

Хохирогч, сэжигтэнтэй ямар хамааралтай байсныг авч үзвэл төрсөн хүүхэд 2.9 хувь, дагавар хүүхэд 19.1 хувь, өвөг эцэг 1.5

хувь, төрөл садан 17.6 хувь, хамт амьдардаг хүн 1.5 хувь, эцэг эхийн найз 6.4 хувь, үл таних хүн 20.6 хувь, таньдаг хүн 23.5 хувь, зүс мэдэх хүн 5.9 хувийг тус тус эзэлж байна. (График 3.18)

График 3.18 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ямар хамааралтай болох



Дээрх судалгаанаас үзэхэд, эцэг, өвөг эцэг, эсхүл хамт амьдардаг хүн нь хүүхдийг хүчиндсэн тохиолдол 25.0 орчмыг хувийг эзэлж байгаа нь гэр бүлийн хүрээнд хүчиндэх гэмт хэрэг гарсаар байгааг харуулж байна. Таньдаг болон эцэг, эхийн найзад хүчиндүүлэх тохиолдол түгээмэл байгааг анхаарах шаардлагатай.

Хүүхэд цэцэрлэг, сургуульд хамрагдах нь хүүхдэд албан ёсны хяналтын хэлбэр болдог бөгөөд гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх гол арга зам гэж үздэг. Тиймээс судалгааны хүрээнд хохирогчдын цэцэрлэг сургуульд хамрагддаг эсэхийг тодруулж үзэхэд 68 хүүхдийн 58 буюу 85.6 хувь нь цэцэрлэг, сургуульд хамрагдаг байжээ. (График 3.19)

Хохирогч бие махбод болон сэтгэцийн эмгэг, өвчтэй байсан эсэхийг авч үзвэл 2 буюу 2.9 хувь өвчтэй байсан бол 66 буюу 97.0 хувь нь ямар нэгэн өвчингүй эрүүл байжээ. (График 3.20)

График 3.19 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч цэцэрлэг, сургуульд хамрагддаг эсэх, хувиар





График 3.20 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогч бие махбод, сэтгэцийн хувьд өвчтэй байсан эсэх, хувиар




Хохирогчдын дийлэнх хувь нь цэцэрлэг сургуульд хамрагддаг байсан хэдий ч хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон байна. Энэ нь гэр бүлийн таагүй нөхцөл байдлаас шалтгаалан хүүхэд цэцэрлэг, сургуульд тогтмол хамрагддаггүй, зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдэх өдөр амралтын өдөр байжээ. Харин бие махбодын хувьд хохирогчдын 2.9 хувь нь эрүүл бус өвчлөлтэй байсан нь гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байх боломжтой.

Б. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч:

Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогчдын хувьд 1 нас хүртэлх хохирогч 3 буюу 7.5 хувийг эзэлж байгаа бол 14 настай хохирогч 2 буюу 5 хувийг тус тус эзэлж байна. Судалгааны дүнгээс харахад, 9 настай хохирогч 6 буюу 15 хувь, 3 ба 10 настай хохирогч тус бүр 5 буюу 12.5 хувийг тус тус эзэлж байна. (График 3.21)

График 3.21 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогчийн нас, тоогоор



Дээрх судалгаанаас үзэхэд, 7-10 насны хохирогч 18 буюу 45 хувь, 1-3 насны хохирогч 9 буюу 22.5 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь 14 насанд ойртох тутам халдлагад өртөх тоо өсөж байсан бол хүнийг алах гэмт хэргийн хувьд хохирогч 14 насанд ойртох тусам тоо нь эсрэгээрээ буурч байна.

Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч 14 буюу 35 хувь нь эрэгтэй, 26 буюу 65 хувь нь эмэгтэй хүүхэд байжээ.

Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогчид боловсролын хувьд бага боловсрол эзэмшиж байгаа 25 хүүхэд буюу 62.5 хувь, боловсролгүй сургуулийн өмнөх насны 13 хүүхэд буюу 32.5 хувь, сургуулийн насанд хүрсэн боловч сургууль завсардсан хүүхэд 2 буюу 5 хувийг тус тус эзэлж байна. (График 3.22)

Харин хохирогч айлын хэд дэх хүүхэд байсныг тодруулж үзвэл 11 буюу 27.5 хувь нь том хүүхэд, 6 буюу 15 хувь нь дунд хүүхэд, 19 буюу 47.5 хувь нь бага хүүхэд, 4 буюу 9.5 хувь нь айлын ганц хүүхэд байжээ. (График 3.23)

График 3.22 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогчдын боловсролын байдал, хувиар




График 3.23 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч айлын хэд дэх хүүхэд эсэх, хувиар





График 3.23-аас үзвэл, айлын бага хүүхэд хохирсныг насаар бага, биеэ хамгаалах чадваргүй, болж байгаа үйл явдлыг бүрэн ойлгох чадваргүй байдагтай холбон тайлбарлаж болно.

Хохирогч, гэмт хэрэг үйлдсэн хүний хоорондын хамаарлыг авч үзвэл өөрийн төрүүлсэн болон дагавар хүүхдээ алсан тохиолдол 19 буюу 57.5 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Мөн үл таних, зүс таних, таньдаг хүмүүс болон эцэг, эхийн найзын гарт хохирсон хүүхэд 12 буюу 30 хувийг эзэлж байна. Харин төрөл садны хүнд алуулсан хүүхэд 5 буюу 12.5 хувийг тус тус эзэлж байна. (График 3.24)

График 3.24 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэг үйлдсэн хүний хоорондын хамаарал, хувиар



Дээрх судалгаанаас амь насаа алдсан хүүхдийн 85 хувь нь өөрийн эцэг, эх, таньдаг болон ойр дотны хүний гарт амь насаа алдсан байгаа нь анхаарал татаж байна. Энэ гэр бүлийн салалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргийг нуун далдлах зэрэг зорилгоор үйлдэгдсэн байна.

Хохирогчдын цэцэрлэг, сургуульд хамрагддаг, бие махбод, сэтгэцийн хувьд эрүүл хүүхэд байсан эсэхийг авч үзвэл 62,5 хувь нь цэцэрлэг сургуульд хамрагддаг, 92,5 хувь нь эрүүл хүүхэд байжээ. (График 3.25. 26)

График 3.25 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч цэцэрлэг, сургуульд хамрагддаг эсэх, хувиар





График 3.26 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хохирогч бие махбод, сэтгэцийн хувьд өвчтэй байсан эсэх, хувиар



Дүгнэлт: Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийн хувийн байдлыг тодорхойлбол дараах нийтлэг болон ялгаатай шинжтэй байна. Үүнд:

Нийтлэг шинж: Хохирогчдын 90 орчим хувь нь сургууль, цэцэрлэгт хамрагддаг, сэтгэц, бие махбодын хувьд эрүүл байна.

Ялгаатай шинж: Хүчиндэх гэмт хэргийн хувьд айлын том хүүхэд хохирогч болох магадлал ихтэй байгаа бол хүүхдийг алах гэмт хэргийн хувьд айлын бага хүүхэд өртөх магадлал ихтэй байна. Хүчиндэх гэмт хэргийн хувьд өөрийн төрсөн хүүхдээ хүчиндэх тохиолдол харьцангуй цөөн байгаа бол хүүхдийг алах гэмт хэргийн хувьд төрсөн хүүхдээ алсан тохиолдол нийт


тохиолдлын 42.5 хувийг эзэлж байна. Хохирогчдыг насны байдлаар нь авч үзвэл хүчиндэх гэмт хэргийн хувьд 13-14 насны хүүхэд халдлагад ихээр өртсөн бол хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 8-10 насны хүүхэд илүү өртсөн байна. Мөн хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 95 орчим хувь эмэгтэй хүүхэд байгаа бол хүүхдийг алах гэмт хэргийн хувьд хохирогч эмэгтэй хүүхэд байх нь давамгайлж байна.

3.3. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

А. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл:


Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр, тухайн нутаг дэвсгэрийн байршил, гэмт хэрэг үйлдэгдсэн газар гэсэн 3 түвшинд хувааж дүн шинжилгээ хийсэн. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар нутгийг Улаанбаатар хот, бүс тус бүрээр нь нэгтгэн харуулав. (График 3.27)

График 3.27 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хувиар



Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд Улаанбаатар хотод 34 буюу 50.0 хувь, баруун бүсэд 3 буюу 4.4 хувь, зүүн бүсэд 13 буюу 19.1 хувь, хангайн бүсэд 2 буюу 2.9 хувь, төвийн бүсэд 16 буюу 23.5 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл Улаанбаатар хотод энэ төрлийн гэмт хэргийн гаралт харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг нарийвчлан тодорхойлох үүднээс нутаг дэвсгэрийн дотор хаана ихээр үйлдэгдэж байгаад дүн шинжилгээ хийв. (График 3.28)


График 3.28 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байршил, хувиар



Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг байршлын хувьд Улаанбаатар хотын захын дүүрэгт байрлах гэр хороололд 15 буюу 22.1 хувь, Улаанбаатар хотод байрлах орон сууцны хороололд 19 буюу 27.9 хувь, аймгийн төвд 9 буюу 13.2 хувь, сумын төв, түүний ойролцоо 25 буюу 36.7 хувийг тус тус эзэлж байна. Улаанбаатар хотын хувьд гэр хороолол, орон сууцны хороололд үйлдэгдэж байгаа хүчиндэх гэмт хэргийн хувь ойролцоо байна.

Хүүхэд аюулгүй орчинд амьдрах эрхтэй бөгөөд өөрийн амьдардаг болон байнга зорчдог газартаа хүчиндэх гэмт хэрэгт өртсөн эсэхийг тодорхойлох зорилгоор гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг нарийвчлан гаргав. (График 3.29)


График 3.29 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хувиар



Гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд авч үзвэл өөрийн амьдардаг гэрт 26 буюу 38.2 хувь, бусад хүний гэр, орон сууцанд 21 буюу 30.9 хувь, гудамж талбайд 2 буюу 2.9 хувь, албан газарт 1 буюу 1.5 хувь, сургуульд 1 буюу 1.5 хувь, зочид буудалд 8 буюу 11.7 хувь, хөдөө хээр 9 буюу 13.2 хувь тус тус үйлдэгдсэн байна. Дээрх судалгаанаас үзэхэд, хүүхэд ихэнх тохиолдолд өөрийн амьдардаг гэртээ хүчиндүүлсэн байгаа нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хангагдаагүй гэж дүгнэж болохоор байна.

Гэмт хэрэг үйлдсэн цагийг үечлэн авч үзвэл 00-03 цаг хүртэл 19 буюу 27.9 хувь, 04-08 цаг хүртэл 4 буюу 5.8 хувь, 09-12 цаг хүртэл 11 буюу 16.1 хувь, 13-16 цаг хүртэл 9 буюу 13.2 хувь, 17-20 цаг хүртэл 14 буюу 20.5 хувь, 21-24 цаг хүртэл 11 буюу 16.4 хувийг тус тус эзэлж байна. (График 3.30)


График 3.30 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, хувиар



Үүнээс үзвэл, шөнийн цагаар буюу 00-03 цагийн хооронд энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна. Шүүхийн шийтгэх тогтоолоос үзэхэд, бага насны хүүхдийг унтаж байхад шөнийн цагаар оронд нь хүчиндсэн тохиолдол цөөнгүй байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн улирлын хувьд авч үзвэл зуны улиралд 17 буюу 25.0 хувь, өвлийн улиралд 13 буюу 19.1 хувь, хаврын улиралд 29 буюу 42.6 хувь, намрын улиралд 9 буюу 13.2 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл, хаврын улиралд хамгийн их үйлдэгдэж байна. (График 3.31)


График 3.31 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн улирал, хувиар



Судалгаанаас үзэхэд хавар, зун энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нь хүүхдэд тавих хяналт суларсантай холбоотой. Учир нь хүүхдийг олон цагаар орхих, айлд харуулах, зарим тохиолдолд хохирогч, насанд хүрсэн хүмүүсийг дагаж аялал, зугаалга, ажил хийх зэргээр хөдөө, орон нутагт явж байхдаа гэмт хэрэгт өртсөн тохиолдол цөөнгүй байна. Мөн улирал дамнаж, удаан хугацаанд үйлдэгдэж байгааг анхаарах нь зүйтэй.

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг нарийвчлан тогтоох зорилгоор гэмт хэрэг үйлдэгдсэн гаригийг авч үзвэл, Даваа гаригт 6 буюу 8.8 хувь, Мягмар гаригт 9 буюу 13.2 хувь, Лхагва гаригт 10 буюу 14.7 хувь, Пүрэв гаригт 20 буюу 29.4 хувь, Баасан гаригт 7 буюу 10.2 хувь, Бямба гаригт 13 буюу 19.1 хувь, Ням гаригт 3 буюу 4.4 хувийг эзэлж байна. (График 3.32)

График 3.32 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн гариг, хувиар




Үүнээс үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг нь Пүрэв болон Бямба гаригт хамгийн их үйлдэгдсэн байна. Харин энэ төрлийн гэмт хэрэг Даваа болон Ням гаригт хамгийн бага үйлдэгдэж, 7 хоногийн дунд үед нэмэгдэх хандлагатай байжээ.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн үйлдлийн аргыг судалж дүн шинжилгээ хийсэн.

Гэмт хэргийн үйлдлийн аргын хувьд авч үзвэл, хүч хэрэглэсэн 15 буюу 22.0 хувь, хүч хэрэглэхээр заналхийлсэн 4 буюу 5.8 хувь, хууран мэхэлсэн 7 буюу 10.2 хувь, эрхшээлдээ байгаа хүний эсрэг 2 буюу 2.9 хувь, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулсан 26 буюу 38.2 хувь, гарын хуруу болон бусад зүйл хийх аргаар 3 буюу 4.4 хувь, согтууруулах ундаа хэрэглүүлж, бие хамгаалах чадваргүй байдлыг далимдуулсан 7 буюу 10.2 хувь, мансуурсан үед 4 буюу 5.8 хувийг тус тус эзэлж байна. (График 3.33)

График 3.33 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн үйлдлийн арга, хувиар




Үүнээс үзвэл, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулж хүчиндэх тохиолдол хамгийн их байна. Судалгаанаас үзэхэд, бага насны хохирогч өөрийн биеийг хамгаалах чадваргүй, нөгөө талаас шүүгдэгч бэлгийн харьцаанд тохиролцсоны үндсэн дээр орсон гэж мэдүүлэх тохиолдол түгээмэл байна. Харин хохирогчийн өгсөн мэдүүлгээс дүгнэхэд айсны улмаас эсэргүүцэл үзүүлээгүй, бусдаас тусламж хүсээгүй, дуу чимээ гаргаагүй байдаг нь шүүгдэгчид зөвшөөрсөн мэт сэтгэгдэл төрүүлдэг байна.

Гэмт хэргийн сэдэлтийн хувьд авч үзвэл бэлгийн дур хүслээ хангах гэж 62 буюу 91.2 хувь нь хариулжээ. Хохирогчийг хүчиндсэн давтамжийн хувьд авч үзвэл 1 удаа 39 буюу 57.3 хувь, 2-3 удаа 17 буюу 25.0 хувь, 4-6 удаа 7 буюу 10.2 хувь, байнга буюу


улирал, жил дамжин хүчиндсэн тохиолдол 5 буюу 7.3 хувийг эзэлж байна. (График 3.34)

График 3.34 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн давтамж, хувиар




Дээрх судалгаанаас үзэхэд, дийлэнх тохиолдол нь 1 удаа хүчиндэж таслан зогсоогдсон байхад 42 орчим хувь нь удаа дараа үйлдэгдэж байсныг харуулж байна. Судалгаанаас үзэхэд, анхны удаа хүчиндээд хэрэг илрээгүй тохиолдолд дахин үйлдсэн тохиолдол түгээмэл байна. Давтан үйлдсэн тохиолдлуудын үргэлжилсэн хугацааг тогтоох нь олон талын ач холбогдолтой. Тиймээс 2 ба түүнээс дээш удаа хүчиндсэн 29 тохиолдлын үргэлжилсэн хугацаанд дүн шинжилгээ хийж үзэхэд, 16 буюу 55.1 хувь 1-6 сар, 6 буюу 21.4 хувь нь 7-12 сар, 4 буюу 13.2 хувь нь 13-18 сар, 3 буюу 10.3 хувь нь 19-ээс дээш сар үргэлжилсэн байна. (График 3.35)

График 3.35 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэж удааширсан хугацаа, хувиар



Үүнээс үзвэл гэмт хэрэг үйлдэж удааширсан хугацаа хамгийн их хувийг 1–6 сарын хугацаа эзэлж байна. Судалгаанаас үзэхэд, хохирогч жирэмсэн болсон, эсхүл тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг илрэх тохиолдол түгээмэл байна. Хохирогч хүчиндүүлсэн даруйдаа бусдад мэдэгдэх тохиолдол харьцангуй цөөн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байхад нөлөөлж байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн гэмт этгээд ганцаараа үйлддэг болох нь дараах судалгаанаас харагдаж байна. тухайлбал, Гэмт хэрэг үйлдэхдээ хамтран оролцсон тохиолдол 9 буюу 13.2 хувь, хамтран оролцогч байхгүй 59 буюу 86.7 хувийг тус тус эзэлж байна. (График 3.36)

График 3.36 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт хамтран оролцогч, хувиар



Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгслийн хувьд авч үзвэл хутга 2 буюу 2.9 хувь, галт зэвсэг 1 буюу 1.4 хувь, ахуйн хэрэглээний багаж 1 буюу 1.4 хувь, хордуулах бодис 3 буюу 4.2 хувь, зэвсэг хэрэглээгүй 61 буюу 89.7 хувийг эзэлж байна. (График 3.37)

График 3.37 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, хувиар




Дээрх судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг хүчиндэхдээ зэвсэг, зэвсгийн чанартай зүйл бараг хэрэглэдэггүй байна. Энэ нь хохирогчийн бие бялдрын байдал, ихэнх тохиолдолд эмэгтэй хүүхэд байдаг, аль болох бусдаас нууц далд аргаар үйлдэх боломжтой байдлаар тайлбарлагдана.

Гэмт хэргийн улмаас хохирогч болон хохирогчийн гэр бүлийн гишүүдэд тодорхой хор уршиг учрах явдал цөөнгүй байна. Тухайлбал, гэмт хэргийн улмаас хохирогч шууд хохирохоос гадна эцэг, эх, эмээ, өвөө болон бусад ойр дотнын хүмүүсийн эрүүл мэнд болон сэтгэцийн байдалд өөрчлөлт үр дагавар гарсан байна.

Хүчиндэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хувьд авч үзвэл хохирогчийн эрүүл мэнд 17 буюу 25.0 хувь, сэтгэцийн өөрчлөлттэй болсон 13 буюу 19.1 хувь, жирэмсэн болсон 23 буюу 33.8 хувь, гэр бүл салсан 4 буюу 5.8 хувь, сургууль завсардсан 3 буюу 4.4 хувь, бусад 8 буюу 11.7 хувийг тус тус эзэлж байна. (График 3.38)

График 3.38 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг улмаас учирсан хор уршиг, хувиар




Судалгаанаас үзэхэд, хохирогчдын 33.8 хувь нь жирэмсэн болж, үр хөндүүлсэн байна. Мөн бэлгийн замын халдварт өвчин авах, бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учирсан тохиолдол түгээмэл байна. Харин хохирогч төдийгүй, хохирогчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эцэг, эх нь сэтгэцийн эмгэгтэй болсон тохиолдол байгаа нь анхаарал татаж байна.

Б. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл:

Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг газар нутгийн бүсээр нь авч үзвэл Улаанбаатар хотод 18 буюу 45.0 хувь, баруун бүсэд 1 буюу 2.5хувь, зүүн бүсэд 5 буюу 12.5 хувь, хангайн бүсэд 12 буюу 30.0 хувь, төвийн бүсэд 4 буюу 10.0 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл Улаанбаатар хотод болон хангайн бүсэд хамгийн их үйлдэгдсэн байна. (График 3.39)

График 3.39 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр (бүсээр), хувиар



Хүүхдийг алах гэмт хэргийг үйлдэгдсэн газрын хувьд авч үзвэл, өөрийн амьдардаг гэрт 16 буюу 40.0 хувь, бусад хүний гэр, орон сууцанд 11 буюу 27.5 хувь, гудамж талбайд 5 буюу 12.5 хувь, ресторан цайны газарт 1 буюу 2.5 хувь, хөдөө хээр 5 буюу 12.5 хувь, орц хонгилд 2 буюу 5.0 хувь тус тус үйлдэгдсэн байна. (График 3.40)


График 3.40 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хувиар



Үүнээс үзвэл, энэ төрлийн гэмт хэрэг хохирогчийн өөрийн гэр орон сууцанд хамгийн их үйлдэгдэж байна.

Хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд нарийвчлан авч үзвэл Улаанбаатар хотын захын дүүрэгт байрлах гэр хороололд 11 буюу 27.5 хувь, Улаанбаатар хотод байрлах орон сууцны хороололд 7 буюу 17.5 хувь, аймгийн төвд 3 буюу 7.5 хувь, сумын төв, түүний ойролцоо 19 буюу 47.5 хувь тус тус үйлдэгдсэн байна. (График 3.41)


График 3.41 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн газар (нарийвчилсан), хувиар



Үүнээс үзвэл, сумын төв түүний ойролцоо энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн нь харагдаж байна.

Хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн хувьд нь 00-03 цагт 8 буюу 20.0 хувь, 04-08 цагт 5 буюу 12.5 хувь, 09-12 цагт 4 буюу 10.0 хувь, 13-16 цагт 5 буюу 12.5 хувь, 17-20 цагт 12 буюу 30.5 хувь, 21-24 цагт 6 буюу 15.0 хувь нь тус тус үйлдэгдсэн байна. (График 3.42)


График 3.42 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, хувиар



Үүнээс үзвэл, 17-20 цагийн хооронд энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг байна. Судалгаанаас үзэхэд, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ ажлын бус цагаар, хүмүүс гэртээ цугларах үеэр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.


Хүүхдийг алах гэмт хэргийг үйлдэгдсэн улирлын хувьд авч үзвэл зуны улиралд 14 буюу 35 хувь, өвлийн улиралд 9 буюу 22.5 хувь, хаврын улиралд 10 буюу 25.0 хувь, намрын улиралд 7 буюу 17.5 хувь нь тус тус үйлдэгджээ. Үүнээс үзвэл, зуны улиралд энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн байна. (График 3.43)

График 3.43 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн улирал, хувиар




Гэмт хэрэг үйлдэгдсэн гаригийн хувьд авч үзвэл 6 буюу 15.0 хувь нь Даваа, 5 буюу 12.5 хувь нь Мягмар, 4 буюу 10.0 хувь нь Лхагва, 3 буюу 7.5 хувь нь Пүрэв, 5 буюу 12.5 хувь нь Баасан, 13 буюу 32.5 хувь нь Бямба, 4 буюу 10.0 хувь нь Ням гаригт тус тус үйлдэгдсэн байна. Үүнээс үзвэл, гэмт хэрэг үйлдэгдсэн гаригийн хувьд Бямба гаригт хамгийн их үйлдэгддэг байна. (График 3.44)

График 3.44 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн гариг, хувиар



Гэмт хэргийн үйлдлийн аргын хувьд авч үзвэл 15 нь буюу 37.5 хувь нь зодож, 6 нь буюу 15.0 хувь нь боож, 1 нь буюу 2.5 хувь нь хутгалж, 1 нь буюу 2.5 нь буудаж, 1 нь буюу 2.5 хувь нь живүүлж, 1 нь буюу 2.5 хувь нь түлхэж, 2 нь буюу 5.0 хувь нь шидэж, 6 нь буюу 15.0 хувь нь хаясан, 1 нь буюу 2.5 хувь нь хүчиндэж болон 6 нь буюу 15.0 хувь нь бусад аргаар үйлдэгдсэн байна. Үүнээс үзвэл, хамгийн их гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж буй арга нь зодож хүүхдийг алсан байна. (График 3.45)


График 3.45 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн үйлдлийн арга, хувиар



Судалгаанаас үзэхэд, зодох, боох зэрэг хүч хэрэглэх шинжтэй үйлдэл хийж, хүүхдийг алсан байна. Энэ нь хүүхдийн биеийн хөгжлийн онцлог, биеэ хамгаалах чадваргүй байдалтай холбоотой.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлын хувьд авч үзвэл, 12 буюу 30.0 хувь нь согтуурсан үедээ, 5 буюу 12.5 хувь нь эрүүл үедээ маргалдсан, 2 буюу 5 хувь нь амьдралын таагүй нөхцөл байдлыг далимдуулан, 15 буюу 37.5 хувь нь биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан, 2 буюу 5 хувь нь бусад хүний өдөөн хатгалга, 4 буюу 10 хувь нь гэр бүлийн гишүүдийн маргааны улмаас үйлдсэн байна. (График 3.46)


График 3.46 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хувиар



Судалгаанаас үзэхэд, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан үйлдсэн тохиолдолд 37.5 хувийг эзэлж байгаа нь хохирогч тухайн үйл явдлыг ойлгох чадваргүй байдагтай холбоотой. Тухайлбал, бага насны хохирогчийг ухаан алдаж үзэх үү хэмээн хууран мэхэлж хоолойг нь боосон тохиолдол байна. Түүнчлэн, согтуугаар маргалдсан үедээ хүүхдэд уураа гаргаж зодох, шидэх байдлаар амь насыг нь хохироож байна. Зарим тохиолдолд гэр бүлийн гишүүд өмнөх амьдралтайгаа холбоотойгоор хардах, дагавар хүүхдээ үзэн ядах, хүүхдээс болж хэрүүл, маргаан байнга гарч байна гэх шалтгаанаар хүүхдийг зодож шийтгэх байдал удаан үргэлжилсний улмаас хүүхдийг алсан тохиолдол их байна.

Гэмт хэргийн шалтгааныг тогтооход гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилгыг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан хэргүүдийн 3 буюу 7.5 хувь нь үгэнд ороогүй, 4 буюу 10 хувь нь хийсэн үйлдэлд нь зэвүүцэж, 7 буюу буюу 17.5 хувь нь үзэн ядаж, 10 буюу 25.0 хувь нь гэмт хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор, 5 буюу 12.5 хувь нь бэлгийн дур хүслээ хангах зорилгоор, 3 буюу 7.5 хувь нь өс хонзон, 8 буюу 20 хувь нь тэжээн тэтгэх үүргээсээ зайлсхийх гэсэн сэдэлт, зорилгоор үйлдсэн байна. (График 3.47)


График 3.47 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, хувиар



Үүнээс үзвэл, гэмт хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тооны хувьд авч үзвэл гэмт хэргийн улмаас 1 хүн хохирсон 33 буюу 82.5 хувь, 2 хүн хохирсон 5 буюу 12.5 хувь, 3 хүн хохирсон 2 буюу 5.0 хувь байна. (График 3.48)

График 3.48 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд, хувиар




Дийлэнх тохиолдолд гэмт хэргийн улмаас нэг хүүхэд хохирсон байна. Харин нийтэд аюултай аргаар буюу галдан шатаах, эсхүл үзэн ядаж гэр бүлээр нь хөнөөхөд хэд, хэдэн хүүхэд хохирсон байна.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтооход тухайн гэмт үйлдэл ямар хугацаанд үргэлжилсэн, хүүхдийг байнга зодож

байсан, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд амь насаа алдсан эсэх нь ач холбогдолтой. Гэмт хэрэг үйлдэж удааширсан хугацааны хувьд авч үзвэл 1-6 сарын хугацаанд удааширсан 3 буюу 7.5 хувь, 7-12 сарын хугацаанд удааширсан 2 буюу 5.0 хувь, 13-18 сарын хугацаанд удааширсан 2 буюу 5.0 хувь, нэг удаагийн үйлдлээр хохироосон 33 буюу 82.5 хувийг тус тус эзэлж байна. (График 3.49)


График 3.49 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж удааширсан хугацаа, хувиар



Дээрх судалгаанаас үзэхэд, ихэнх тохиолдолд нэг удаагийн үйлдлээр нэг цаг хугацаанд хохирогчид халдаж амь насыг хөнөөсөн байна. Харин 17.5 хувь нь ямар нэгэн байдлаар хохирогчийг удаа дараа зодож, хүчирхийллийн шинжтэй үйлдлийг давтамжтай хийдэг байсан нь хохирогчийг үхэлд хүргэх шалтгаан болжээ. Эдгээр байнгын шинжтэй хүчирхийллийн үйлдэл нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хүрээнд болж байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийг эрт илрүүлж, хүүхдийг хамгаалалтад авсан бол энэ гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх боломжтой байсан байна.

Гэмт хэрэгт хамтран оролцсон хүмүүсийн хувьд авч үзвэл ижил хүйсийн хүмүүс хамтран оролцсон 1 буюу 2.5 хувь, өөр хүйсийн хүмүүс хамтран оролцсон 4 буюу 10.0 хувь, хамтран оролцогчгүй 35 буюу 87.5 хувийг тус тус эзэлж байна. (График 3.50)


График 3.50 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт хамтран оролцсон байдал, хувиар



Үүнээс үзвэл гэмт хэрэг үйлдэхдээ хамтран оролцогчгүйгээр ганцаараа гэмт хэрэг үйлдэх нь хамгийн их байна. Хүүхэд биеэ хамгаалах чадваргүй байдагтай холбоотойгоор хамтран оролцсон, урьдаас төлөвлөж бэлтгэсэн тохиолдол цөөн байна.

Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсгийн хувьд хутга ашигласан 3 буюу 7.5 хувь, галт зэвсэг ашигласан 1 буюу 2.5 хувь, ахуйн хэрэглээний багаж ашигласан 6 буюу 15 хувь, олс түүнтэй адилтгах зүйл 5 буюу 12.5 хувь, ямар нэгэн зүйлийг зэвсгийн чанартай ашигласан 1 буюу 2.5 хувь, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглээгүй 24 буюу 60.0 хувийг тус тус эзэлж байна. (График 3.51)


График 3.51 Гэмт хэрэг үйлдэхдээ зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашигласан эсэх, хувиар



Үүнээс үзэхэд, хүүхдийн амь насыг хохироохдоо зэвсэг, зэвсгийн чанартай зүйл бараг хэрэглэдэггүй байна. Олс, түүнтэй адилтгах зүйлээр боож хүүхдийн амь насыг хөнөөсөн тохиолдол нь хохирогчийг дуу гаргуулахгүй байх, ул мөр үлдээхгүй байхад хамгийн тохиромжтой байх боломжтой байна.

Хохирогчийн нас барсан хугацааг авч үзвэл гэмт хэргийн улмаас шууд нас барсан тохиолдол 31 буюу 77.5 хувь, гэмт хэргийн улмаас тодорхой хугацааны дараа нас барсан 9 буюу 22.5 хувийг тус тус эзэлж байна. (График 3.52)

График 3.52 Хохирогч нас барсан хугацаа, хувиар



Үүнээс үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирогч шууд нас барах тохиолдол их байна. Шинжээч эмчийн дүгнэлтээс үзэхэд, хохирогч гэмтэл авснаас хойш 4-6 цагийн дотор нас барсан гэх тохиолдол 22.5 хувийг эзэлж байгаа бол гэмтлийн улмаас 7 хоног, сарын дараа нас барсан тохиолдол судалсан хэргийн дотор байхгүй байна. Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 98.5 хувийг эрэгтэй, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 55 хувийг эрэгтэй, 45 хувийг эмэгтэй хүн үйлдсэн байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 50.0 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний 62.5 хувийг 19-30 насны хүн эзэлж байгаа бол 51-74 насны хүмүүс бага

насны хүүхдийг хүчиндсэн тохиолдол 6 орчим хувь байна. Харин бага насны хүүхдийг 51-ээс дээш насныхан алсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

2. Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 90 орчим хувь нь бүрэн дундаас доош, 60 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой, 85 орчим хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 70 орчим хувь нь орон нутагт төрж, өссөн, 19 орчим хувь нь урьд нь ял шийтгэгдэж байсан хүн байна.
3. Хорих ял биечлэн эдэлсэн хүн зан байдлын хувьд засарч хүмүүжээгүй байхад хугацаанаас нь өмнө тэнсэн сулласан, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, өршөөгдсөн үед цагдаагийн байгууллага хяналт сул тавьсан нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болсон тохиолдол цөөнгүй байна. (Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг түүвэр судалгаа №2, 4, 5, 10)
4. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 90 орчим хувь нь сургууль, цэцэрлэгт хамрагддаг, сэтгэц, бие махбодын хувьд эрүүл, хүчиндэх гэмт хэргийн хувьд 13-14 насны хүүхэд халдлагад өртсөн тохиолдол 47 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 8-10 насны хүүхэд хохирсон тохиолдол 37.5 хувь, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын хамгийн бага нь 1 настай хүүхэд байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 97.1 хувь эмэгтэй хүүхэд байхад хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 65 хувь мөн эмэгтэй хүүхэд байгаа нь анхаарал татаж байна.
5. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садангийн хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 38.2 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн 40 хувь нь хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 30.9 хувь,

бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 27.5 хувь нь хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ.

6. Гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа зэрэг нь бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Судалгаанаас үзэхэд, өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн тохиолдол 2.9 хувь, төрсөн хүүхдээ алсан тохиолдол 42.5 хувийг тус тус эзэлж байна. Харин дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 19.1 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг эзэлж байгаа бол дагавар хүүхдээ алсан тохиолдол 15 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг алсан тохиолдол 12.5 хувийг тус тус эзэлж байна. Тухайлбал, гэр бүл салж, хоёр дахь амьдрал зохиосонтой холбоотойгоор дагавар хүүхдээ үзэн ядаж удаан хугацаанд зоддог байснаас хүүхдийг алсан тохиолдол 25 хувь, өөрийн төрсөн хүүхэд биш гэсэн шалтгаанаар бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 40.2 хувийг эзэлж байна. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь өөр хүнтэй гэр бүл болсон гэсэн шалтгаанаар эмээ, өвөөгийн гэрт байхдаа бусад хүмүүст хүчиндүүлсэн тохиолдол 27.9 хувийг тус тус эзэлж байна. (Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг түүвэр судалгаа №8, 10, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг түүвэр судалгаа №3 үзнэ үү)
7. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болж байна. Судалгаанаас үзэхэд, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садангийн хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол 16 буюу 23,5 хувьтай байгаа анхаарал татаж байна. Хохирогч жирэмсэн болсон, эсхүл бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байна. Удаан хугацаанд нуун далдалсан шалтгаан нь 40,4 дарамтад өртсөн, 20,3 хувь хууртагдсан, 17 хувь

гэр бүлийн гишүүдээсээ санаа зовсон /ээж, дүү/, 19,1 хувь бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгоогүй зэрэг байна. Харин үл таних хүнд хүчиндүүлсэн тохиолдолд хохирогч ойролцоо байгаа хүн болон өөрийн эцэг, эх ойр дотнын хүндээ шууд мэдэгддэг байна. (Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг түүвэр судалгаа №4, 9)

8. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хувьд хохирогчийн буруутай үйл ажиллагаа бараг тогтоогдоогүй, харин гэнэн итгэмтгий зангаасаа болж гэмт хэрэгт хохирсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, “Ухаан алдахаар гоё мэдрэмж төрдөг” гэсэн үгэнд хууртаж, өөрийгөө боолгуулсан байна. Харин хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мөнгө шаардлагатай болсон, зочид буудал, гэмт хэрэг үйлдсэн хүний ажлын байранд очсон, тээврийн хэрэгслээр зугаалсан, ажил, хөдөлмөр эрхлэх нэрээр садар самуун явдалд орж биеэ үнэлсэн, бусдаас тусламж хүсэх боломж байсаар байтал тусламж аваагүй зэрэг нь хохирогч болоход нөлөөлсөн байх боломжтой байна. Эдгээр нөхцөл байдлын цаана гэр бүлийн таагүй орчин, эцэг, эхийн хараа хяналт сул, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл байгааг анхаарах нь зүйтэй. Судалгаанаас үзэхэд, 12 настай охин ажил хийж байгаа нэрээр гэртээ нэг сар орчим ирээгүй байхад эцэг, эх нь хайгаагүй байх, хойд эцэгтээ хүчиндүүлсэн охин нэгэнт хүчиндүүлсэн гэсэн шалтгаанаар бусад хүнтэй төлбөртэй бэлгийн харьцаанд орсон тохиолдол байна.
9. Бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй гэдгийг нь мэдсээр байж зодох, боох, шидэх зэрэг аргаар алсан тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг үйлдсэн хүн өмнө үйлдсэн гэмт хэргийг бага насны хүүхэд харсан тохиолдолд гэмт хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор тухайн бага насны хүүхдийг алсан үйлдсэн тохиолдол 25 хувь, хүүхдийн хийсэн үйлдэлд зэвүүцэх, үзэн ядах, үгэнд орсонгүй гэсэн үл ялих зүйлээр шалтаглаж алсан тохиолдол 35 хувь, тэжээн тэтгэхээс зайлсхийх сэдэлт, зорилготой 20 хувь байгаа нь анхаарал татаж байна. Хүчиндэх гэмт хэргийн хувьд бэлгийн

харьцааны учир холбогдлыг ойлгохгүй байгааг далимдуулж, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглүүлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах, хууран мэхлэх зэрэг аргаар ихэвчлэн үйлдэгдсэн байна.

10. Хүчиндэх гэмт хэргийн улмаас бага насны хохирогч болон түүний ойр дотны хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаанд ихээхэн хохирол учирч байна. Тухайлбал, хохирогч нас барсан, амиа хорлосон, сэтгэцийн эмгэгтэй болсон, жирэмсэн болсон, ураг хөндүүлсэн, бэлгийн замын халдварт өвчтэй болсон, сургууль завсардсан, гэр бүлээсээ дайжсан, гэр бүл салсан, биеэ үнэлэх болсон, бэлгийн замбараагүй харьцаанд орж эхэлсэн зэрэг сөрөг үр дагавар бий болжээ.
11. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч 10-14 насны хүүхдийн хувьд сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, өөрийн гэсэн үзэл бодол тогтоогүй байдаг учир сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхгүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн онцлог зэрэг нь хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна.


ДӨРӨВ. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛСАН БАЙДАЛ

4.1. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛЖ БУЙ ЕРӨНХИЙ БАЙДАЛ

А. Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулсан байдал:

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн хугацааг авч үзэх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг тодорхойлох нэг шалгуур юм. Нөгөө талаас шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг үнэлэхэд ач холбогдолтой. Хэргийг шийдвэрлэсэн хугацааны хувьд нийт 68 хэргээс 1 жил хүртэл хугацаанд 46 буюу 67.6 хувь, 1-2 жил хүртэл хугацаанд 20 буюу 29.4 хувь, 3-4 жил хүртэл хугацаанд 2 буюу 2.9 хувь нь тус тус шийдвэрлэгдсэн бол 5 жил түүнээс дээш хугацаанд шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй. (График 4.1)

График 4.1 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн хугацаа, хувиар




Үүнээс үзэхэд, нийт хэргийн 97 хувь 1-2 жилийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүн үйлдсэн хэргээ хүлээсэн, шинжээчийн дүгнэлтээр гэмт хэрэг үйлдсэн болох нь бүрэн дүүрэн нотлогддог зэрэгтэй холбоотой.

2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт “...бага насны хүүхэд хүчиндсэн..” бол 15-25 жилийн хугацаагаар хорих ял, эсхүл цаазаар авах ял, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “... бага насны хүүхдийг хүчиндсэн” бол 12-20 жилийн хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан байна.

Нийт ял оногдуулсан 68 хэргийн 2 буюу 2.9 хувьд төгсөөгүй гэмт хэрэгт /завдалт/ тооцож хорих ял, 63 буюу 92.6 хувьд төгссөн гэмт хэрэгт тооцож хорих ял, 3 буюу 4.4 хувьд нь цаазаар авах ял тус тус оногдуулсан байна. (График 4.2)


График 4.2 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хувиар



Нийлбэр дүнгээр нь авч үзвэл нийт ял оногдуулсан хэргийн 65 буюу 95.5 хувьд нь хорих ял оногдуулсан байна. Хорих ял оногдуулсан 65 тохиолдолд оногдуулсан ялыг үечлэн авч үзвэл 4.6-11 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 2 буюу 2.9 хувь, 12-14 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 4 буюу 6.2 хувь, 15-17 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 9 буюу 14.0

хувь, 18-20 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 16 буюу 25.0 хувь, 21-23 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 28 буюу 42.1 хувь, 24-25 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 6 буюу 9.3 хувийг тус тус эзэлж байна. (График 4.3)


График 4.3 Хорих ял оногдуулсан хугацаа, хувиар



Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 12-оос дээш 20 жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан. Харин хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан, бэлтгэсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон оногдуулах ялын гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр ял оногдуулна гэснийг баримтлан 4.6 жилийн хорих ял оногдуулсан байна. Түүнчлэн, 2002 оны Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийг удирдлага болгон ял оногдуулсан байна.

Мөн эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тогтоох, ялыг ялгамжтай оногдуулахад хамтран оролцогч байгаа эсэхийг тогтоох ёстой. Хамтран оролцогчид нь ял оногдуулсан эсэхийг авч үзвэл 10 буюу 14.8 хувь хамтран оролцогчид нь ял шийтгэл оногдуулсан бол 58 буюу 85.2 хувь хамтран оролцогчид нь ял оногдуулаагүй байна. Үүнээс үзэхэд, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхдээ хамтран оролцох тохиолдол харьцангуй цөөн байна. (График 4.4)

График 4.4 Хамтран оролцогчид ял оногдуулсан эсэх, хувиар




Хүчиндэх гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон этгээдүүдийн оролцооны хэлбэрийг авч үзвэл 7 буюу 70 хувь нь гүйцэтгэгч, 3 буюу 30 хувь хамжигч хэлбэрээр оролцсон гэж ял оногдуулсан байна.

Хэрэг хянан шийдвэрлэх явцад таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан тохиолдлыг судалж үзэхэд, 68 буюу 100 хувь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байдаг боловч цагдан хоригдсон хугацаа харилцан адилгүй байна.

Цагдан хоригдсон хугацааны хувьд 1-3 сар хүртэл хугацаагаар 22 буюу 32.3 хувь, 4-7 сар хүртэл хугацаагаар 35 буюу 51.4 хувь, 8-12 сар хүртэл хугацаагаар 8 буюу 11.7 хувь, 13-18 сар хүртэл хугацаагаар 3 буюу 4.4 хувийг тус тус эзэлж байна. (График 4.5)

График 4.5 Цагдан хоригдсон хугацаа, хувиар




Үүнээс үзвэл нийт гэмт хэргийн 83.7 хувьд нь 1-7 сарын хугацаагаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байгаа нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг шийдвэрлэхдээ түргэн хугацаанд шийдвэрлэдэг болох нь харагдаж байна. Харин 15 орчим хувь нь 8 сараас дээш хугацаагаар цагдан хорьсон тохиолдол нь хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогчийн амь нас хохирсон, үргэлжилсэн үйлдэлтэй зэрэг ээдрээ төвөгтэй нөхцөл байдалтай холбоотой байна.

Шүүхээс ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.10 дугаар зүйлийн 2 /2002 оны Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйл/ дахь хэсгийг удирдлага болгон цагдан хоригдсон хугацааг хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцсон байна.

Шүүхээс ял оногдуулахад хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрхэн авч үзсэн талаар судлах нь ялын тохироог тодорхойлоход ач холбогдолтой. Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлын хувьд авч үзвэл 21 буюу 30.8 хувь анх удаа гэмт хэрэг үйлдсэн, 1 буюу 1.4 хувь хохирогчид туслалцаа үзүүлсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн бол 46 буюу 67.6 хувьд нь Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг хэрэглээгүй байна. (График 4.6)


График 4.6 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн хөнгөрүүлэх нөхцөл байдал, хувиар



Үүнээс үзэхэд, хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг анх удаа гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр хөнгөрүүлэх тохиолдол түгээмэл байна.

Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлын хувьд онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн 1 буюу 1.5 хувь, гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн 7 буюу 10.3 хувь, албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотнын хүний эсрэг үйлдсэн 1 буюу 1.5 хувь, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн 21 буюу 30.9 хувь, гэм буруугаа хүлээж, хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй 1 буюу 1.5 хувь, харин хүндрүүлэх нөхцөл хэрэглээгүй тохиолдол 54.4 хувийг тус тус эзэлж байна. (График 4.7)

График 4.7 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн хүндрүүлэх нөхцөл байдал, хувиар




Шүүх шийтгэх тогтоолдоо “Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн”, “бүлэглэж” үйлдсэн гэдгийг хамгийн олон удаа буюу 41 хувьд нь дурджээ. Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 2 дахь

хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй” гэж заасан байна. Гэтэл Эрүүгийн хуулийн тусгай ангид зүйлчлэлээрээ хүндэрсэн зарим нөхцөл байдлыг давхардуулан дурдсан байна.

Ял оногдуулахдаа харгалзан үздэг нэг хүчин зүйл нь гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо барагдуулсан эсэх асуудал байдаг. Судалгаанаас үзэхэд, нийт тохиолдлын 15 буюу 22.1 хувь нь нэхэмжилсэн хохирлыг барагдуулсан бол 53 буюу 77.9 хувь нь ямар нэгэн хохирол нэхэмжлээгүй, түүнийг барагдуулаагүй байна. (График 4.8)

График 4.8 Хохирол нөхөн төлсөн байдал, хувиар




Хүчиндэх гэмт хэргийн нэг онцлог нь ихэнх тохиолдолд хохирол нэхэмжлээгүй байна. Харин судалгаанаас үзэхэд, гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа хохирогчоос уучлал гуйсан, эмнэлгийн үзлэг, ахуйн хэрэгцээнд зориулж хэрэглэх, эсхүл гомдолгүй гэж хэлүүлэх зорилгоор мөнгө, эд хөрөнгө өгөх, амлах тохиолдол цөөнгүй байсан нь хохирогчийн мэдүүлгээс харагдаж байна.

Б. Хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулсан байдал:

Хэргийг хянан шийдвэрлэсэн хугацааны хувьд авч үзвэл 1 жил хүртэл хугацаанд хянан шийдвэрлэсэн 32 буюу 80.0 хувь, 1-2 жил хүртэл хугацаанд хянан шийдвэрлэсэн 7 буюу 17.5 хувь, 3-4 жил хүртэл хугацаанд хянан шийдвэрлэсэн 1 буюу 2.5 хувийг тус тус эзэлж байна. (График 4.9)


График 4.9 Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн хугацаа, хувиар



Үүнээс үзвэл, энэ төрлийн гэмт хэргийг богино хугацаанд хянан шийдвэрлэдэг нь харагдаж байна. Зарим тохиолдолд 2-оос дээш жилийн хугацаанд мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилдэг нь тухайн этгээд олон үйлдэлтэй, нотлох баримт хангалтгүй, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй зэрэг шалтгаантай байна.

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуульд заасан ямар төрлийн ял оногдуулсан эсэхийг авч үзвэл 2 буюу 5.0 хувьд нь цаазаар авах ял, 36 буюу 90 хувь нь төгссөн гэмт хэрэгт тооцож 12-25 жилийн хугацаагаар хорих ял, 2 буюу 5.0 хувьд нь төгсөөгүй гэмт хэрэгт тооцож /завдалт/ 8-11 жилийн хорих ял тус тус шийтгэжээ. (График 4.10)


График 4.10 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хувиар



Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт 95 хувьд нь хорих ял оногдуулсан бол бүх насаар хорих ял хэрэглээгүй байна. Харин цаазаар авах ялыг 2 буюу 5 хувьд нь оногдуулсан байна.

Хорих ялын хугацааны ангиллын хувьд авч үзвэл 10-11 жил хүртэл хугацаатай 2 буюу 5.0 хувь, 12-14 жил хүртэл хугацаатай 3 буюу 7.5 хувь, 15-17 жил хугацаатай 6 буюу 15.0 хувь, 18-20 жил хүртэл хугацаатай 10 буюу 25.5 хувь, 21-23 жил хүртэл хугацаатай 14 буюу 35.0 хувь, 24-25 жил 5 буюу 12.5 хувийг тус тус эзэлж байна. (График 4.11)


График 4.11 Хорих ял оногдуулсан хугацаа, хувиар



Үүнээс үзвэл, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 21-25 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах нь түгээмэл байна.


Гэмт хэрэг үйлдэхдээ завдсан эсэхийг авч үзвэл 2 буюу 5.0 хувь нь завдсан, 38 буюу 95.0 хувь нь төгс үйлдэгдсэн байна. Гэмт хэрэгт хамтран оролцогчид ял оногдуулсан эсэхийг авч үзвэл 5 буюу 12.2 хувьд ял оногдуулсан бол 35 буюу 87.5 хувьд нь хамтран оролцогч байхгүй тул ял оногдуулаагүй байна. (График 4.12)

График 4.12 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт хамтран оролцогчид ял оногдуулсан эсэх, хувиар



Цагдан хоригдсон хугацааны хувьд авч үзвэл 1-3 сар хоригдсон 9 буюу 22.5 хувь, 4-7 сар хоригдсон 20 буюу 50.0 хувь, 8-12 сар хоригдсон 7 буюу 17.5 хувь, 13-18 сар хоригдсон 4 буюу 10.0 хувь байна. (График 4.13)

График 4.13 Цагдан хоригдсон хугацаа, хувиар



Цагдан хоригдсон хугацааны хувьд гэмт хэргийг богино хугацаанд шийдвэрлэж байгаатай холбоотойгоор цагдан хорих хугацаа бага байх талтай байна.


Ял оногдуулахдаа хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон үзсэн тохиолдлыг авч үзвэл анх удаа гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр 9 буюу 22.5 хувь, гэмт хэрэг үйлдсэн даруйдаа хохирогчид тусламж үзүүлсэн 6 буюу 15 хувь, хөнгөрүүлэх нөхцөл байдал хэрэглээгүй 25 буюу 62.5 хувь байна. (График 4.14)

График 4.14 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн ял хөнгөрүүлэх нөхцөл байдал, хувиар



Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлын хувьд авч үзвэл онц хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн 5 буюу 12.5 хувь, бүлэглэж үйлдсэн 3 буюу 7.5 хувь, нийтэд аюултай аргаар 2 буюу 5.0 хувь, өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн 4 буюу 10.0 хувь, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн 16 буюу 40 хувийг тус тус эзэлж байна. Харин 10 буюу 25 хувьд нь хүндрүүлэх нөхцөл байдал хэрэглээгүй байна. (График 4.15)

График 4.15 Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзсэн ял хүндрүүлэх нөхцөл байдал, хувиар



Үүнээс үзвэл, хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн тохиолдол хамгийн их байна.

Бага насны хүүхэд хохирсон гэмт хэргийн хувьд оршуулгын зардал, холбогдох бусад зардлыг нэхэмжилсэн байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг 21 буюу 52.5 хувь нь барагдуулсан бол 19 буюу 47.5 хувь нь барагдуулаагүй байна.

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулсан байдалд дүн шинжилгээ хийхэд, дараах нийтлэг шинж тогтоогдсон. Үүнд:

1. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээг удирдлага болгон хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэж иржээ. Түүвэр судалгаанд хамрагдсан нийт 40 хэргийн 2 буюу 5 хувь нь цаазаар авах, 38 буюу 95 хувьд нь 10-25 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна. Хорих ял оногдуулсан хугацааг авч үзвэл, нийт шийдвэрлэсэн хэргийн 19 буюу 47.5 хувь нь 21-ээс дээш жил, 52.5 хувь нь 20-оос доош жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна.
2. Шүүх бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд 20 жилээс доош хугацаагаар хорих ял оногдуулахдаа анх удаа гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэн даруйдаа хохирогчид тусламж үзүүлсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгасан, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн зэрэг нөхцөл байдлыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцсон байна. Харин онц харгис хэрцгий аргаар алсан, тохуурхан доромжилж, өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн зэрэг нөхцөл байдлыг ихэнх тохиолдолд хүндрүүлэх нөхцөл байдал болгон авч үзжээ. Энэ тохиолдолд 20 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулсан байна.
3. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт 65 буюу 95.5 хувьд нь хорих ял, 3 буюу 4.5 хувьд нь цаазаар авах ял оногдуулсан байна. Хорих ял оногдуулсан 65 тохиолдолд оногдуулсан ялыг үечлэн авч үзвэл 4.6-11 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 2 буюу 2.9 хувь, 12-14 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 4 буюу 6.2 хувь, 15-17 жилийн хугацаагаар

хорих ял оногдуулсан 9 буюу 14.0 хувь, 18-20 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 16 буюу 25.0 хувь, 21-23 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 27 буюу 42.1 хувь, 24-25 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан 6 буюу 9.3 хувийг тус тус эзэлж байна.

4. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа 47.5 хувьд нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, хохирогчид тусламж үзүүлсэн зэрэг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзсэн бол 52.5 хувьд хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзээгүй байна. Харин нийт хэргийн 75 хувьд нь ял оногдуулахдаа хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзсэн бол 25 хувьд нь харгалзан үзээгүй байна. Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн, онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж, өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор, гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн зэрэг ял хүндрүүлэх нөхцөл байдлыг ихэвчлэн харгалзан үзэж, 20-оос дээш жилийн хугацаагаар хорих ял, эсхүл цаазаар авах ял оногдуулсан байна.
5. 2015 оны Эрүүгийн хуулийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдлийн шинж ба гэмт хэргийг төгсгөж чадаагүй нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр ял оногдуулна” гэж заасан. Энэ зохицуулалтаас үзвэл бага насны хүүхдийг алах (10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) эсхүл хүчиндэх гэмт хэрэг (12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг) үйлдэхээр завдсан тохиолдолд хорин жилийн гуравны хоёр буюу дээд тал 13.3 жилийн хорих ялаас хэтрүүлэхгүйгээр ял оногдуулахаар заасан. Тиймээс судалгааны түүвэрт хамрагдсан бага насны хүүхдийг алахаар завдсан 2 тохиолдолд ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дээрх хэм хэмжээг удирдлага болгон 10-11 жил, бага насны хүүхдийг хүчиндэхээр завдсан тохиолдолд 4 жил 6 сараас 11 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан байна. Харин завдсан тохиолдолд оногдуулах ялын доод хэмжээг зааж өгөөгүй нь зарим талаар хэт хөнгөн ял оногдуулах боломж олгосон байна.

4.2. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ТҮҮВЭР СУДАЛГАА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Хүснэгт 4.1

№	Хэргийн товч утга	Эрүүгийн хууль	Зүйл, хэсэг	Оногдуулсан ялын төрөл, хэмжээ	Дундаж ял
1. Хүнийг алах гэмт хэргээ нуун далдлах зорилгоор бага насны хүүхдийг алсан гэмт хэрэгт ял оногдуулсан байдал:					
1	Шүүгдэгч Э.Г 2006 оны 8 дугаар сарын 4-ний өдөр эхнэр О.О-г, 2006 оны 8 дугаар сарын 5-ны өдөр 11 настай хүү О.С-г биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж боомилж алсан.	2002	91.2.15, 91.2.16	25 жил хорих ял	25 жил, цаазаар авах
2	Шүүгдэгч Х.А нь 2008 оны 7 дугаар сарын 14-ний орой согтуу байх үедээ З.М-ийг үл ялих зүйлээр шалтаглан заазуур, хүрз, хүрзний иш мэт бөөрөнхий модоор толгой, цээж хэсэгт олон удаа цохиж алсан, хэргээ нуун далдлах зорилгоор хэвтэрт байдаг бага насны М.Б-ийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж онц харгис хэрцгий аргаар алсан.	2002	91.2.12, 91.2.15, 91.2.16	Цаазаар авах ял	
3	Шүүгдэгч Б.Б нь 2013 оны 3 дугаар сарын 20-21-нд шилжих шөнө 01 цагийн үед согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын эхнэр болох Ч.Ч-г хүчиндэж, шунахайн сэдэлтээр гэрээс ноолуур авсан. Уг гэмт хэргээ нуун далдлах зорилгоор Ч.Ч болон түүний бага насны хүүхдийг мяндсан утсаар боомилж алсан.	2002	126.1, 91.2.6, 91.2.12, 91.2.15, 91.2.16	4 жил хорих ял /126.1/, 25 жил хорих ял /91.2.6, 91.2.12, 91.2.15, 91.2.16/ 25 жил хорих ял биечлэн эдлэх	

4	БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн Ө нь 2016 оны 12 дугаар сарын 30-аас 31-нд шилжих шөнө 00 цагийн орчим эхнэр Ж.Х-г хувийн таарамжгүй харьцааны улмаас заазуураар 6 удаа цавчиж, онц харгис, хэрцгий аргаар алсан, улмаар танхайн сэдэлтээр, хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж эхнэрийн дүүгийн хүүхэд 4 настай А.А-ын зулай хэсэгт 1 удаа заазуурдаж алсан, мөн дагавар хүү 12 настай Ө.Бу-ийн толгой хэсэгт 1 удаа заазуурдаж, эрүүл мэндэд хүнд хохирол учруулж, алахаар завдсан.	2002	91.2.2, 91.2.12, 91.2.15, 91.2.16 32, 32.2, 60.3 91.2.2, 91.2.6, 91.2.15	24 жил хорих ял, 8 жил хорих ял 25 жил хорих ял биечлэн эдлэх	
		2015	Дээрх тохиолдолтой ижил гэмт хэрэг шийдвэрлэгдээгүй.		
2. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг бусад төрлийн гэмт хэрэгтэй хамт үйлдсэн тохиолдолд ял оногдуулсан байдал:					
5	Шүүгдэгч Ө.А нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 2 нас, 7 сартай Т.Н-ийг 2007 оны 11 дүгээр сард нуруу, гэдэс, зүүн мөрөнд нь хазаж тарчлаасан, өмдөндөө шээсэн, үг сонсохгүй байна гэх үл ялих зүйлээр шалтаглан зодож, зүүн 7, 8 дугаар хавиргыг нь хугалж, хүндэвтэр гэмтэл учруулсан, 2007 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 20 цагийн үед согтуугаар танхайн сэдэлтээр, биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж зодож, гавал тархины хүнд гэмтэл учруулж алсан, хохирогчийн ээж болох Т-г гурилын модыг зэвсгийн чанартайгаар ашиглан зодож танхайрсан.	2002	100.1 181.3 91.2.2, 91.2.15	2 жил хорих ял /100.1/, 6 жил хорих ял /181.3/ Цаазаар авах ял 91.2.2, 91.2.15/ Хорих ялыг цаазаар авах ялд багтаан шийдвэрлэсэн.	Цаазаар авах
6	Шүүгдэгч П.Т 2009 оны 8 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө 13 настай Ц.М-ийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан заазуур болон гараараа зодож, толгой, нүүр, гар, хөлд нь олон тооны шарх, цус хуралт үүсгэж, онц харгис хэрцгий аргаар өвтгөн шаналгаж, зовоон тарчлааж хүчиндсэн, хүчиндэх гэмт хэргээ нуун далдлах зорилгоор хохирогчийг нуурын усанд живүүлж алсан.	2002	126.3 91.2.6, 91.2.12, 91.2.15	20 жилийн хорих ял /126.3/, Цаазаар авах ял, Хорих ялыг цаазаар авах ялд багтаасан.	

7	Шүүгдэгч Р.Г нь 2016 оны 10 дугаар сарын 30-ны өдөр иргэн О.Н-ийг сэтгэцийн өвчтэй биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан бэлгийн харьцаанд орсон, уг хэргээ нуун далдлах зорилгоор хэргийг харсан 8 настай гэрч П.Б-г жалган дотор багалзуурдан алсан.	2015	12.1.1 10.1. 2.4, 2.7	2 жил хорих ял /12.1/, 13 жил хорих ял /10.1.2.4, 10.1.2.7/ Хорих ялыг нэмж нэгтгэн биечлэн эдлэх ялыг 15 жилээр тогтоосон.	13 жил хорих ял
		2015	Ялын бодлого зөөлөрсөн, цаазаар авах ялыг хассан.		
3. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд ял оногдуулсан байдал:					
8	Шүүгдэгч Г.М нь өөрийн дагавар охин Ц.О-г эцэг Т.Ц-той бүлэглэн 2015 оны 2 дугаар сарын 15-ны өдөр биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж онц харгис хэрцгий аргаар зодож санаатай алсан, мөн 2014 оны 10 дугаар сарын 24-өөс 2015 оны 2 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд бөөгийн үйл хийж байна гэх нэрийдлээр модон могойгоор байнга зодох, эхийн бузар арилгаж байна хэмээн бэлэг эрхтнийг базаж чимхэх, усанд оруулсны дараа онгорхой цонхны доор зогсоох, үгэнд ороогүй гэж нүд рүү нь будаг арилгагч шингэн цацах, алгадах, хохирогчид арцыг арвай будаатай хольж хүчээр идүүлэх зэргээр тарчлаасан.	2002	36.2, 100.1 91.2.11, 91.2.12, 91.2.15	2 жил хорих ял /100.1/, 22 жил хорих ял, Биечлэн эдлэх ялыг 24 жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосон.	
9	Шүүгдэгч П.Б нь З.С-ийн захиалгаар 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 7 настай Ц.Т-г биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж, гар утасны цэнэглэгч кабель, цахилгааны уртасгагч залгуураар хоолойг нь боож алсан.	2002	35.2, 37.4 91.2.3, 114.3, 91.2.4, 91.2.15	Захиалагч /эмэгтэй/ 20 жил хорих ял, 5 жил 1 сарын хорих ялаар /114.3/ Биечлэн эдлэх ялыг 23 жилээр тогтоосон. Гүйцэтгэгч /насанд хүрээгүй/ 14 жил хорих ял, өмнө нь хойшлуулсан байсан 2 жилийн хорих ялын 1 жилийг нэмж, биечлэн эдлэх ялыг 15 жилээр тогтоосон.	20.2 жил хорих ял

10	Шүүгдэгч Ж.Э нь 2015 оны 9 дүгээр сарын 13-14-нд шилжих шөнө дотно харьцаатай байсан Б.Х-тай маргалдаж, Б.Х-нд түр хугацаагаар амьдарч байсан 4 настай Б.Э-г алах зорилгоор хэд хэдэн удаа сүхдэж хүнд гэмтэл учруулсан, Б.Х-ийн эмээ 81 настай Н.Б-г сүхдэж, танхайн сэдэлтээр, онц харгис хэрцгий аргаар алсан, Б.Х-ын охин 5 настай Б.У-ийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан.	2002	91.2.2, 91.2.6, 91.2.10, 91.2.12, 91.2.15, 91.2.16 96.2.1, 96.2.6, 96.2.9	25 жил хорих ял, 10 жил хорих ял. биечлэн эдлэх ялыг 25 жил хорих ялаар тогтоосон.	
		2015	Дээрх тохиолдлуудтай ижил гэмт хэрэг шийдвэрлэгдээгүй.		
4. Нэг удаагийн үйлдлээр бага насны хүүхдийг алсан гэмт хэрэгт ял оногдуулсан байдал:					
11	Шүүгдэгч Б нь 2009 оны 11 дүгээр сарын 11-ний орой согтуурсан үедээ өөрийн төрсөн ах Ц.Б-тэй “Хүүхдэд хоол бага хийж өгсөн” гэж маргалдаж, улмаар хүүхдэдээ “уураа гаргаж”, өөрийн хүү 1 нас, 6 сартай Т-г биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж, танхайн сэдэлтээр хацар руу нь алгадах, өндөрт өргөж байгаад газарт шидэх зэргээр онц харгис хэрцгий аргаар зодож, алсан.	2002	91.2.2, 91.2.12, 91.2.15	20 жил хорих өмнө нь оногдуулсан 2 жилийн хорих ялын зарим болох 1 жилийг нэмж нэгтгэн биечлэн эдлэх ялыг 21 жилээр тогтоосон.	
12	2010 оны 6 дугаар сарын 20-ны өдөр согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ өөрийн гэртээ дагавар охин 4 настай У.М-ийг олон тооны гэмтэл шарх үүсгэж, онц харгис хэрцгий аргаар санаатай алсан.	2002	91.2.2, 91.2.12, 91.2.15	25 жил хорих ял	21.6 жил хорих ял
13	Шүүгдэгч Г.Ү нь 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 21 цагийн орчим “Авгай” гэж дуудлаа хэмээн үл ялих зүйлээр шалтаглан танхайн сэдэлтээр 13 настай, эмэгтэй О-г чулуугаар нүүрэн тус газарт 2 удаа цохиж, боож амь насыг нь хохироосон, гэмт хэргээ эрэгтэй хүн үйлдсэн мэт харагдуулах зорилгоор өмд, дотуур хувцас, цамцыг тайлж нүцгэлсэн.	2002	91.2.2, 91.2.15	20 жил хорих ял	
14	Шүүгдэгч Б.Д нь 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 20 цагийн үед согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 3 сар, 2 хоногтой өөрийн төрсөн хүүгээ хашаа давуулан шидэж, санаатай алсан.	2015	10.1. 2. 2.7	18 жил хорих ял	15.5 жил хорих ял

15	2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 15 цагийн үед Ж.Д нь нөхөртэйгөө маргалдаж, түүнийг явуулахгүй гэж өөрийн 2 настай төрсөн охиныг машины дугуй руу шидэж алсан байна.	2015	10.1. 2 2.7	12 жил хорих ял
16	2017 оны 8 дугаар сарын 12-13-нд шилжих шөнө М.Б нь эхнэрийнхээ эгчийн нөхрийн охин болох хамт амьдардаг 3 нас, 8 сартай М.А-ийн баруун, зүүн хацар болон баруун гарын сарвууны гадна хэсгийг асаагуураар түлж, онц харгис хэрцгий аргаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, цээжин тус газар нь өшиглөж алсан.	2015	10.1. 2. 2.1, 2.7, 2.8	20 жил хорих ял
17	Шүүгдэгч Х нь 2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан сум ... дугаар баг, ... дугаар гудамжны ... тоотод хамт амьдардаг өөрийн төрсөн эгч А-ын охин болох 3 нас, 11 сар, 14 хоногтой У-г биеэ хамгаалах чадваргүй гэдгийг мэдсээр байж ундаа асгалаа хэмээн үл ялих зүйлээр шалтаглан нэг удаа алгадаж, улмаар ор мөргөж унаснаас зүүн тал бөмбөлгийн чамархай, дагз хэсгийн хатуу хальсан доорх цусан хураа бүхий хүнд гэмтэл учирч хохирогч нас барсан.	2015	10.1.2.2.7, 2.8	12 жил хорих ял
		2015	Ялын бодлого 6.1 жилээр зөөлөрсөн.	
Нийт гэмт хэрэгт оногдуулсан ялын бодлогын өөрчлөлт		2002	91.2	22.2 жил хорих ял
		2015	10.1 2.2.7	14.25 жил хорих ял
		2015	Хорих ялын бодлого 7.95 жилийн хугацаагаар зөөлөрч, цаазаар авах ял хасагдсан.	

Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж, 2002 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт дунджаар 22.2 жилийн хугацаагаар хорих эсхүл цаазаар авах ял оногдуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт дунджаар 14.25 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байгаа нь өмнөх хуультай харьцуулахад ялын бодлого 7.95 жилээр зөөлөрсөн байна. Энэ нь 2015 оны Эрүүгийн хуулийн ялын бодлогын өөрчлөлт, хүнийг алах гэмт хэрэгт оногдуулах ялын доод болон дээд хэмжээг багасгасантай холбоотой.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан хэрэгжүүлж, Эрүүгийн хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг”, Зөрчлийн тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчих” зөрчлийг бие даасан байдлаар хуульчилж, гэр бүлийн хүрээнд удаан хугацаанд үргэлжилдэг хүчирхийлэлтэй тэмцсэний үр дүнд 2015 оноос хойш үйлдэгдэж, шүүхээр шийдвэрлэгдсэн бага насны хүүхдийг алах гэмт хэргүүдийн дотор удаан хугацаанд үргэлжилсэн хүчирхийлэл, онц харгис хэрцгий аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг цөөн байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-1

Эрүүгийн хэргийн дугаар: 20606281

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
37, 2007.04.04

Шийдвэрлэсэн шүүх: Дорноговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Э.Г, 1969 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Сүхбаатар аймгийн Наран суманд төрсөн, 38 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, жолооч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 3, эхнэр, хүүгийн хамт Дорноговь аймгийн Сайншанд сумын ... дугаар баг ... тоотод оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн О.О, эмэгтэй, /шүүгдэгч Э.Г-ийн эхнэр/.

Монгол Улсын иргэн О.С, 11 настай, эрэгтэй, /шүүгдэгч Э.Г-ийн хүү/.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Э.Г 2006 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Сүхбаатар аймгийн

Наран сумын нутагт эхнэр О.О-г, 2006 оны 8 дугаар сарын 5-ны өдөр 11 настай хүү О.С-г биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж боомилж тус тус алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Хардалт, гэр бүлээс гадуурх харилцаа. Тухайлбал, хохирогч О.О-г Ж гэгчтэй явалддаг болохыг шүүгдэгч мэддэг байсан бөгөөд та 2 арай дэндэж байна, хүүхдээ бодооч гэж удаа дараа хэлж байсан.

Оногдуулсан ял: Шүүгдэгчид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.15, 91.2.16 дахь хэсэгт зааснаар 25 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн.

Дүгнэлт: Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.12 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүх хэрэгсэхгүй болгосон байна. Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, хохирогч О.О, О.С нарыг алахын өмнө болон алах явцдаа олон тооны шарх, гэмтэл үүсгэж, өвтгөн шаналгасан, тарчилган зовоосон байдал тогтоогдохгүй байна. Иймд шүүхээс онц харгис хэрцгий аргаар үйлдсэн гэх хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрэгсэхгүй болгосон нь зүйтэй байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-2

Эрүүгийн хэргийн дугаар: 20740111

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 227, 2008.07.10

Шийдвэрлэсэн шүүх: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ө.А, 1976 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 32 настай, эрэгтэй, халх, бага боловсролтой, барилгын засал

чимэглэлчин мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 2, эхнэрийн хамт Чингэлтэй дүүргийн ... дугаар хороо, Булгийн ... тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, 2003 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар 5 жил 10 хоногийн хугацаагаар хорих ял шийтгүүлж, 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн Хан-Уул дүүргийн шүүхийн 39 дүгээр захирамжаар хугацаанаас өмнө эдлээгүй үлдсэн 1 жил, 7 сар, 10 хоногийн хорих ялыг тэнсэж, хянан харгалзсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Хохирогч Т.Н нь 2 нас 7 сартай, эмэгтэй, төрсөн эх, хойд эцгийн хамт Чингэлтэй дүүргийн ... дугаар хороо, Булгийн ... тоотод оршин суудаг, архаг хууч өвчингүй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Ө.А нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 2 нас 7 сартай Т.Н-ийг 2007 оны 11 дүгээр сард нуруу, гэдэс, зүүн мөрөнд нь хазаж тарчлаасан, 2007 оны 11 дүгээр сард өмдөндөө баасан, үг сонсохгүй байна гэх үл ялих зүйлээр шалтаглаж зодож зүүн 7, 8 дугаар хавиргыг нь хугалж хүндэвтэр гэмтэл учруулсан, 2007 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 20 цагийн үед согтуугаар танхайн сэдэлтээр, бие хамгаалах чадваргүй байгааг мэдсээр байж зодож, гавал тархины хүнд гэмтэл учруулж амь насыг нь хөнөөсөн, хохирогчийн ээж болох Т-г гурилын модыг зэвсгийн чанартайгаар ашиглан зодож танхайрсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Дагавар хүүхэд, хамтран амьдрагч Т нарыг байнга зодож, тарчлааж, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг байсан, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн

хэрэглэсэн, түрэмгий зан, биеэ барих чадваргүй байдал, дагавар хүүхдийг үзэн ядах сэтгэл, гэр бүл салалт, гэмт хэрэг үйлдэгдэх үед шүүгдэгч, хохирогч хоёр хамт байсан зэрэг нөхцөл байдал нь дээрх гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болжээ.

Шүүгдэгч ёс суртахууны доголдолтой, бие барих чадваргүй, цочмог ууртай болох нь урьд үйлдсэн гэмт хэргийн шинж чанар /Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, хамтран амьдрагч Т болон дагавар охин А нарыг удаа дараа зодож байснаас тогтоогдож байна. Энэ нь дээрх гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон бөгөөд ялэдэлж байхдаа хугацаанаас өмнө тэнссэн суллагдсан байгааг анхаарах шаардлагатай. 2002 оны Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт “Хорих ял шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болно” гэж заасан. Хорих ангиас хугацаанаас өмнө тэнсэн суллагдахад ялтны зан байдлын тодорхойлолтыг тухайн хорих ангийн дарга гаргаж, шүүхээс шийдвэр гаргадаг. Хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлаас үзэхэд, шүүгдэгч зан байдлын хувьд засарч хүмүүжсэн шинж харагдахгүй байна. Практикт хугацаанаас өмнө тэнссэн суллахад 74 дүгээр зүйлд заасан бүх шалгуурыг хангасан байхыг шаардахгүй, зөвхөн хорих ялын тодорхой хугацааг биечлэн эдэлсэн байхыг голчлон анхаарч байгаа нь энэ төрлийн хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болж байна. 2015 оны Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох үндэслэлд “...ялтан зан

байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй...” гэсэн шалгуурыг заасан байгааг хорих байгууллага сайтар тодорхойлж байх нь хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол үндэслэл болно. Түүнчлэн, Монгол Улсад гэр бүл салалт, ялангуяа хүүхэдтэй гэр бүлийн салалт өсч байгаа нь хүүхэд гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байгааг анхаарч, иргэдийн гэр бүлийн боловсрол, гэр бүл салалтаас үүсэх хор уршгийг таниулах, гэр бүл төлөвлөлтийн ач холбогдол, боловсролын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Ө.А-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт /тарчлаах/ зааснаар 2 жил, 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсэгт /танхайрах/ зааснаар 6 жил, хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж алсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 91.2.2, 91.2.15 дахь хэсэгт зааснаар цаазаар авах ял оногдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан хорих ялыг цаазаар авах ялд багтаан шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдалд тохирсон гэж үзэж байна. Шүүхээс ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.4, 56.1.6, 56.1.10, 56.1.12 дахь хэсэгт зааснаар бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн, ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн зэргийг хүндрүүлэх нөхцөлд харгалзан үзжээ.

Эрүүгийн хэргийн дугаар: 20804180

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
№96, 2018.11.12

Шийдвэрлэсэн шүүх: Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Х.А, Булган аймгийн Булган суманд 1984 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр төрсөн, 24 настай, халх, эрэгтэй, боловсрол мэргэжилгүй, ам бүл 6, эцэг эх, ах, дүү нарын хамт Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, ... тоотод оршин суух, эрхэлсэн тодорхой ажилгүй, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгэгдэж байгаагүй, бие эрүүл, ухаан мэдрэл бүрэн.

Хохирогчийн хувийн байдал: Өвөр Монгол гаралтай Монгол Улсын иргэн З.М, Булган аймгийн Булган сумын ... дугаар баг, ... тоотод, оршин суудаг, ам бүл 3, хүү, охины хамт амьдардаг, эрхэлсэн тодорхой ажилгүй, хөдөлмөрийн чадваргүй, мэргэ төлөг үзэх замаар амьдардаг.

Хохирогч Монгол Улсын иргэн М.Б нь төрөлхийн тархины саажилттай, хэвтэрт байдаг, тэдний охин болох М.М нь сэтгэцийн өөрчлөлттэй, гэр бүлийн 3 гишүүн халамжийн тэтгэвэр авдаг. Ах дүү хамаатан садан байхгүй, сургууль, цэцэрлэгт хамрагддаггүй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Х.А нь 2008 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн орой согтуу үедээ Булган сумын ... дугаар баг, ... тоотод оршин суух иргэн З.М-ийн “..Тэр хүүхэн чинь янхан, банзал, хүүхэд нь ч бас хоноцын шээс” гэж хэлж, шүүгдэгчийн араас төмөр эд зүйл шидсэнд өсөрхөн заазуур, хүрз, хүрзний иш мэт бөөрөнхий модоор толгой, цээж хэсэгт олон удаа

цохиж амь насыг нь хөнөөсөн, үйлдсэн хэргээ нуун далдлах зорилгоор төрөлхийн тархины саажилттай, хэвтэрт байдаг хүү болох бага насны М.Б-ийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж хүрзээр олон удаа цохиж, онц харгис хэрцгий аргаар алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Шүүгдэгч согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэж, өөрийн үйлдлээ ухамсарлан ойлгож, удирдан жолоодох чадваргүй болсон байдал, мухар сүсэгт итгэж, бусдын хэлсэн үгэнд өсөрхөн туньсан, гэмт хэргээ нуун далдлах зорилго, насанд хүрсэн хохирогчийн зүй бус үйлдэл зэрэг нь дээрх гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болжээ. Шүүгдэгч нь эрхэлсэн тодорхой ажилгүй улмаас мөрийтэй тоглох, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэх зан төлөвтэй болсон, өөрийн үйлдсэн хэргээ нуун далдах зорилгоор бусад хүнийг алах нь өөрт нь ашигтай байдлыг бий болгоно гэсэн явцуу бодол нь хэрэг явдлын учир холбогдлыг ойлгохгүй, сэтгэцийн өвчтэй бага насны хүүхдийг алах шалтгаан болжээ. Түүнчлэн, хохирогчийн зүй бус үйлдэл нь энэ гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн. Насанд хүрсэн хохирогч М нь мэргэ төлөг хийх нэрээр бусдыг хэл амаар доромжлон, гэмт хэрэг үйлдсэн хүнд хүч хэрэглэсэн байдал нь “..Тэр хүүхэн чинь янхан, банзал, хүүхэд нь ч бас хоноцын шээс юм байна гэж хэлэхээр нь босоод гараад явах гэтэл араас хутга бололтой нэг зүйл шидсэн, тэгэхээр нь би буцаж очоод хохирогч М-ийг цохисон” гэх шүүгдэгчийн мэдүүлэг, мэдүүлгийг газар дээр нь шалгасан ажиллагааны үр дүнгээс тогтоогдож байна. Шүүгдэгч нь өөрийн урьд үерхэж байсан эмэгтэй, түүний хүүхдэд хайртай байсан учраас дээрх зүй бус үг хэллэгт цочрон давчдаж,

хууль бус үйлдэл хийсэн байна. Талийгаачийн бага охин М.М-ийг сэтгэцийн өөрчлөлттэй гэсэн шалтгаанаар “Асрамжийн газар”, “Шар хад”-ны эмнэлэг хүлээн авах боломжгүй гэж мэдэгдсэн бөгөөд багийн Засаг дарга албан бусаар тэжээн тэтгэж байгаа нь энэ гэмт хэргийн хор уршгийг илэрхийлж байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Х.А-д онц харгис хэрцгий аргаар хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж, хоёр хүний амь насыг хөнөөсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.12, 91.2.15, 91.2.16-д зааснаар цаазаар авах ял оногдуулсан. Шүүгдэгчийн 116 хоног цагдан хоригдсоныг дурдаж, давж заалдах болон Монгол Улсын Ерөнхийлөгчөөс уучлал хүсэх эрхтэйг тус тус дурдсан байна.

Дүгнэлт: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэгт зааснаар 15-25 жил хүртэл хугацаагаар хорих ял эсхүл цаазаар авах ял оногдуулж болохоор заасан байтал цаазаар авах ял оногдуулсан нь ял хүндэдсэн гэж үзэж байна. Шүүгдэгч Х.А-д ял шийтгэл оногдуулахдаа хөнгөрүүлэн үзэх нөхцөл тогтоогдоогүй. Харин согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас хоёр хүний амь нас хохирсон байдлыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцож цаазаар авах ял оногдуулах үндэслэл болгожээ. 2002 оны Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.10 дахь хэсэгт “Согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн” бол хүндрүүлж үзэхээр заасан тул дээрх нөхцөл байдлын хүндрүүлэх нөхцөл болгон авч үзсэн нь зүйтэй. Харин мөн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн 56.1-д заасан хүндрүүлэх нөхцөл байдал нь уг

хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болж байгаа бол түүнийг ял оногдуулахдаа харгалзаж үзэхгүй” гэж заасан байхад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.16 дахь хэсэгт заасан хоёр буюу түүнээс олон хүний амь насыг хохироосон байдлыг хүндрүүлэх нөхцөл байдалд давхардуулан дурдсан байна. Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, бага насны хохирогчийг үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах зорилгоор амь насыг нь хохироосон байхад шийтгэх тогтоолд дурдсан зүйлчлэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91.2.6 дахь хэсэгт заасан “Өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор” гэсэн заалтыг тусгаагүй байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлийн 55.1.4 дэх хэсэгт “Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхэд автсан...”, мөн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.5 дэх хэсэгт “хохирогчийн хууль бус үйлдлээс болж санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас...” гэмт хэрэг үйлдсэн бол хөнгөрүүлэх нөхцөл байдал тооцохоор заасан атал дээрх нөхцөл байдлыг харгалзан үзээгүй байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-4

Эрүүгийн хэргийн дугаар: 20904213

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 84, 2010.01.25

Шийдвэрлэсэн шүүх: Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн П.Т, 1984 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Булган аймгийн Тэшиг суманд төрсөн, 26 настай, эрэгтэй, боловсролгүй, мэргэжилгүй,

эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 5, эцэг, эх, ах, дүүгийн хамт Булган аймгийн Тэшиг сумын ... дүгээр багт оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, 2006 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-т зааснаар 3 сар, 1 хоногийн баривчлах ялаар, мөн хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д зааснаар 4 жил, 6 сарын хорих ялаар шийтгүүлж, 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4.4-д зааснаар эдлээгүй үлдсэн 4 жил, 9 хоногийн хорих ялаас өршөөн суллагдсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ц.М, 13 настай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч П.Т 2009 оны 8 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө Булган аймгийн Тэшиг сумын ... дугаар багийн нутаг ... гэх газар 13 настай Ц.М-ийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан заазуур болон гараараа зодож, толгой, нүүр, гар, хөлд нь олон тооны шарх, цус хуралт үүсгэж, онц харгис хэрцгий аргаар өвтгөн шаналгаж, зовоон тарчлааж хүчиндсэн, хүчиндэх гэмт хэргээ нуун далдлах зорилгоор хохирогчийг нуурын усанд живүүлж алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Хүүхдэд тавих анхаарал, халамж сул байдал нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, хохирогч Ц.М-ийг дүүгийнх нь хамтаар гэрт нь үлдээж, эцэг нь хадланд, эх нь аймгийн төв олон хоногоор явсан.

Оногдуулсан ял: Шүүгдэгчид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар 20 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.6, 91.2.12, 91.2.15 дахь хэсэгт зааснаар цаазаар авах

ялаар тус тус шийтгэж, мөн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар цаазаар авах ялд багтаасан байна.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалтай нийцэж байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 20933764

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №331, 2010.08.02

Шийдвэрлэсэн шүүх: Баянгол дүүргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ц.Б, 1976 оны 8 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 34 настай, эрэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, цахилгаанчин мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 3, эгч, дүүгийн хамт Баянгол дүүрэг ... дугаар хороо, Зүүн Нарангийн ... тоотод оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, 1998 онд Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлийн 2-д зааснаар 1 жил 6 сар хорих ялаар, 2003 онд Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлийн 146.2-д зааснаар 6 сарын хугацаагаар баривчлах ялаар, 2009 онд Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-д зааснаар 2 жил хугацаагаар хорих ял шийтгэгдэж, уг хорих ялыг тэнсэж 1 жилийн хугацаагаар тэнсэн харгалзсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Т, 1 нас 6 сартай, эрэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б нь 2009 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн орой Баянгол

дүүргийн ... дугаар хороо, ... тоотод согтуурсан байх үедээ өөрийн төрсөн ах Ц.Б-тэй “Хүүхдэд хоол бага хийж өглөө” гэдгээр шалтаглан маргалдаж, улмаар хүүхдэдээ уураа гаргаж, өөрийн хүү 1 нас 6 сартай Т-г бие хамгаалж чадахгүйг мэдсээр байж, танхайн сэдэлтээр хацар руу нь алгадах, өндөрт өргөж байгаад газарт шидэх зэргээр онц харгис хэрцгий аргаар зодож, элэгний баруун зүүн дэлбэнгийн язарсан урагдал, зүрхний баруун тосгуурын орох хэсгийн хураагуур судасны язарсан урагдал, зүүн хацар, эрүү, дээд, доод уруул, цээж, нуруунд цус хуралт үүсгэх замаар олон тооны шарх гэмтэл учруулан амь насыг нь хохироосон.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Ахуйн хүрээнд согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хүүхдээ тэжээн тэтгэх чадваргүй байдал, зан төлвийн доголдол, хүүхдэд тавих төрийн байгууллагын хараа хяналт сул зэрэг нь энэ гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болжээ.

Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, шүүгдэгч өөрийн гэр оронгүй, санхүүгийн чадваргүй, нийгэмд эзэлсэн байр суурьгүй болох нь тогтоогдож байгаа бөгөөд согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг байна.

Шүүгдэгч Б өмнө нь 3 удаа гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж байснаас үзэхэд, нийгэмд эзэлсэн тодорхой байр суурьгүй, түрэмгий, хэрцгий болсныг харуулж байна. Шүүгдэгч Б 2007 онд хорих ял эдэлж байхдаа ялтан М гэгчтэй танилцаж, 2008 оны 4 дүгээр сард тэд хүүтэй болсон. Хохирогч “Т” 1 нас хүртлээ өөрийн эх ялтан М-тэй хорих ангид байж байгаад 2009 онд аав болох Б хорих ял эдэлж дууссанахаа дараа өөрийн эгч болох Н-ийн хамт ирж авч явсан.

Хорих ангид байхдаа танилцсан хүмүүс гэр бүл болох, хүүхэд төрүүлэх, хүүхдийг хорих ангиас гаргах нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан “Хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй” гэсэн зохицуулалт зөрчигдөхөд хүрч байна. Нөгөө талаар эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогын эх үүсвэргүй хүн, түүнийг хариуцаж батлан даах талаар баталгаа гаргасан хүмүүс хүүхдийг эрүүл аюулгүй орчинд өсгөх талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд төрийн байгууллагын хяналт сул байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх нэг нөхцөл болжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Б-ын танхайн сэдэлтээр, онц харгис хэрцгий аргаар, бие хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж 1 нас 6 сартай Т-г санаатай алсан үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.12, 91.2.15-д зааснаар 20 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн. Мөн ял дээр нэмж 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 75 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-д зааснаар оногдуулсан 2 жилийн хорих ялын зарим болох 1 жилийг нэмж нэгтгэн биечлэн эдлэх ялыг 21 жилээр тогтоож, цагдан хоригдсон 259 хоногийг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохоор шийдвэрлэжээ.

Дүгнэлт: Шүүхээс оногдуулсан ял төрөл, хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохирсон гэж үзэх үндэстэй байна. Шүүх ял оногдуулахдаа согтуугаар, ялтай байхдаа гэмт хэрэг үйлдсэнийг эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл болгон авч үзсэн. 2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр

зүйлийн 91.2 дахь хэсэгт хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг санаатай алсан тохиолдолд 15-25 жил хүртэл хорих ялаар шийтгэх, эсхүл цаазаар авах ял оногдуулахаар заасан. Шийтгэх тогтоолд дурдсанаар шүүгдэгчид 20 жилийн ял оногдуулсан бөгөөд ямар үндэслэлээр хөнгөрүүлсэн талаар тодорхой дурдаагүй байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 21038045

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 384, 2010.10.05

Шийдвэрлэсэн шүүх: Сонгино хайрхан дүүргийн шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн М.Х, 1987 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Хэнтий аймгийн Хэрлэн суманд төрсөн, 22 настай, эрэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, мэргэжилгүй, ... ХХК-д ноос угаагч ажилтай, ам бүл 3, эхнэр, хүүхдийн хамт Сонгино хайрхан дүүргийн ... хороо Хилчний ... тоотод оршин суух, Баянзүрх дүүргийн шүүхийн 2005 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 382 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дах хэсэгт зааснаар 2 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, уг ялыг 2 жилийн хугацаагаар тэнсэж хянан харгалзсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн У.М, 2006 онд төрсөн 4 настай, эмэгтэй, аав, ээж, дүүгийн хамт амьдардаг байсан.

Хэргийн товч утга: 2010 оны 6 дугаар сарын 20-ны өдөр согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ өөрийн гэртээ дагавар охин 4 настай У.М-ийг олон тооны гэмтэл, шарх үүсгэж, онц харгис хэрцгий аргаар санаатай алсан.

Шалтгаан нөхцөл: Шүүгдэгч М.Х нь дагавар охиноо гэртээ ирсэн өдөр ээжийг нь дэлгүүр явсны дараа дүүгээ миний дүү биш гэж хэллээ, мөн өмдөндөө бие заслаа гэх шалтгаанаар олон удаа алгадаж, зодож алсан байна. Эндээс үзэхэд, ахуйн хүрээнд архи дан согтуурах явдал, гэр бүл салалт гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн байна. Мөн хүүхэддээ тавих хараа хяналт сул согтууруулах ундаа хэрэглэсэн хүнтэй үлдээсэн нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн байж болох юм.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.12, 91.2.15-д зааснаар 25 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялын 3 жилийг гяндан, үлдсэн хугацааг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүхээс ял оногдуулахдаа шүүгдэгчийг согтуугаар гэмт хэрэг үйлдсэнийг хүндрүүлэх нөхцөлд тооцож, хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзжээ. Шүүгдэгч нь өөрөө 2 сартай хүүхэдтэй байсан атлаа дагавар хүүхдээ алсны улмаас төрсөн хүүхэд нь эцэггүй өсөх, өөрөө хорих ял эдэлж, эхнэр нь өнчин хүүхэд өсгөх амаргүй байдлыг үүсгэж байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-7

Эрүүгийн хэргийн дугаар: 21141251

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №40, 2012.01.19

Шийдвэрлэсэн шүүх: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Г.Ү, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт 1986 оны 6 дугаар сарын 23-ны өдөр

төрсөн, 26 настай эмэгтэй, халх, бүрэн бус дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 7, эх, дүү, нөхөр, 2 хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ... дугаар хороо Согоотын ... тоотод оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгэгдэж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Эцэг эхийн хамт амьдардаг, 13 настай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч ГҮ нь 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 21 цагийн орчим согтуугаар Чингэлтэй дүүргийн ... дугаар хороо Согоотын ... дугаар гудамжинд байх жалганд “Авгай” гэж дуудлаа хэмээн үл ялих зүйлээр шалтаглан нийгмийн хэв журмыг ноцтой зөрчин танхайн сэдэлтээр 13 настай, эмэгтэй О-г биеэ хамгаалах чадваргүй байгааг мэдсээр байж чулуугаар нүүрэн тус газарт 2 удаа цохиж, улмаар хоолойг нь багалзуурдан боож, амыг нь тагласнаас амьсгал бүтэлтэд оруулан санаатай алж, гэмт хэргээ эрэгтэй хүн үйлдсэн мэтээр харагдуулах зорилгоор өмд, дотуур хувцас, цамцыг тайлж нүцгэлсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Эцэг, эх нь бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхисон, олон нийтийн газарт худалдаа эрхлүүлсэн, хохирогч “О” мөнгө олох зорилгоор үл таних эмэгтэйд туслахаар дагаж явсан, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн түрэмгий зан, бие барих чадваргүй байдал, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн, гэмт хэрэг үйлдэгдэх үед харанхуй болж үзэгдэх орчин хязгаарлагдаж олон нийтийн хяналтаас гарсан байсан зэрэг нь гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болжээ.

2011 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хохирогчийн ээж “Э” нь өөрийн гэр шатсан тул орох газар

байхгүй, даарах байх гэсэн шалтгаанаар төрсөн охин “О”-г өөрийн найз “С”-д үлдээгээд явсан. 2018 оны 10 дугаар сарын 14-ний өдөр “С” гэгч өөрийн охин “Оч”, найзын охин талийгаач “О” нараар Чингэлтэй дүүрэгт байрлах 17 дугаар сургуулийн автобусны буудлын хажуугийн гүүрэн дээр хонь, ямааны чанасан толгой заруулах ажил хийлгээд хараа хяналтгүй орхисон. Энэ хугацаанд согтууруулах ундаа хэрэглэсэн 30 орчим насны бага насны 2 хүүхэд дагуулсан эмэгтэй ирж, тэр хоёрт хүүхдээ харуулаад гүүрэн доор архи уусан, улмаар эгчдээ туслаад хүүхэд гэрт хүргэж өгвөл 2000 төгрөг өгнө гэсэн амлалтын дагуу талийгаач “О” үл таних эмэгтэйг дагаж яваад, буцах замдаа маргалдан зодуулж, боолгосны улмаас амь насаа алдсан.

Оногдуулсан ял: Шүүгдэгч ГҮ-г бага насны хүүхдийг танхайн сэдэлтээр, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж санаатай алсан гэж үзэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.15 дахь хэсэгт зааснаар зүйлчилж, 20 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, цагдан хоригдсон 95 хоногийг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож, шүүгдэгчийн бага насны 2 хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр шүүгдэгчийн ээжийг тогтоосон байна.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял тохирсон гэж үзэх үндэстэй. Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, эмэгтэй хүн, бага насны хүүхэдтэй, оршуулгын зардлыг нөхөн барагдуулсан гэсэн нөхцөл байдлыг үндэслэн оногдуулах ялыг хөнгөрүүлсэн

байх талтай боловч шүүхийн шийтгэх тогтоолд энэ талаар дурдаагүй байна. Харин согтуурсан, бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж алсан гэсэн үндэслэлээр түүнд оногдуулах ял шийтгэлийг хүндрүүлж байгааг шийтгэх тогтоолд дурдсан байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 201310000063

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 69, 2013.07.17

Шийдвэрлэсэн шүүх: Дорноговь аймаг дахь сум дундын хоёрдугаар шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Б, 1990 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Дорноговь аймгийн Сайншанд суманд төрсөн, 23 настай, эрэгтэй, боловсролгүй, мэргэжилгүй, ажилгүй, ам бүл 6, аав, ээж, дүү нарын хамт Сайншанд сумын ... дугаар баг, Хамарын хийдэд оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн, 2009 онд төрсөн 3 настай, эмэгтэй, аав, ээж, эгчийн хамт амьдардаг байсан.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Б нь 2013 оны 3 дугаар сарын 20-21-нд шилжих шөнө 01 цагийн үед согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг Улаан гэх газарт нутаглах Ө.Б-ийн гэрт эхнэр болох Ч.Ч-г хүчиндэж, шунахайн сэдэлтээр гэрээс ноолуур авсан ба үйлдсэн гэмт хэргүүдээ нуун далдлах зорилгоор Ч.Ч болон түүний бага насны хүүхдийг мяндсан утсаар боомилж санаатай алсан.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл: Шүүгдэгч Б.Б нь хүчиндэх гэмт хэрэг үйлдэж, улмаар гэмт хэргээ нуун далдлах зорилгоор бага насны хүүхдийг боомилж алсан байна. Энэ нь бэлгийн дур хүслээ хангах болон амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэдэлттэй байхаас гадна хүнийг алахыг юман чинээ тоохгүй, хувь хүний ухамсар, төлөвшилтэй холбоотой нь эхнэр, хүүхдийг нь боомилж алчхаад буцаж ирээд нөхөртэй нь юу ч болоогүй мэт хамт хоносон байдлаас харагдаж байна.

Монгол Улсын нүүдэлчин соёл буюу хөдөө ганц нэг гэрээрээ амьдардаг байдал гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д зааснаар 4 жилийн хугацаагаар хорих ял, мөн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.6, 91.2.12, 91.2.15, 91.2.16-д зааснаар 25 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэжээ. Оногдуулсан хорих ялын хөнгөнийг хүндэд нь багтаасан бөгөөд хорих ялын 5 жилийг гяндан, үлдэх 20 жилийн хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэнийг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцсон байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-9

Эрүүгийн хэргийн дугаар: 2015250001693

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 1193, 2015.10.07

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн ... овогт Г.М, 1990 оны 6 дугаар сарын 8-ны

өдөр Улаанбаатар хотод төрсөн, халх, 25 настай, эмэгтэй, бүрэн дунд боловсролтой, гоо сайханч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 3, нөхөр охины хамт Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, ... дүгээр гудамж, ... тоотод оршин суух хаягтай /одоо Баянзүрх дүүрэг 2 дугаар хороо, ... хотхоны ... тоотод оршин суудаг/, бие эрүүл, хэрэг хариуцах чадвартай, улсаас авсан гавьяа шагналгүй, Баянзүрх дүүргийн шүүхийн 2013 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 411 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар 2 жил хорих ялыг 1 жилийн хугацаагаар тэнсэж хянан харгалзаж байсан.

Монгол Улсын иргэн ... овогт Т.Ц. 1985 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 29 настай, эрэгтэй, халх, бүрэн дунд боловсролтой, криминалистикийн шинжээч мэргэжилтэй, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Баянзүрх дүүрэг хариуцсан тасгийн криминалистикийн шинжээч ажилтай, ам бүл 3, эхнэр охины хамт Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо, ... дүгээр хотхон, ... дугаар байр, ... тоотод оршин суух хаягтай /одоо Баянзүрх дүүрэг 2 дугаар хороо, ... хотхоны ... тоотод оршин суудаг/, бие эрүүл, хэрэг хариуцах чадвартай, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ц.О, 3 нас, 11 сартай, эмэгтэй, эцэг, хойд эхийн хамт Баянзүрх дүүрэг 2 дугаар хороо, ... хотхоны ... тоотод амьдарч байсан.

Хэргийн товч утга: Г.М нь өөрийн дагавар охин Ц.О-г эцэг Т.Ц-той бүлэглэн 2015 оны 2 дугаар сарын 15-ны өдөр биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж онц харгис хэрцгий аргаар

зодож санаатай алсан, мөн 2014 оны 10 дугаар сарын 24-өөс 2015 оны 2 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд бөөгийн үйл хийж байна гэх нэрийдлээр модон могойгоор байнга зодох, эхийн бузар арилгаж байна хэмээн бэлэг эрхтнийг базааж чимхэх, усанд оруулсны дараа онгорхой цонхны доор зогсоох, үгэнд ороогүй гэж нүд рүү нь будаг арилгагч шингэн цацах, алгадах, хохирогчид арцыг арвай будаатай хольж хүчээр идүүлэх зэргээр тарчлаасан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй, таслан зогсоогоогүй нийтийн байрны хөршүүд, хохирогчийн төрсөн эх Б.Ө-ийн шууд бус буруутай үйлдэл нөлөөлжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Г.М, Т.Ц нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт зааснаар 2 жилийн хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.11, 91.2.12, 91.2.15 дахь хэсэгт зааснаар 22 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэж, мөн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг журамлан хорих ялыг нэмж нэгтгэн, нийт биечлэн эдлэх ялыг 24 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус тогтоосон.

Дүгнэлт: Шүүгдэгчдэд оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

Шүүгдэгч Г.М-г нөхөр Т.Ц-тэй бүлэглэн хүнийг санаатай алах болон тарчлаах гэмт хэргийг

үйлдсэн гэж шийдвэрлэсэн нь зүйтэй бөгөөд шүүхээс хэрэгт цугларсан нотлох баримтыг үнэлж, гэмт хэрэг хамтран үйлдэх хэлбэрийг зөв тодорхойлжээ.

Эрүүгийн хэргийн дугаар: 201514000452

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 68, 2017.03.27

Шийдвэрлэсэн шүүх: Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн ... овогт Ж.Э, 1988 оны 8 дугаар сарын 22-ны өдөр Завхан аймгийн Тэс суманд төрсөн, 28 настай, эрэгтэй, боловсролгүй, мэргэжилгүй, мал малладаг, ам бүл 1, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Хайлантай гэх газар оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, хохирогч Б.Х-тэй дотно харьцаатай байсан.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Х, 27 настай, эмэгтэй, ам бүл 3, эмээ Н.Б, охин Б.У нарын хамт Орхон аймгийн Баян-Өндөр сум, Баянцагаан баг, ... гудамжны ... тоотод оршин суудаг.

Монгол Улсын иргэн Б.Э, 4 настай, эрэгтэй, / гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч Б.Х-ийн гэрт түр амьдарч байсан/.

Монгол Улсын иргэн Н.Б, 81 настай, эмэгтэй, / хохирогч Б.Х-ийн эмээ/

Монгол Улсын иргэн Б.У, 5 настай, эмэгтэй / хохирогч Б.Х-ийн охин/.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Ж.Э нь 2015 оны 9 дүгээр сарын 13-аас 14-нд шилжих шөнө Орхон

аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан баг ... гудамжны ... тоотод дотно харьцаатай байсан Б.Х-тай маргалдан Б.Х, Б.Х-ынд түр хугацаагаар амьдарч байсан 4 настай Б.Э-г алах зорилгоор хэд хэдэн удаа сүхдэж, алсан, Б.Х-ийн эмээ 81 настай Н.Б-г сүхдэж, танхайн сэдэлтээр, онц харгис хэрцгий аргаар, олон хүнийг алсан, Б.Х-ын охин 5 настай Б.У-ийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэр бүлийн хүчирхийлэл, хардалт. Тухайлбал, шүүгдэгч хохирогч Б.Х-г нэг залуутай тэврэлдээд зогсож байсан учраас маргалдаж, улмаар сүхээр толгой руу нь хэд хэдэн удаа цохиж, хохирогч Б.Х-г хамгаалахаар гэрээс гарч ирсэн эмээ, гэрт байсан бага насны хүүхдүүдийг алсан, алах зорилгоор гэмтэл учруулсан байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгчид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.6, 91.2.10, 91.2.12, 91.2.15, 91.2.16 дахь хэсэгт зааснаар 25 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.2.1, 96.2.6, 96.2.9 дэх хэсэгт зааснаар 10 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэж, мөн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар 25 жилийн хугацаагаар хорих ялд багтааж, түүний биечлэн эдлэх ялыг нийт 25 жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосон байна.

Дүгнэлт: Шүүгдэгчид ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдал байхгүй болохыг дурдаж, түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хугацаатай ялын

дээд хэмжээгээр ял шийтгэж, оногдуулсан ялын заримыг гянданд, заримыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.10 дахь хэсгээр яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхдээ хэрэгсэхгүй болголгүй, ял оногдуулсан нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, хохирогч Н.Б-г алсан, Б.Х, Б.Э-г алах зорилгоор халдсан үйлдэл нь нэг цаг хугацаанд хийгдсэн тул давтан гэмт хэргийн шинжид хамаарахгүй.

ТҮҮВЭР СУДАЛГАА-11

Эрүүгийн хэргийн дугаар: 201611000373

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №88, 2017.06.22

Шийдвэрлэсэн шүүх: Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн П.Б, Дорнод аймгийн Хэрлэн суманд 1998 оны 10 дугаар 22-ны өдөр төрсөн, 18 настай эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, ам бүл 4, өвөө, эмээ, эгчийн хамт Дорнод аймгийн Хэрлэн сумын ... дүгээр багийн ... тоотод оршин суух, эрхэлсэн тодорхой ажилгүй, улсаас авсан гавьяа шагналгүй, 2016 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 7 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-д зааснаар 2 жил хорих ялаар шийтгүүлж, шийтгэх тогтоол биелүүлэхийг 1 жилийн хугацаагаар хойшлуулсан, бие эрүүл.

Монгол Улсын иргэн З.С, Дорнод аймгийн Хэрлэн суманд 1992 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр төрсөн, 24 настай, эмэгтэй, бүрэн дунд

боловсролтой, гоо сайханч мэргэжилтэй, ам бүл 8, эцэг, эх, эгч дүү, охины хамт хамт Дорнод аймгийн Хэрлэн сумын ... дүгээр багийн ... тоотод оршин суух, эрхэлсэн тодорхой ажилгүй, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, бие эрүүл.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ц.Т, Дорнод аймгийн Хэрлэн сумын ... баг ... тоотод эцэг, эхийн хамт оршин суух 7 настай.

Хэргийн товч утга: Шүүгдэгч П.Б нь шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаандаа З.С-ийн захиалгаар Iphone-4 маркийн гар утас авч өгнө гэж амласны дагуу 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр Дорнод аймгийн Хэрлэн сумын ... баг ... тоотод оршин суух 7 настай Ц.Т-г биеэ хамгаалах чадахгүйг мэдсээр байж, өөрийн гар утсан дахь зургийн цомгоо үзүүлэн тайлбарлаж байхад нь ухаан алдаж үзсэн үү? гоё мэдрэмж төрдөг хэмээн төөрөлдүүлэн 2 гараараа хоолойг нь боож ухаан алдуулж, амьсгал гарч байгаа мэдрэмж төрсөн гэх шалтгаанаар гар утасны цэнэглэгч кабель, цахилгааны уртасгагч залгуураар хоолойг нь боож санаатай алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэр бүлийн гадуурх эр, эмийн харилцаа, үзэн ядалт, өс хонзонгийн сэдэлт, эцэг, эхийн хэт хайхрамжгүй байдал, насанд хүрээгүй шүүгдэгчийн өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулын шинжийг ухамсарлах чадваргүй байдал, хүүхдэд тавих нийгмийн хяналт, ял хойшлуулсан хугацаанд ялтанд тавих төрийн байгууллагын хяналт суларсан нь гэмт хэргийн шалтгаан болжээ.

Хэрэгт цугларсан нотлох баримтаас үзэхэд, хохирогчийн эцэг “Ц” нь уг гэмт хэргийн

захиалагч З.С- тэй гэр бүлээс гадуурх эр эмийн харьцаатай удаан хугацаанд явсан, үүний улмаас З.С жирэмсэн болсон, хохирогчийн эцэгтэй гэр бүл болно гэж бодож байсан боловч бүтэхгүй байсан тул үр зулбуулах эм ууж хүүхдээ дутуу төрүүлж, бусдаас нууж оршуулсан. Үүндээ өсөрхөн бусдын хүүхдийн амь насыг хохироох сэдэл төрж, санаагаа бусдаар дамжуулан хэрэгжүүлсэн байна. Хохирогчийн эцэг “Ц” нь шүүгдэгч З.С-тэй анх танилцахдаа “Эхнэрээсээ салсан, эхнэр маань нэг даргын нөхөртэй явалддаг, ээж нь миний мууг үзэж, дүү нар нь манайхаас хулгай хийдэг” гэж шүүгдэгчийн мэдүүлэгт туссан байна. Мөн хохирогчийн төрсөн эх, түүний нөхөртэй эр эмийн харьцаатай байсан З.С нарын хооронд таарамжгүй харьцаа удаан үргэлжилсэн, элдэв хэл амаар доромжлох байдал байнга давтагддаг байснаас үзэхэд, гэр бүлийн таарамжгүй харьцаа удаан хугацаанд үргэлжилж гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болжээ.

Хохирогчийн эцэг, эхийн мэдүүлгээс үзэхэд захиалагч З.С нь удаа дараа заналхийлж, хүүхдийн амь насанд халдана гэж хэлж байсан боловч энэ талаар хуулийн байгууллагад мэдэгдэж арга хэмжээ аваагүй нь гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн. Түүнчлэн, гэрчийн мэдүүлэгт насанд хүрээгүй шүүгдэгч өнөө орой З.С эгчтэй хамтарч хүн ална, өнөө орой ээжтэй нь хамт хүүхдийг нь ална, намайг алж чадахгүй бол З.С эгч өөрөө ална гэж хэлсэн, чи байтугай бүх хүмүүс гайхна гэж хэлээд инээж байсан зэргээс үзэхэд шүүгдэгч өөрийн үйлдлийн нийгмийн хор аюул, хуулийн хариуцлагын талаар ухамсарлан ойлгох чадваргүй, хэвийн бус сэтгэлгээтэйг харуулж байна.

Шүүгдэгч /гүйцэтгэгч/ П.Б нь 2016 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 7 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-д заасан бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэж, 2 жилийн хугацаагаар хорих ял шийтгүүлж, шийтгэх тогтоол биелүүлэхийг 1 жилийн хугацаагаар хойшлуулсан нь гэмт хэрэг үйлдэх нэг нөхцөл болсон.

2002 оны Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-ийн дахь хэсэгт “Шүүх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар, сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садны хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулж болно” гэж заасан.

Шүүгдэгчийн /гүйцэтгэгч/ хувийн байдлыг авч үзвэл, 18 настай, бүрэн дунд боловсролтой хэдий ч их, дээд сургуульд суралцдаггүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, эцэг, эхээсээ тусдаа өвөө, эмээ, эгчийн хамт амьдардаг байхдаа хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээс даалгасан үүргийг биелүүлээгүй, хүүхдэд тавих гэр бүлийн болон цагдаагийн байгууллагын хяналт сул байгааг харуулж байна. Мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэгт “Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан

үүрэг биелүүлээгүй...бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана” гэж заасан байхад цагдаагийн байгууллага хяналт тавих үүргээ хангалттай биелүүлээгүй, нэр төдий хандсан байдал нь гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэжээ. 2015 оны Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хойшлуулж, засрал хүмүүжилд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавихаар зохицуулсан бөгөөд хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх ялтан дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.2, 37 дугаар зүйлийн 37.4-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.3, 91.2.4, 91.2.15-д зааснаар шүүгдэгч З.С-ийг 20 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 114 дүгээр зүйлийн 114.3-т зааснаар 5 жил 1 сарын хорих ялаар, шүүгдэгч П.Б Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.4, 91.2.15-д зааснаар 14 жилийн хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-т зааснаар эд хөрөнгийг хураахгүйгээр 2 жилийн хорих ялаар тус тус шийтгэжээ.

Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 57.1 д зааснаар ялтан З.С-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.3, 91.2.4, 91.2.15-д зааснаар оногдуулсан 20 жилийн хорих ял дээр эрүүгийн хуулийн тусгай ангийн 114 дүгээр зүйлийн 114.3 дааснаар оногдуулсан

5 жил 1 сарын хорих ялаас заримыг буюу 3 жилийн хорих ялыг нэмж, нийт 23 жилийн хорих ялаар, ялтан П.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.4, 91.2.15-д зааснаар оногдуулсан 14 жилийн хорих ял дээр мөн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-т зааснаар оногдуулсан 2 жилийн хорих ялаас заримыг буюу 1 жилийн хорих ялыг нэмж, нийт 15 жилийн хорих ял биечлэн эдлүүлэхээр тогтоосон.

Дүгнэлт: Оногдуулсан ялын төрөл, хэмжээ нь үйлдсэн хэргийн нийгмийн хор аюул, хэр хэмжээнд нийцсэн гэж үзэх үндэстэй. Шүүгдэгч З.С нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн, шүүгдэгч П.Б нь арван найман насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн нь Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.7 зааснаар хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэжээ. Хүнийг захиалгаар алсан үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар 15-25 жилийн хорих ял, эсхүл цаазаар авах ял оногдуулахаар заасан байдаг хэдий ч Эрүүгийн хуулийн эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг “Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн, эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй”, мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэг “Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй” гэсэн журмын тус тус баримталсан нь үндэслэлтэй гэж үзэж байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 201726010003

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
186, 2017.05.08

Шийдвэрлэсэн шүүх: Сонгинохайрхан дүүргийн
Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: БНХАУ-ын
ӨМӨЗО-ны иргэн Ө, 1971 оны 1 дүгээр сарын 7-ны
өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Жирэм аймгийн
Хорчин зүүн гарын хойд хошуунд төрсөн, 46
настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой,
мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам
бүл 4, эхнэр Ж.Х, дагавар хүү Ө.Бу, Ө.Бя нарын
хамт Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр
хороо, 21 дүгээр хороолол 8В байрны 137 тоотод
түрээсээр оршин сууж байсан, улсаас авсан
гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, бие эрүүл,
ухаан бүрэн, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын
иргэн Ж.Х, 40 настай, эмэгтэй, захад хүүхдийн
хувцас худалдаалдаг, хүү Ө.Бу, Ө.Бя нарын
хамт өрх толгойлон амьдарч байгаад 2013
оны 10 дугаар сарын үед БНХАУ-ын ӨМӨЗО-
ны иргэн Ө-тай танилцаад 2014 оны 6 дугаар
сарын 25-ны өдөр гэрлэлтээ бүртгүүлж, улмаар
Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо, 21
дүгээр хороолол 8В байрны 137 тоот орон сууцыг
түрээсэлж амьдрах болсон.

Монгол Улсын иргэн А.А, 4 нас, 10 сар, 3
хоногтой, эрэгтэй, эцэг, эх, 2 дүүгийн хамт
Сонгино хайрхан дүүргийн 26 дугаар хороо ...
гудамжны ... тоотод амьдарч байсан. Хохирогч
Ж.Х-ын дүүгийн хүүхэд, гэмт хэрэг үйлдэгдэх
үед хохирогчийнд тоглож байсан.

Монгол Улсын иргэн Ө.Бу, 12 нас, 8 сар, 1
хоногтой, эрэгтэй, хойд эцэг БНХАУ-ын ӨМӨЗО-

ны иргэн Ө, эх Монгол Улсын иргэн Ж.Х, ах Ө.Бя нарын хамт Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо, 21 дүгээр хороолол 8В байрны 137 тоотод түрээсээр амьдарч байсан.

Хэргийн товч утга: БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн Ө нь 2016 оны 12 дугаар сарын 30-аас 31-нд шилжих шөнө 00 цагийн орчим Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо, 21 дүгээр хороолол 8В байрны 137 тоотод эхнэр Ж.Х-ыг хувийн таарамжгүй харьцааны улмаас баруун бугалгын дотор хэсэг, гадна дээд хэсэг, гадна дунд хэсэг, зүүн шууны ард булчин хэсэг, духны баруун хэсэг, баруун сарвуу зэргийг заазуураар 6 удаа цавчиж, онц харгис, хэрцгий аргаар шууд санаатай алсан, улмаар танхайн сэдэлтээр, хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж эхнэрийн дүүгийн хүүхэд 4 настай А.А-ын зулай хэсэгт 1 удаа заазуурдаж, шууд санаатай алсан, мөн дагавар хүү 12 настай Ө.Бу-ийн толгой хэсэгт 1 удаа заазуурдаж, эрүүл мэндэд хүнд хохирол учруулж, алахаар завдсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Шүүгдэгч БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн Ө, Монгол Улсын иргэн Ж.Х нар найз Отгоны төрсөн өдрийг тэмдэглэж, караокед архи, пиво уусан, улмаар эхнэр Ж.Х нөхөртөө их уулаа гэж хэлсэн тул маргалдаж, эхнэрээ алгасан, эхнэр Ж.Х “Чи ганцаараа гартай нь юм уу?” гээд өөдөөс нь цохисон, нөхөр эр хүн эхнэрээ ганц алгадах байдаг л зүйл гэж хэлж, дахин алгадаж, улмаар заазуурдаж алсан. Эндээс үзэхэд, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн Ө-д эхнэр Монгол Улсын иргэн Ж.Х, эхнэрийн дүүгийн хүүхэд 4 настай А.А нарыг

алсан үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.12, 91.2.15, 91.2.16-д зааснаар 24 жил, дагавар хүү Ө.Бу-ийг алахаар завдаж, эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан үйлдэлд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.2, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.6, 91.2.15 дахь хэсэгт зааснаар 8 жилийн хорих ял оногдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг журамлан зарим ялыг нэмж нэгтгэн, биечлэн эдлэх ялыг 25 жилээр тогтоосон.

Дүгнэлт: Шүүхээс БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн Ө-д холбогдох эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлыг зөв үнэлж, гэмт этгээдийн гэм буруугийн хэлбэр, үйлдлийн арга, нийгмийн хор аюулд тохирсон ялыг шударгаар оногдуулсан байна.

Шүүхээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлтдээ БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн Ө-ын хүнийг санаатай алсан, алахаар завдсан үйлдлийн зүйлчлэлээс 91 дүгээр зүйлийн 91.2.6, 91.2.10 дахь хэсгийг хассан нь зүйтэй байна. Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, хохирогч А.А-ыг алсан үйлдэл нь өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгыг хангаагүй, мөн 2 хүнийг нэг цаг хугацаанд алсан нь давтан гэмт хэргийн шинжид хамаарахгүй.

Эрүүгийн хэргийн дугаар: 20172200019

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
№77, 2018.03.23

Шийдвэрлэсэн шүүх: Хөвсгөл аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Р.Г, 1982 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох суманд төрсөн, 36 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, малчин, ам бүл 6, эхнэр, хүүхдүүдийн хамт Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ... багт оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн П.Б, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ... багт эцэг, эх, дүү нарын хамт амьдардаг, эрэгтэй, 8 настай, сэтгэцийн болон архаг хууч өвчингүй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Р.Г нь 2016 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ... багт иргэн О.Н-ыг сэтгэцийн өвчтэй биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан бэлгийн харьцаанд орсон, уг хэргээ нуун далдлах зорилгоор хэргийг харсан гэх 8 настай гэрч П.Б-г жалган дотор хоёр гараараа багалзуурдан боомилж, алсан. Мөн уг хэргийг өөр хүн үйлдсэн мэтээр харагдуулах зорилгоор цогцсыг жалганаас малын хашаа руу зөөвөрлөн сэтгэцийн өвчтэй О.Н-ээр бүсээр хоолойг нь боолгож, шонгийн модноос уясан байдалтай орхисон.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, шүүгдэгч төрөлхийн сэтгэцийн өвчтэй, оюуны хомсдолтой О.Н-ыг удаа дараа хүчиндэж байсан, сүүлийн гэмт

үйлдлийг харсан бага насны гэрчийг устгах гэсэн явцуу зорилго, өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулыг ухамсарлан ойлгох мэдлэг чадвар дутмаг, үйлдсэн хэргийнхээ төлөө заавал хариуцлага хүлээдэг гэсэн ойлголт байхгүйгээс гэнэт үүссэн шууд санаагаа хэрэгжүүлсэн нь энэ гэмт хэргийн шалтгаан болжээ. Дээрх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, мэдлэг боловсролтой шууд холбоотой гэж үзэх үндэстэй боловч, хүүхдээ хараа хяналтгүй орхиж, найр наадамд анхаарлаа хандуулсантай холбон тайлбарлаж болох юм. Түүнчлэн, шүүгдэгч нь сэтгэцийн өвчтэй хохирогчийг удаа дараа хүчинддэг байсан талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, ойр дотнын хүмүүс мэдээгүй удаан хугацаанд явсан нь энэ гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болжээ. Хүчиндэх үйлдлийг эрт мэдэж, хараа хяналтаа сайжруулсан бол бага насны хүүхдийн амь нас хохирохгүй байх боломжтой.

Оногдуулсан ял: Шүүгдэгч О.Н-ыг сэтгэцийн өвчтэй, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан бэлгийн харьцаанд орсон, уг хэргээ нуун далдлах зорилгоор хэргийг харсан гэх 8 настай гэрч П.Б-г боомилж, амь насыг нь хохироосон үйлдэлд 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 жилийн хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.4, 2.7 дахь хэсэгт зааснаар 13 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, Эрүүгийн хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 10.1 дүгээр зүйлийн 2.4, 2.7 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 13 жилийн хорих ял дээр мөн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 2 жилийн

хорих ялыг нэмж, нэгтгэн биечлэн эдлэх ялыг 15 жилийн хугацаагаар тогтоосон.

Дүгнэлт: Оногдуулсан ялын төрөл, хэмжээ үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, чанарт тохироогүй гэж үзэх үндэслэлтэй. 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах, мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт 12-20 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах, эсхүл бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан байна. Дээрх нөхцөл байдалтай ижил нөхцөлд үйлдэгдсэн гэмт хэрэгт 20-25 жил хүртэл зарим тохиолдолд цаазаар авах ял оногдуулж байсан практиктай харьцуулахад хөнгөн ял оноосон гэж үзэж болно. Шүүхийн шийтгэх тогтоолд хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг дурдаагүйгээс гадна шүүгдэгчийн өмгөөлөгч тухайн хүүхдийг миний үйлчлүүлэгч алаагүй, сэтгэцийн өвчтэй хүний мэдүүлэгт үндэслэн яллаж байгаа тул хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах эсхүл цагаатгаж өгөх талаар хүсэлт гаргасан боловч хүсэлтийг хүлээж аваагүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэж заасныг үндэслэн цагаатгах учиртай. Харин нотлох баримтыг дутуу цуглуулсан, бүрэн дүүрэн нотлоогүй нь ял оногдуулахад хөнгөрүүлэх үндэслэл болохгүй.

Эрүүгийн хэргийн дугаар: 201725010733

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 665, 2017.11.03

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Д, 1978 оны 8 дугаар сарын 31-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 39 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, ажилгүй, ам бүл 3, ээж, ахын хамт Баянзүрх дүүргийн ... хороо ... тоотод оршин суух, Баянзүрх дүүргийн шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 296 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 98 дугаар зүйлийн 98.1-д зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, уг ялыг тэнсэж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн, 3 сар 2 хоногтой, 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр төрсөн, эрэгтэй, ээж, эгчийн хамт амьдардаг байсан.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Д нь 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 20 цагийн үед согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 3 сар 2 хоногтой өөрийн төрсөн хүүгээ хашаа давуулж шидэж санаатай алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Хүүхдийн эцэг нь хамт амьдардаггүй байсан ба ээжийнх нь бие нь өвдсөн тул аваачиж өгсөн байдаг. Хүүхдээ аваад очиход согтуу байсан ба архи ууж байгаад хүүхдээ уйлсан болохоор нь хашаа давуулан шидсэн. Эх нь удалгүй буюу 2017 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр өвчний учир нас барсан. Энэ гэмт хэргийн тухайд байнга согтууруулах

ундаа хэтрүүлэн хэрэглэдэг байдал гэмт хэргийн шалтгаан болжээ. Мөн хүүхдээ харж чадахгүй согтуу хүнд эцэг нь гээд бага насны хүүхдийг итгээд үлдээсэн байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7-д зааснаар 18 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүгдэгчдэд оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

**ТҮҮВЭР
СУДАЛГАА-15**

Эрүүгийн хэргийн дугаар: 1727000000008

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 2018/ШЦТ/18, 2018.01.30

Шийдвэрлэсэн шүүх: Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б овогтой Ж.Д, 1994 оны 7 дугаар сарын 3-ны өдөр төрсөн, эмэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, ажилгүй, ам бүл 3, нөхөр, хүүхдийн хамт Өвөрхангай аймагт оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн, 2015 онд төрсөн 2 настай, эмэгтэй, аав, ээж, ахын хамт амьдардаг байсан.

Хэргийн товч утга: 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 15 цагийн үед Өвөрхангай аймгийн Бүрд сумын ... багийн ... гэх газар шүүгдэгч Ж.Д

нь өөрийн төрсөн 2 настай охиноо машины дугуй руу шидэж алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Ж.Д нь нөхөр болох С.М-ыг аавтайгаа сум явах гэхэд араас нь гарч машины дугуй рүү шидэж алсан байна. Гэрчүүдийн мэдүүлгээс үзэхэд, нөхрийгөө гадагш гарах гэхээр дандаа араас нь юм шидэж явуулахгүй гэдэг байсан гэжээ. Үл ялих зүйлээс болж өөрийн төрсөн хүүхдээ алсан нь уурын мунхаг, гэр бүлийн хэрүүл маргаан, ухамсар, хүмүүжилтэй нь салшгүй холбоотой.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7-д зааснаар 12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг нээлттэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: 23 настай иргэн Ж.Д нь өөрийн 2 настай төрсөн охиныг алсан гэмт хэрэг үйлдсэн ба өмгөөлөгчийн зүгээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийг хэрэглэж, хорих ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулж өгөхийг хүссэн боловч шүүхээс шүүгдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй байгаа учир хэрэглэх боломжгүй гэсэн хэмээн үзжээ. Харин шүүгдэгч Ж.Д-г тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож хорих ялын доод хэмжээгээр хорих ял оногдуулжээ.

Эрүүгийн хэргийн дугаар: 1708000000037

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
517, 2017.12.05

Шийдвэрлэсэн шүүх: Сонгино хайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б овогт М.Б, 1994 оны 12 дугаар сарын 7-ны өдөр төрсөн, эрэгтэй, 22 настай, бүрэн бус дунд боловсролтой, сантехникийн слесарь мэргэжилтэй, ажилгүй, ам бүл 4, эхнэр, хүүхдүүдийн хамт Сонгино хайрхан дүүргийн ... хороо нуурын ... дугаар гудамж ... тоотод оршин суух, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн, 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 3 нас 8 сартай, эмэгтэй, аав, хойд ээж, түүний хүүхдийн хамт амьдардаг байсан.

Хэргийн товч утга: 2017 оны 8 дугаар сарын 12-13-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн ... хороо нуурын ... дугаар гудамж ... тоот гэртээ шүүгдэгч М.Б нь эхнэрийнхээ эгчийн нөхрийн охин болох хамт амьдардаг 3 нас 8 сартай М.А-ийн баруун зүүн хацар болон баруун гарын сарвууны гадна хэсгийг асаагуураар түлж, онц харгис хэрцгийгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, цээжин тус газар нь өшиглөж алсан гэмт хэрэг үйлджээ.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Энэ гэмт хэргийн улмаас нас барсан бага насны М.А-ийн эцэг, эх нь 2015 оны 3 сард салсан бөгөөд эх нь өөр хүнтэй гэр бүл болсон ба 10 сартай хүүхэдтэй учир охиныг эцэгт нь өгсөн байдаг. Төрсөн эцэг болох Б.М нь мөн өөр хүнтэй буюу О.С-тэй гэр бүл болсон ба О.С нь мөн дагавар хүүхэдтэй. О.С-ийн дүү нь нөхөр болох М.Б болон 2 хүүхдийн хамт Б.М-ийн гэрт хамт амьдардаг байна. Амь хохирогч М.А-г цуг амьдарснаас хойш эцэг болох Б.М болон түүний эхнэр болох О.С нар байнга зодож, харгис хэрцгий

харьцаж, хөнгөн гэмтэл учруулсан байна. Хойд ээж О.С нь өмдөндөө шээлээ, өөрийгөө ээж гэж дуудсангүй гэж, харин эцэг Б.М нь ээжийнхээ үгэнд орсонгүй, хүүхэд зодлоо гэх шалтгаанаар, хохирогчийг алсан шүүгдэгч М.Б нь үгэнд орсонгүй, муухай харлаа гэх шалтгаанаар удаа дараа зодож байсан байна. Иймд гэр бүлийн салалт, дагавар хүүхэдтэй өөр хүнтэй гэрлэж, олуулаа амьдардаг, бүгд зодож гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байсан нь энэ гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болжээ. Монгол Улсад 2017 онд 3945, 2018 онд 4201 хүн гэр бүлээ цуцлуулсан байна. Энэ тоо нь хуулийн дагуу цуцалснаас хойших хугацаа харгалзахгүйгээр дахин гэрлээгүй байгаа хүмүүсийг гэр бүлээ цуцалж салсан гэж үздэг байна.³¹ Гэтэл хуулийн дагуу бус гэр бүлээ батлуулаагүй салсан мөн цуцлуулаад дахин гэр бүл болсон хүмүүсийн тоог нэмбэл бүр их тоо гарах нь тодорхой ба үүний цаана хэдэн хүүхэд өнчирч, хэдэн хүүхэд хойд эцэг, эхийн гарын аялыг харж, хэдэн хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа нь сэтгэл эмзэглэмээр зүйл болоод байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.7, 2.8-д зааснаар 20 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүхээс ял оногдуулахдаа шүүгдэгч М.Б тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг хөнгөрүүлэх нөхцөлд тооцож, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзжээ. Харин хохирогчийн эцэг болох Б.М, түүний эхнэр

³¹ www.1212.mn

гэх О.С нарыг Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн гэж үзэж тус бүр 2 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 1818007580500

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №26, 2019.01.09

Шийдвэрлэсэн шүүх: Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн М.Х, 1994 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд төрсөн, 24 настай, эрэгтэй, яс үндэс халх, бүрэн бус дунд боловсролтой, мэргэжилгүй, Дархан захад тэрэг түрдэг, ам бүл 8 аав, ээж, эгч, дүү нарын хамт Дархан –Уул аймаг ... сум, ... дугаар баг, ... гудамж ... тоотод оршин суух, 1 удаагийн ял шийтгэлтэй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн У, 3 нас 11 сар 14 хоногтой.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Х нь 2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Дархан Уул аймгийн ... сум ... дугаар баг, ... дугаар гудамжны ... тоотод хамт амьдардаг өөрийн төрсөн эгч А-ийн охин болох 3 нас 11 сар 14 хоногтой У-г биеэ хамгаалах чадваргүй гэдгийг мэдсээр байж, ундаа асгалаа хэмээн үл ялих зүйлээр шалтаглаж нэг удаа алгадаж улмаар ор мөргөж унаснаас зүүн тал бөмбөлгийн чамархай, дагз хэсгийн хатуу хальсан доорх цусан хураа бүхий хүнд гэмтэл учирч, хохирогч нас барсан.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл: Ундаа асгалаа гэж үл ялих зүйлээр шалтаглаж зодсон, хүүхдэд хараа хяналт сул, амьдралын боломж тааруу, шүүгдэгчийн биеэ барих чадваргүй байдал зэрэг болно. Хохирогч нь ээж, шүүгдэгч болон насанд хүрсэн бусад хүмүүсийн хамт нэг гэрт амьдардаг, шүүгдэгч зах дээр тэрэг түрдэг, төрсөн эх А нь хөдөө ажил хийж амьдардаг, Дархан-Уул аймагт цэцэрлэгийн хүрэлцээ дутмаг гэсэн шалтгаанаар ажлын өдрүүдэд хохирогч У нь бага насны эгчийн хамт гэртээ үлддэг байсан нь хүүхдэд тавих хараа хяналт сул, хүнс тэжээлийн дутагдалд орох, хооллох дадалд хэвшээгүй зэрэг нөхцөлийг бүрдүүлсэн байна. Шүүгдэгч сэтгэцийн хувьд эрүүл боловч, түрэмгий ууртай өөрийн хийж байгаа үйлдлийн нийгмийн аюулыг ойлгож, биеэ барих чадваргүй болох нь бага насны хүүхдэд хүч хэрэглэн зодсон, хохирогчийг салган авах үед дахин зодох гэж дайрч байсан зэргээр тогтоогдож байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгчид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж алсан гэж үзэж, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.7, 2.8 дахь хэсгээр зүйлчилж, 12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн. Шүүх ял оногдуулахдаа шүүгдэгчийн гэм буруугаа хүлээж, гэмшсэн байдал, оршуулгын зардлыг барагдуулсан байдал, хохирогчийн ар гэрийн зүгээс нэхэмжлэх зүйл, гомдол саналгүй гэсэн нөхцөл байдлуудыг харгалзан үзсэн.

Дүгнэлт: Шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдалд тохирсон гэж үзэх үндэстэй байна. Шүүх ял оногдуулахдаа хөнгөрүүлэх болон хүндрүүлэх

нөхцөл байдлыг дурдаж тайлбарлаагүй боловч ял оногдуулахдаа хөнгөрүүлэх нөхцөл байдлыг түлхүү харгалзсан байна. Шүүгдэгчийн хувийн байдлыг авч үзвэл урьд нь ял шийтгэл эдэлж байсан, гэмт хэрэг үйлдэх үедээ согтуурсан байсан зэрэг бусад хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь тогтоогоогүй байна.

4.3. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ТҮҮВЭР СУДАЛГАА /ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА/

Хүснэгт 4.2 Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулсан байдалд хийсэн түүвэр судалгаа (харьцуулсан судалгаа)

№	Хэргийн товч утга	Эрүүгийн хууль	Зүйл, хэсэг	Оногдуулсан ялын төрөл, хэмжээ	Дундаж ял
1. Нэг удаагийн үйлдлээр хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулсан байдал:					
1	Шүүгдэгч М.А нь 2016 оны 7 дугаар сард бага насны хүүхэдтэй тохиролцож, хохирогч өөрөө хүссэн шалтгаанаар бэлгийн харьцаанд орж хүчиндсэн.	2002	126.3	20 жилийн хорих ял	16.7 жил хорих ял
2	Шүүгдэгч Д.Х 2011 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хохирогч М.С-ийг биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хүчиндсэн, мөн өөрийн биед бэлгийн замын халдварт өвчин байгааг мэдсээр байж халдаасан.	2002	126.3 103.2	15 жил 1 сарын хорих ял, /126.3/ 1 жилийн хорих ял /103.2/ Биечлэн эдлэх 15 жил 1 сар /57.1/	
3	Шүүгдэгч Н.Э нь 2015 оны 8 дугаар сарын 20-ны шөнө Төв аймгийн нутаг дэвсгэрт байрлах Си ХХК-ны ажилчдын байранд 7 настай, эмэгтэй, У.У-г биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хүчиндэж, бэлэг эрхтэн рүү нь гарын хуруугаа хийж, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан.	2002	126.3	15 жил 1 сарын хорих ял /126.3/,	

4	Шүүгдэгч Ц.Б нь 2017 оны 4-р сарын 3-ны өдрийн 09 цагийн орчимд бага насны буюу 10 нас 2 сартай Б.Н-ийг хүч хэрэглэн хүчиндсэн	2015	12.1.4	12 жилийн хорих ял	12 жил хорих ял
5	Шүүгдэгч Т.Б нь 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 23 цагийн үед өөрийн хадам дүү болох Д.Н-ийг эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, бага насны хүүхэд гэдгийг нь мэдсээр байж, хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орсон, энэ хэргийн улмаас хохирогч жирэмсэн болсон.	2015	12.1. 4	12 жилийн хорих ял	
Ялын өөрчлөлт		2015	Хорих ялын бодлого -4.7 жилээр суларсан.		
2. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн гэмт хэрэгт ял оногдуулсан байдал:					
5	Шүүгдэгч Б.Б нь 2005 оноос 2013 оны 4 сарын 8-ны өдөр хүртэл дагавар охин Д.Г-г 14 насанд хүрээгүй байх үеэс буюу 8 настайгаас нь 15 нас 4 сар 27 хоног хүртэлх хугацаанд удаа дараа хохирогчид хүч хэрэглэхээр заналхийлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн.	2002	126.3	16 жилийн хорих ял	16 жил хорих ял
6	Шүүгдэгч Ш.О Сүхбаатар дүүргийн ... дугаар хороо, ... задгай тоотод 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2017 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд хохирогч дагавар охин Ө.С-д хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хүчиндсэн.	2015	12.1. 4	18 жилийн хорих ял	17.5 жилийн хорих ял
7	Шүүгдэгч Г.Б нь 2016 оноос 2018 оны 6-р сар хүртэл дагавар охин Б.С-г 14 насанд хүрээгүй байх үеэс буюу 10 настайгаас нь 12 нас хүртэлх хугацаанд удаа дараа хүч хэрэглэн хүчиндсэн	2015	12.1.4	18 жилийн хорих ял	
8	Шүүгдэгч Б.О 2016 оны 7 дугаар сараас 2017 оны 9 дүгээр сар хүртэл өөрийн гэртээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай дагавар охин 13 настай О.Л-ийг удаа дараа хүчиндсэн.	2015	12.1. 4	18 жилийн хорих ял	
9	Шүүгдэгч Ж.М нь 2017 оны 12-р сараас 2018 оны 06-р сарын 9-ний өдрийг хүртэлх хугацаанд 2018 оны 6-р сарын 10-ны өдрөөс 2018 оны 8 сарын 25 хүртэл өөрийн дагавар охин болох 13 настай Ц.С-г удаа дараа хүчиндсэн	2015	12.1.4 11.7.1	19 жилийн хорих ял /12.1.4/ 1жилийн хорих ял/11.7.1/	

10	Шүүгдэгч Э.В нь 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр орцны жижүүрийн 00 өрөөнд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай дагавар охин 6 настай Б.Х-г өөрийн эрхшээлдээ байгааг далимдуулан хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчин халдаасан.	2015	12.1. 4	18 жилийн хорих ял	
11	Шүүгдэгч С.А 2017 оны 3 дугаар сараас 5 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 3 удаа гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох хохирогч А.М-д хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орж, хохирогчийг жирэмсэн болгосон.	2015	12.1. 4	12 жилийн хорих ял	
12	Шүүгдэгч Д.Г нь 2017 оны 10-р сарын 6-7-нд шилжих шөнө архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэр бүлийг хамаарал бүхий харилцаатай бага насны настай Н.М хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн	2015	12.1.4	20 жилийн хорих ял	
		2015		Хорих ялын бодлого +1.5 жилээр чангарсан.	
3. Удаа дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулсан байдал:					
10	Шүүгдэгч Н.М 2010 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр хохирогч Д.С-г хүчиндэж, энэ хэргээ хялбарчлах зорилгоор хоолойг боон амьсгал бүтэлтэд оруулан санаатай алахыг завдсан, 2010 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр танхайн сэдэлтээр хохирогч Э.Н-г биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж түүний хоолойг боож алахыг завдсан, 2010 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр хохирогч О.Б-г хүчиндэж, энэ хэргээ хялбарчлах зорилгоор хоолойг боож санаатай алахыг завдсан, 2010 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хохирогч Р.М-г хүчиндсэн, шулуун гэдсээр хурьцал үйлдэж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан, энэ хэргээ хялбарчлах зорилгоор боож амьсгал бүтэлтэд оруулан санаатай алсан.	2002	125.2, 126.3, 32.1, 32.2- 91.2.2, 91.2.6, 91.2.10, 91.2.15	10 жилийн хорих ял /125.2/, 25 жилийн хорих ял /126.3/ 10 жилийн хорих ял /32.1, 32.2, 60.4-г 91.2.2, 91.2.6, 91.2.10, 91.2.15/ Цаазаар авах ял /91.2.6, 91.2.10, 91.2.15/ Биечлэн эдлэх ял цаазаар авах	16.5 жилийн хорих ял эсхүл Цаазаар авах ял
11	Шүүгдэгч Т.Г айлд мал маллаж байхдаа 2011 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2013 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд тухайн айлын 13 настай охин Э.Ц-г удаа дараа хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэн болж, ураг авхуулсан, мөн шүүгдэгч С.А айлд мал маллаж байхдаа 2013 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 13 настай охин Э.Ц-г хүчиндсэн.	2002	126.3	18 жилийн хорих ял / Т.Г/ 15 жил 1 сарын хорих ял / С.А/	

12	<p>Шүүгдэгч Б.Б нь 2013 оны 12 дугаар сарын 4-ний өдөр 8 настай, эмэгтэй Г.М-ыг “Зам заалгая” хэмээн хуурч мэхлэн өөрийн Тоёота чейзер-100 маркийн автомашинд суулган Улиастайн голын орчим аваачиж, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан айлган сүрдүүлж, хүч хэрэглэж, түүний бэлэг эрхтнийг нь долоож тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан.</p> <p>Мөн 2014 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 14 цагийн үед 7 настай, эмэгтэй Л.М-ыг “Гэрт чинь хүргэж өгье” хэмээн хууран мэхэлж, өөрийн Тоёота чейзер-100 маркийн автомашинд суулган Улиастайн голын орчим аваачиж, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан айлган сүрдүүлж, хүч хэрэглэж хүчиндсэн.</p>	2002	126.3,	16 жилийн хорих ял /126.3/	
13	<p>Шүүгдэгч Г.П нь 2015 оны 4 дүгээр сарын 1, 2015 оны 6 дугаар сарын 20, 2015 оны 8 дугаар сарын 15-ны өдөр тус тус өөрийн гэртээ болон тээврийн хэрэгсэлдээ оюуны хүндэвтэр хомсдол сэтгэцийн өвчтэй бага насны Э.Ц-г биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хүч хэрэглэхээр заналхийлж, хутга тулган айлган сүрдүүлж хүчиндсэн.</p>	2002	126.3	17 жилийн хорих ял	
14	<p>Шүүгдэгч Х.А нь 2016 оны 8-р сард бага насны 2 хүүхдийг хүч хэрэглэн хүчиндсэн</p>	2015	12.1.4	13 жилийн хорих ял	
15	<p>Шүүгдэгч Б.Б 2017 оны 7 дугаар сард Гацууртын зусланд байрлах иргэн Б.Я-ийн байшинд 13 настай хохирогч Т.Э-г унтаж байхад нь буюу эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байгааг далимдуулан бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн, мөн 2017 оны 7 дугаар сард ... дугаар байрны орчим автомашин дотор хохирогчийг хүчиндсэн, 2017 оны 11 дүгээр сард Баянгол дүүргийн ... дугаар байрны орчим автомашин дотор хохирогчийг хүчиндсэн, 2017 оны 12 дугаар сард Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, Гацууртын зусланд автомашин дотор хохирогчийг хүчиндсэн, 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт хохирогчийг хүчиндсэн.</p>	2015	12.1. 4	13 жилийн хорих ял	12.75 жилийн хорих ял

16	Шүүгдэгч Х.А 2016 оны 8 дугаар сард хохирогч А.Н-г хүч хэрэглэн хүчиндсэн, мөн иргэн Л.А-ийн гэрт хохирогч А.Н-г хүч хэрэглэн давтан хүчиндсэн.	2015	12.1. 4	13 жилийн хорих ял	
17	Шүүгдэгч М.С нь 2018 оны 8 дугаар сараас 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд 12 настай, Б.А-г "Тоёота приус" маркийн автомашинд удаа дараа хүчиндэж жирэмсэн болгосон.	2015	12.1.4	12 жилийн хорих ял	
		2015		-3.75 жилээр ялын бодлого суларсан, цаазаар авах ял хасагдсан	
4. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэж хүчиндсэн үйлдэлд ял оногдуулсан байдал:					
18	Шүүгдэгч 2010 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хохирогч Р.М-г шулуун гэдсээр хурьцал үйлдэж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан	2002	125.2	10 жилийн хорих ял	8.0 жилийн хорих ял
19	Шүүгдэгч Н.Э нь 2015 оны 8 дугаар сарын 20-ны шөнө Төв аймгийн нутаг дэвсгэрт байрлах Си ХХК-ны ажилчдын байранд 7 настай, эмэгтэй, У.У-г биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан бэлэг эрхтэн рүү нь гарын хуруугаа хийж, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан.	2002	125.2	5 жил 1 сарын хорих ял /125.2/	
20	Шүүгдэгч Б.Б нь 2013 оны 12 дугаар сарын 4-ний өдөр 8 настай, эмэгтэй Г.М-ыг "Зам заалгаа" хэмээн хуурч мэхлэн өөрийн Тоёота чейзер-100 маркийн автомашинд суулган Улиастайн голын орчим аваачиж, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан айлган сүрдүүлж, хүч хэрэглэж, түүний бэлэг эрхтнийг нь долоож тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан.	2002	125.2	9 жилийн хорих ял /125.2/ /	
21	Шүүгдэгч Б.Д нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай бага насны дагавар охин А.М 8 нас 6 сартай байхаас нь эхэлж 13 нас хүртэл 2 удаа бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн	2015	12.1.4	20 жилийн хорих ял	14.3 жилийн хорих ял
22	Шүүгдэгч Д.Э 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр өөрийн хүү Э.Д-ийн 5 настай охин Д.Ц-г хамт унтахаар хэвтэж байхад нь бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн /бэлэг эрхтэн рүү нь гарын хуруугаа хийсэн/.	2015	12.1.4	12 жил, 3 сарын хорих ял	

23	Шүүгдэгч Ж.Б нь 2018 оны 2 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө найз Ч.Б-нд хонож байхдаа түүний 8 настай охины бэлэг эрхтэнд гараа хийх, аманд нь бэлэг эрхтнээ хийх зэргээр бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.	2015	12.1 4	12 жилийн хорих ял	
24	Шүүгдэгч М.Ш нь 2018 оны 04-р сарын 3-ны өдөр 06 цагийн орчим гэр бүлийн хамаарал бүхий дагавар охин болох 9 нас 10 сар 1 хоногтой У.Э-г хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр занал хийж оюуны хөнгөн хомсдол сэтгэцийн өвчтэй буюу биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг нь далимдуулан бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн	2015	12.1.4	14 жилийн хорих ял	
25	Шүүгдэгч Б.Х 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хохирогч 6 настай охины бэлэг эрхтэнд хуруугаа хийсэн, бэлэг эрхтнийг оролдож, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.	2015	12.1 4	15 жилийн хорих ял	
26	Шүүгдэгч Н.Э нь 2018 оны хавар удаа дараа дагавар охин 8 настай Б.Л-ийн аманд бэлэг эрхтнээ хийж, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.	2015	12.1 4	13 жилийн хорих ял	
		2015	Хорих ялын бодлого жилээр +6.3 жилээр чангарсан.		
5. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд ял оногдуулсан байдал:					
27	Шүүгдэгч Н.Э нь 2016 оны 7 дугаар сарын 20-21-нд шилжих шөнө Дорнод аймгийн Баяндун сумын ... дүгээр багийн нутаг ... гэх газарт оршин суух иргэн Ч.Б-ийн гэрт 14 насанд хүрээгүй Б.Х-г хүч хэрэглэж, хүчиндэхийг завдсан.	2002	32.3, 126.3	4 жил 6 сарын хорих	4 жил 6 сар хорих ял
28	Шүүгдэгч Б.Д нь 2017 оны 10 дугаар сарын 1-ний өдөр 7 настай Б.Ц-г гадуур куртикийг нь тайлсан, түшлэгтэй сандал дээр гадуур өмдийг нь дотоожтой нь цуг өвдөг хүртэл нь шувталж дээшээ харуулан хэвтүүлсэн, өөрийнхөө гадуур өмдийг дотоожны хамт шувталчихсан охины өмнө сөхрөөд суун, өөрийнхөө бэлэг эрхтнээ гараараа оролдох зэрэг үйлдлээр хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан.	2015	2.8 12.1 4	9 жилийн хорих ял	9 жил хорих ял

		2015	Хорих ялын бодлого 4.4 жилээр чангарсан.	
Нийт гэмт хэрэгт оногдуулсан ялын бодлогын өөрчлөлт /дунджаар/	2002	126.3	12.4 жилийн хугацаагаар хорих ял	
	2015	12.1 (4)	13.1 жилийн хугацаагаар хорих ял	
	2015 зөрүү	Хорих ялын бодлого +0.7 жилээр чангарсан, цаазаар авах ял хасагдсан.		

2002 оны Эрүүгийн хуульд заасан хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогыг 2015 оны Эрүүгийн хуультай харьцуулан үзвэл, нэг удаагийн үйлдлээр хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 4.7 жилээр суларсан, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 1,5 жилээр чангарсан, удаа дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 3.75 жилээр суларч, бүх насаар хорих ял оногдуулаагүй, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэж хүчиндсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 6.3 жилээр, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулсан хорих ялын бодлого 4.4 жилээр тус тус чангарсан байна. Нийт оногдуулсан ялын бодлогыг авч үзвэл хорих ялын бодлого 0.7 жилээр чангарсан, цаазаар авах ялын оронд хэрэглэхээр хуульчилсан бүх насаар хорих ялыг хэрэглээгүй байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-1

Эрүүгийн хэргийн дугаар: 1811021630694

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №847, 2018.11.29

Шийдвэрлэсэн шүүх: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Т.Б, 1989 оны 7 дугаар сарын 12-ны өдөр Говь-Алтай аймагт төрсөн, 29 настай, эрэгтэй, бага боловсролтой, гагнуурчин мэргэжилтэй,

хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл 4, эхнэр, хүүхдүүдийн хамт Чингэлтэй дүүргийн ... дугаар хороо, сургуулийн ... дугаар гудамжны ... тоотод оршин суудаг, урьд ял шийтгэгдэж байгаагүй.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Д.Н, 2004 оны 10 дугаар сарын 15-ны өдөр төрсөн, 13 нас, 4 сар, 10 хоногтой, эмэгтэй, эцэг, эх нь салсан шалтгаанаар эцгийн ээжийн нэрээр овоглон Сэлэнгэ аймгийн төвд эмээгийн хамт амьдардаг.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Т.Б нь 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 23 цагийн үед Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн ... дугаар хороо, Яргайтын ... дүгээр гудамжны ... тоотод өөрийн хадам дүү болох Д.Н-ийг эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, бага насны хүүхэд гэдгийг нь мэдсээр байж, хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орсон, энэ хэргийн улмаас хохирогч жирэмсэн болсон.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдалд дүгнэлт хийж үзэхэд, гэр бүлтэй, сэтгэцийн хувьд эрүүл, согтууруулах ундааны зүйл хэрэглээгүй байсан зэргээс үзвэл, хүчиндэх гэмт хэрэг үйлдэх онцгойлсон шалтгаан байхгүй байна. Харин бэлгийн дур хүслээ барих чадваргүй байдал, боловсролын түвшин, эсэргүүцэл үзүүлэхгүй байгаа нь зөвшөөрч байгаа хэлбэр гэсэн явцуу бодол нь гэмт хэрэг үйлдэх гол шалтгаан болжээ. Нөгөө талаар хохирогчид тавих хараа хяналт сул, гэрээс өөр газарт түр хугацаагаар байрлаж байсан, эцэг, эхгүйн улмаас эмээ дээр өссөн нь хохирогчийн эрх ашгийг хамгаалах хүн байхгүй гэсэн ойлголтыг гэмт этгээдэд төрүүлсэн байх боломжтой. Хохирогч биеийн хөгжил сайтай, хөх нь ургасан байсан зэрэг нь гадаад байдлын

хувьд халдлагад өртөхөд нөлөөлсөн байх талтай. Гэмт хэргийн улмаас хохирогч жирэмсэн болсон нь сэтгэл санааны болон бие махбодод учирсан үлдэц хор уршиг юм.

Хохирогч жирэмсэн болсон нь хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 5 сарын дараа мэдэгдсэнээр гэмт хэрэг илэрсэн бөгөөд хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй, өвөрмөц шалтгаан, нөхцөлтэй гэдгийг энэ тохиолдол харуулж байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Т.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4-т зааснаар бага насны хүүхдийн эсрэг хүч хэрэглэж, хүчээр бэлгийн харьцаанд орсон, энэ гэмт хэргийн улмаас хохирогч жирэмсэн болсон гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, 12 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 4-д зааснаар оногдуулсан 12 жилийн хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр зааж, мөн ерөнхий ангийн 6.10 дугаар зүйлийн 1-д зааснаар цагдан хоригдсон 118 хоногийг хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохоор дурдсан хууль зүйн үндэслэлтэй байна.

Дүгнэлт: Хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, зэргийг нь харгалзан үзвэл оногдуулсан ял хөнгөдсөн гэж үзэх үндэстэй. Учир нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хамгийн бага хэмжээгээр хорих ялыг оногдуулсан байна. Шүүхийн шийтгэх тогтоолд Эрүүгийн хуулийн хууль ёсны зарчим, шударга ёсны зарчим, гэм буруугийн зарчим, эрүүгийн хариуцлагын хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл

байдлыг харгалзан ял оногдуулсан гэж дурдсан боловч ямар нөхцөл байдлыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал болгон ял оногдуулахдаа харгалзан үзсэн нь тодорхойгүй байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 171100874019

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №75, 2018.01.17

Шийдвэрлэсэн шүүх: Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Д, 1943 оны 8 дугаар сарын 25-ны өдөр Говь-Алтай аймгийн ... суманд төрсөн, 74 настай эрэгтэй, дээд боловсролтой, сэтгүүлч, багш мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Монголын Үндэсний Радио, TV-8 телевизийн улс төрийн тоймч, “Зохиомж” дээд сургуулийн зөвлөх багшаар ажиллаж байсан, ам бүл 2, эхнэрийн хамт Чингэлтэй дүүргийн ... дугаар хороолол, ... дугаар хороо, ... дүгээр байрны ... тоотод оршин суух хаягтай, Соёлын гавьяат зүтгэлтэн, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдаж байсан, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Ц нь 2010 оны 1 дүгээр сард төрсөн, 7 настай эцгийн хамт амьдардаг, сэтгэцийн хувьд оюуны хүндэвтэр хомсдол эмгэгтэй, эмэгтэй, үнэн зөв мэдүүлэг өгөх чадваргүй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Д нь 2017 оны 10 дугаар сарын 01-ны өдөр Чингэлтэй дүүргийн ... дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах

“Шадивлан” зуслангийн ... тоотод өөрийн уран бүтээл хийдэг гэх зуны байшиндаа бага насны хүүхэд 7 настай эмэгтэй Б.Ц-г гадуур куртикийг нь тайлсан, түшлэгтэй сандал дээр гадуур өмдийг нь дотоожтой нь цуг өвдөг хүртэл нь шувталж дээшээ харуулан хэвтүүлсэн, өөрийнхөө гадуур өмд, дотоожны хамт шувталчихсан охины өмнө сөхөрч суун, өөрийнхөө бэлэг эрхтнээ гараараа оролдох зэрэг үйлдэл хийж, хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Согтуурсан үедээ өөрийгөө удирдан жолоодох чадваргүй болсон, өндөр настай боловч бэлгийн харьцаанд орох чадвартай зэрэг нь шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон зэрэг нь бэлгийн харьцаанд орох сэдэлтийг төрүүлсэн байх боломжтой.

Оногдуулсан ял: Бага насны хүүхдийг хүчиндэхийг завдсан үйлдэлд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.5 хэсгийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 9 жилийн хугацаагаар хорих оногдуулсан байна.

Дүгнэлт: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг үйлдэхээр завдсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1.5 хэсгийг журамлан 9 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан нь тохирсон гэж үзэх үндэслэлтэй. Шүүх ял оногдуулахдаа хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ,

бусдад төлөх төлбөргүй, 74 настай, улсаас авсан гавьяа шагнал, үр бүтээлтэй ажилласан байдал зэрэг хувийн байдлыг хөнгөрүүлэх нөхцөл болгон авч үзсэн байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх энэ зүйлд заагаагүй онцгой нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж болно” гэж заасныг удирдлага болгон зарим хувийн байдлыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамааруулсан нь үндэслэлтэй байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 201619000727

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №100, 2017.03.27

Шийдвэрлэсэн шүүх: Төв аймаг дахь Сум дундын дүүргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн М.А, 1962 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, 54 настай, бүрэн дунд боловсролтой, мужаан мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 3, 6-8 насны хоёр хүүхдийн хамтаар Төв аймгийн ... сумын ... дүгээр багт оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд Нийслэлийн шүүхийн 1997 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор 1986 оны Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйл, 112 дугаар зүйлийн 3, 239 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 13 жилийн хорих ял шийтгүүлж, 2005 оны 3 дугаар сарын 17-ны өдөр эдлээгүй үлдсэн 2 жил, 1 сар, 3 хоногийн хорих ялыг хугацаанаас өмнө тэнсэн сулагдсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: 2003 оны 6 дугаар сард Төв аймагт төрсөн, 13 настай, хойд эцэг, 2

дүүгийн хамт Төв аймагт оршин суудаг. Эх “Ц” нь хойд эцгээс салаад өөр хүнтэй амьдардаг, Төв аймгийн ... сумын ерөнхий боловсролын сургуульд суралцдаг.

Хэргийн товч утга: Шүүгдэгч М.А нь 2016 оны 7 дугаар сард Батсүмбэр сумын Мандал ... дүгээр баг Улаан хутгын ... тоотод хохирогчийн 13 настайд нь өөрөөр хэлбэл 14 насанд хүрээгүй бага насны хүүхэдтэй тохиролцож, хохирогч өөрөө хүссэн шалтгаанаар хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэр бүлийн тогтворгүй байдал, гэр бүлээс гадуурх эр, эмийн харилцаа, эцэг, эхийн хүүхдэд тавих хараа хяналт сул, хохирогчийн буруутай үйлдэл, гэмт этгээдийн ёс суртахуунгүй байдал, зан төлөвийн доголдол, согтууруулах ундааны зүйлд донтсон байдал зэрэг нь гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болжээ.

Хохирогч “Г” нь эцэг, эхээс зургуулаа, айлын бага охин байсан бөгөөд түүний төрсөн эцэг нас барсны дараа эх “Ц” нь 2005 онд шүүгдэгч А-тай танилцаж хамтран амьдарч 2 хүү төрүүлсэн байна. “Ц”, “А” нар хамтран амьдрах хугацаандаа гэр бүлийн орчинд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, хэрүүл маргаан ихтэй байсан шалтгаанаар тусдаа амьдрах болсон. Хохирогчийн эх “Ц” нь 2015 онд өөр хүнтэй гэр бүлээс гадуур харьцаатай болж, гэр бүлээ орхиж явснаас хохирогч “Г”, төрсөн 2 дүүгийн хамт хойд эцэгтэйгээ амьдрах болсон.

Энэ хугацаанд хохирогчийн биеийн юм ирж, тусламж хүсэх хүн байхгүй болсноос хойд эцэгтээ хандсан байдаг. Үүнээс хойш тэр хоёрын дунд бэлгийн харьцааны талаарх яриа өрнөдөг болсон нь гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болжээ.

Шүүгдэгчийн мэдүүлгээс үзэхэд, хүүхдүүдээ дагуулан хөдөө ажлаар явдаг байсан, хохирогч заримдаа хэд хоногоор алга болдог байсан, хэрэг болдог өдөр тэд бэлгийн харьцааны талаар шөнө дунд хүртэл ярилцаж байгаад бэлгийн харьцаанд оржээ. Мөн хохирогчийн зан суртахууны доголдол, эцэг, эхийн буруу нөлөө гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл болсон нь “Та миний аав биш, би секс үзсэн гээд хувцсаа тайлж дээр нь гарсан, би бэлгийн дур хүсэл ханасан бол та ямар хамаатай юм, секс амархан ш дээ” гэсэн шүүгдэгчийн мэдүүлгээс харагдаж байна. Мөн хохирогч аавтай бэлгийн харилцаанд орсон тоогоо мартсан гэж үзсэнээс дүгнэхэд бэлгийн харьцаанд тогтмол ордог, шинжээчийн дүгнэлтээс үзэхэд онгон хальсны хуучин урагдалтай гэж тогтоогдсон нь хохирогчийн хувьд бэлгийн харилцаанд эрт орсон гэх үндэслэлтэй байжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч А-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар бага насны өөрөөр хэлбэл 14 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэж үзэж 20 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлэх, шүүгдэгчийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцож, цагдан хоригдсон 171 хоногийг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохоор шийдвэрлэжээ.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял тохирсон байна. Шүүх ял оногдуулахдаа шүүгдэгч болон хохирогч тохиролцож бэлгийн харьцаанд орсон боловч хохирогч бэлгийн харьцааны талаар бүрэн гүйцэд ойлголтгүй, түүний хор уршгийн талаар мэдэх чадваргүй, бэлгийн бойжилт дутуу байсан, аавтай бэлгийн харьцаанд орсон тоогоо мартсан зэргийг удирдлага болгон хүчиндэх

гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн нь үндэслэлтэй. Хохирогчийн мэдүүлэгт дурдсанаар удаа дараа хүчиндүүлж байсан гэж байгаа боловч шүүх зөвхөн нотлогдсон нэг удаагийн үйлдэлд үнэлэлт өгч ял оногдуулсан байна. Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар “...бага насны өөрөөр хэлбэл 14 насанд хүрээгүй хүн”-ийг хүчиндсэн бол 15-25 жилийн хугацаагаар хорих ял, эсхүл цаазаар авах ял шийтгэхээр заасан байхад шүүх хохирогчийг 2 жилийн хугацаанд тэжээн тэтгэж асран хамгаалж байсан, тохиролцож бэлгийн харьцаанд орсон, хохирогчийн буруутай үйлдэл байсан зэргийг харгалзан 20 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсныг хууль зүйн үндэслэлтэй гэж үзэж байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-4

Эрүүгийн хэргийн дугаар: 201311000273

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: №122, 2013.11.14

Шийдвэрлэсэн шүүх: Дорнод аймгийн Хэрлэн сумын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Б, 1980 оны 8 сарын 22-ны өдөр Дорнод аймгийн Баяндун суманд төрсөн, 38 настай, боловсролгүй, тракторчин мэргэжилтэй, ам бүл 6, эхнэр, 4 хүүхдийн хамт Дорнод аймгийн ... сумын ... дүгээр багийн ... тоотод оршин суух, “Авто арга” ХХК-д тракторын жолоочоор ажиллаж байсан, гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Д.Г, 15 нас 4 сартай, Дорнод аймгийн ... сумын ... дүгээр багийн ... тоотод өөрийн эх,

хойд эцэг, 3 дүүгийн хамт амьдардаг, ерөнхий боловсролын сургуулийн сурагч, үнэн зөв мэдүүлэг өгөх чадвартай.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Б нь 2005 оноос 2013 оны 4 сарын 8-ны өдөр хүртэл дагавар охин Д.Г-г 14 насанд хүрээгүй байх үеэс буюу 8 настайгаас нь 15 нас 4 сар 27 хоног хүртэлх хугацаанд удаа дараа хохирогчид хүч хэрэглэхээр заналхийлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдэд тавих хараа хяналт сул, шүүгдэгчийн нийгэмд эзлэх байр суурь, боловсролын түвшин гэмт хэрэг үйлдэх шалтгаан болжээ. Хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, шүүгдэгч бага насны дагавар охиноо өөрийн хүүхэд биш, цусан төрлийн холбоогүй учир бэлгийн харьцаанд орж болно гэсэн бодол нь гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болжээ. Шүүгдэгч хохирогчийн ээжтэй гэр бүл болоод 10 гаруй жил болсон бөгөөд тэдний дундаас 3 хүүхэд төрсөн. Түүний эх хохирогчийг багаас нь аав нь гэж итгүүлж, хамт өсгөсөн бөгөөд шүүгдэгчид итгэж дагавар охиноо хамт үлдээдэг байсан, шүүгдэгч согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэж, гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлддэг байсан нь уг хэргийг тэр даруйд нь илчлэх боломжгүй болгож, 7 жил орчим удааширсан байна. Хохирогч өөрийн төрсөн дүүдээ энэ талаар ярьж, дүү нь ээждээ мэдэгдсэнээр гэмт хэрэг илэрсэн.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Б.Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэнд гэм буруутайд тооцож, 16 жилийн хорих ялаар

шийтгэж, ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэж, цагдан хоригдсон 216 хоногийг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцжээ.

Дүгнэлт: Гэмт хэргийг согтуугаар үйлдсэн, удаа дараа хүчиндсэн, үйлдэл нь удааширсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг байсан зэрэг хувийн байдлыг нь харгалзан үзвэл 16 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан нь хөнгөдсөн гэж үзэж байна. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийг хүчиндэх тохиолдол цөөнгүй байгаа хэдий ч оногдуулах ял нь хөнгөн байх магадлал ихтэй байгаа нь шүүхээр шийдвэрлэгдсэн бусад гэмт хэргүүдээс харагдаж байна. Үүний шалтгаан нь хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь шүүгдэгчтэй мөн гэр бүлийн хамааралтай тул гомдолгүй, нэхэмжлэх зүйлгүй, шүүгдэгчийг гэр бүлийг тэжээн тэтгэх хүнгүй гэсэн шалтгаан зонхилж байжээ.

Судалгаанаас үзэхэд, эцэг, эх нь ажилгүй, орлого багатай байдаг, гэр бүлийн тогтворгүй байдал, гэр нь хөдөө, эцэг эх нь гадаадад хөдөлмөр эрхэлдэг байдал, ар гэрийн хяналт сул зэрэг нь эрсдэлт хүчин зүйл болж байна. Иймд хүүхдэд учирч болзошгүй эрсдэл, тэдэнд учирч болох хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй ажиллах үйл ажиллагааны төлөвлөлт гарган ажиллахад багш, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагаа чухал байна. Бид эцэг эх, асран хамгаалагчидтай ажиллах арга барилаа өөрчлөх, эцэг, эхийн хурлыг хийдэг уламжлал болсон зохион байгуулалтын ажлаа ч эргэн харах хэрэгтэй болжээ.

“Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч,

иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл”-ийг 2019 онд баталж, үлгэрчилсэн чиглэлд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг нийт захирлуудад үүрэг болгосныг дэмжиж байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-5

Эрүүгийн хэргийн дугаар: 201419000647

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 30а, 2015.07.08

Шийдвэрлэсэн шүүх: Төв аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн ... овогт Э.Д, 1997 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Дундговь аймагт төрсөн, 17 настай, эрэгтэй, халх, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, ам бүл 5, аав, ээж, 2 дүүгийн хамт Төв аймгийн Алтанбулаг сумын ... дүгээр багт оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэл эдэлж байгаагүй, бие эрүүл, ухаан бүрэн.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ш.Ч, 13 настай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Э.Д Төв аймгийн Алтанбулаг сумын сургуулийн дотуур байранд 13 настай Ш.Ч-г удаа дараа хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэмт хэргийн нөхцөл байдлаас үзэхэд, эцэг, эхийн хүүхдэдээ тавих хараа хяналт сул, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар гэр бүл, ангийн багш, нийгмийн ажилтан сурагчдад мэдлэг, мэдээлэл өгөх

явдал дутмаг, охидын үзлэгийг тогтмол зохион байгуулдаггүй, анги хамт олны нөлөө, интернэт, нийгмийн сүлжээний хяналтгүй байдлаас шалтгаалан хүүхдүүд бэлгийн харьцаанд эрт орох болсон зэрэг нь энэ гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Э.Д-д хохирогч Ш.Ч-г 16 насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар 3 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, түүнд оногдуулсан хорих ялыг Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт зааснаар тэнсэж, хянан харгалзахаар тогтоосон.

Дүгнэлт: Шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг шинжлэх судлаад Төв аймгийн прокурорын газраас шүүгдэгч Э.Д-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг болгон зүйлчлэлийг өөрчилсөн нь зүйтэй байна. Учир нь шүүгдэгч, хохирогч, гэрч нарын өгсөн мэдүүлгээс үзэхэд, шүүгдэгч хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хуульд заасан аргаар бэлгийн харьцаанд орсон байдал харагдахгүй, сайн дурын үндсэн дээр бэлгийн харьцаанд орсон байж болзошгүй байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн шинжийг 18 насанд хүрсэн хүн 14 насанд хүрсэн, 16 насанд хүрээгүй гэдгийг мэдсэн, мэдэх боломжтой байтал бэлгийн харьцаанд орсон гэж хуульчилсан. Хэрэв энэ гэмт хэрэг шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс

хойш үйлдэгдсэн бол хохирогч 13 настай учраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.5 дугаар зүйлээр бус, 12.1 дүгээр зүйлд заасан хүчиндэх гэмт хэргээр зүйлчилж, шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх байв.

Эрүүгийн хэргийн дугаар: 21019179

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 288, 2011.11.08

Шийдвэрлэсэн шүүх: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн ... овогт Н.М, 1982 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох суманд төрсөн, 29 настай, эрэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар ангиас завсардсан, боловсролгүй боловч унших, бичих чадвартай, мэргэжилгүй, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн ... дүгээр хороо, ... тоотод бүртгэлтэй, ам бүл 3, эхнэр, хүүхэдтэй, эхнэр Л.Т-ээс 2009 оноос тусдаа амьдарч, гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргасан гэх, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгүүлж байгаагүй, бие эрүүл, ухаан бүрэн, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Д.С, 10 нас, 5 сартай, эмэгтэй.

Монгол Улсын иргэн Э.Н, 9 нас, 7 сартай, эмэгтэй.

Монгол Улсын иргэн О.Б, 8 нас, 1 сартай, эмэгтэй.

Монгол Улсын иргэн Р.М, 7 нас, 10 сартай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Н.М 2010 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр хохирогч Д.С-г хүчиндэж, энэ хэргээ хялбарчлах зорилгоор, хохирогчийн

биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж хоолойг боон амьсгал бүтэлтэд оруулан санаатай алахыг завдсан, 2010 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр танхайн сэдэлтээр хохирогч Э.Н-г биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж түүний хоолойг боож алахыг завдсан, 2010 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр хохирогч О.Б-г хүчиндэж, энэ хэргээ хялбарчлах зорилгоор, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж хоолойг боон амьсгал бүтэлтэд оруулан санаатай алахыг завдсан, 2010 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хохирогч Р.М-г хүчиндсэн, шулуун гэдсээр хурьцал үйлдэж, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан, энэ хэргээ хялбарчлах зорилгоор, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж хоолойг боон амьсгал бүтэлтэд оруулан санаатай алсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бусад хүчин зүйлээс шалтгаалан бэлгийн гаж зуршил, бэлгийн олон хамтрагчтай байх үзэгдэл нэмэгдсээр байна. Бага насны хүүхдэдээ тавих хараа хяналт сул, гудамж талбай, олон нийтийн газар, орцны гэрэлтүүлэг, камерын хяналт муу, бага насны хүүхдээ танихгүй хүнтэй ярилцах, чихэр, жимс авахгүй байх, дагаж гэр, бусад газар луу явахгүй байх талаар эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч хэлж ойлгуулаагүй зэрэг байдал нөлөөлжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Н.М-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 125 дугаар зүйлийн 125.2-т зааснаар 10 жилийн хугацаагаар хорих ял, мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар 25 жилийн хугацаагаар хорих ял, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 60 дугаар зүйлийн 60.3, 60.4-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн

91.2.2, 91.2.6, 91.2.10, 91.2.15-д зааснаар 10 жилийн хугацаагаар хорих ял, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.6, 91.2.10, 91.2.15-д зааснаар цаазаар авах ял тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар шүүгдэгчид оногдуулсан хөнгөн ялыг хүндэд нь багтааж, түүний биечлэн эдлэх ялыг цаазаар авах ялаар тогтоосон байна.

Дүгнэлт: Шүүгдэгчдэд оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 201211000430

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 18, 2013.04.10

Шийдвэрлэсэн шүүх: Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Д.Х, 1990 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Сүхбаатар аймгийн Түвшинширээ суманд төрсөн, 23 настай, эрэгтэй, бага боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, Дорнод аймгийн Хэрлэн сумын ... дугаар багийн ... гудамжны ... тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн М.С, 5 нас, 25 хоногтой, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Д.Х 2011 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Дорнод аймгийн Баянтүмэн сумын ... дугаар багийн нутаг ... гэх

газар хохирогч М.С-ийг биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хүчиндсэн, мөн өөрийн биед бэлгийн замын халдварт өвчин байгааг мэдсээр байж халдаасан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бага насны хүүхдэд тавих анхаарал сул, сумын эмч бэлгийн замын халдварт өвчин туссан, хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй бага насны хүүхэд эмнэлгийн тусламж авахаар ирэхэд зөв оношлоогүй, цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй нь энэ гэмт үйлдэгдэхэд нөлөөлжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Д.Х-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар 15 жил 1 сарын хугацаагаар хорих ял, мөн хуулийн тусгай ангийн 103 дүгээр зүйлийн 103.2-д зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ял тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар шүүгдэгчид оногдуулсан ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 15 жил 7 сарын хугацаагаар хорих ялаар тогтоосон байна.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалтай нийцэхгүй хөнгөдсөн байна. 5 нас 25 хоногтой хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчтэй гэдгээ мэдсээр байж халдаасан этгээдэд тухайн зүйлд заасан хорих ялын хэмжээний хамгийн багаар ял оногдуулсан нь учир дутагдалтай байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 2017....

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
103, 2017.08.21

Шийдвэрлэсэн шүүх: Хэнтий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Х.А, 1977 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд төрсөн, 40 настай, эрэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 5, эхнэр, 3 хүүхдийн хамт Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын 2 дугаар багт оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд Хэнтий аймгийн Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 55 дугаартай шийтгэх тогтоолоор 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар 2 жилийн хорих ялаар шийтгүүлж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн А.Н, 14 настай, бэлгийн бойжилт бүрэн олоогүй, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Х.А 2016 оны 8 дугаар сард Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ... дугаар багийн нутаг ... гэх газар хохирогч А.Н-г хүч хэрэглэн хүчиндсэн, мөн сард Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ... дугаар багийн нутагт иргэн Л.А-ийн гэрт хохирогч А.Н-г хүч хэрэглэн давтан хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бага насны хүүхдэдээ тавих эцэг, эхийн анхаарал сул, тэдэнтэй ярилцаж, санал бодлыг асуудаггүй, хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй сэжигтэй байдал илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн

болон хууль сахиулах байгууллагад хандаагүй хайнга байдал нөлөөлжээ. Тухайлбал, шүүгдэгч Х.А хохирогчийг хээр хүчиндээд мотоциклдоо сундлаад гэрт нь хүргэж ирэхэд болон гэртээ байхад нь хүчиндсэний дараа хохирогчийн нүүр нэлээд улайсан, дотроо юм бодоод гөлрөөд, юм асуухаар дуугарахгүй, сандарсан байдалтай байхад эцэг, эх нь түүнийг яагаад байгаа юм бол бие нь муу байгаа юм бол уу гэж бодоод өнгөрсөн байдаг.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Х.А-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх зааснаар 13 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгч Х.А нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан гэмт хэргийг хоёр удаа үйлдсэнийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцсон талаар шүүх шүүхийн шийтгэх тогтоолд дурдсан боловч тухайн зүйлд заасан 12-20 жил хүртэл хугацаагаар хорих, бүх насаар хорих ялаас 13 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан нь учир дутагдалтай байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-9

Эрүүгийн хэргийн дугаар: 1806024281779

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
129, 2019.01.15

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн С.А, 1999 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 19 настай, эрэгтэй,

бага боловсролтой, экскаваторын оператор мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 5, эх, эгч, 2 дүүгийн хамт Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, Улаанхуарангийн ... тоотод оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн А.М, 12 нас, 8 сартай, эмэгтэй, сурагч.

Хэргийн товч утга: Шүүгдэгч С.А 2017 оны 3 дугаар сараас 5 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 3 удаа Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, Улаанхуарангийн ... тоотод гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох хохирогч А.М-д хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орж, хохирогчийг жирэмсэн болгосон.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бага насны хүүхдэдээ тавих эцэг, эхийн анхаарал сул, тэдэнтэй ярилцдаггүй, биеийн байдал, эрүүл мэндийн байдлыг ажигладаггүй байдал нөлөөлсөн байна. Тухайлбал, хохирогчийг шүүгдэгчид хүчиндүүлж, жирэмсэн болсон гэдгийг 5 сарын дараа эмнэлэгт үзүүлж мэдсэн бөгөөд улмаар цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, ураг хөндүүлсэн байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгч С.А-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх зааснаар 12 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгч С.А нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан гэмт хэргийг хоёр удаа үйлдсэн, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.6-д заасан эрүүгийн

хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдсон байсаар байтал шүүх шүүхийн шийтгэх тогтоолдоо Эрүүгийн хуулийн 6.5, 6.6 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэжээ. Улмаар тухайн зүйлд заасан 12-20 жил хүртэл хугацаагаар хорих, бүх насаар хорих ялаас 12 жилийн хугацаагаар хорих ялыг сонгож оногдуулсан нь учир дутагдалтай бөгөөд шүүгдэгчид оногдуулсан ял илтэд хөнгөдсөн, эрүүгийн хариуцлага нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна гэсэн шударга ёсны зарчимтай нийцэхгүй байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-10

Эрүүгийн хэргийн дугаар: 1806073501584

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
270, 2019.02.15

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Д.Э, 1958 оны 2 дугаар сарын 22-ны өдөр төрсөн, 61 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, өрмийн мастер мэргэжилтэй, группэд байдаг гэх, ам бүл 2, эхнэрийн хамт Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ... багийн ... тоотод оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Д.Ц, 5 настай, эмэгтэй, шүүгдэгчийн ач охин.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Д.Э 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, ... хорооллын ... дугаар байрны ... тоотод хүү Э.Д-ийн 5 настай охин Д.Ц-г хамт унтахаар хэвтэж байхад нь бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн /бэлэг эрхтэн рүү нь хуруугаа хийсэн/.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Архидалт, бэлгийн гаж зуршил нөлөөлсөн байж болзошгүй байна. Тухайлбал, шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн байсан нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогддог.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Д.Э-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх зааснаар 12 жил, 3 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д заасан хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж үйлдсэн байтал шүүх шүүхийн шийтгэх тогтоолдоо Эрүүгийн хуулийн 6.5, 6.6 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэсэн нь учир дутагдалтай байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 201519000679

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 117, 2016.03.31

Шийдвэрлэсэн шүүх: Төв аймгийн Сум дундын эрүүгийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Г.П, 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

Төв аймгийн Сэргэлэн суманд төрсөн, 25 настай, эрэгтэй, боловсролгүй, жолооч мэргэжилтэй, ажилгүй, ам бүл 2, хүүхдийн хамт Төв аймгийн ... сумын ... дугаар баг ... тоотод оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Э.Ц, 14 насанд хүрээгүй, оюуны хүндэвтэр хомсдол буюу сэтгэцийн эмгэгтэй, ам бүл 4, аав, ээж, эгч дүүгийн хамт амьдардаг.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Г.П нь 2015 оны 4 дүгээр сарын 1, 2015 оны 6 дугаар сарын 20, 2015 оны 8 дугаар сарын 15-ны өдөр тус тус өөрийн гэртээ болон ... улсын дугаартай портер маркийн тээврийн хэрэгсэлд оюуны хүндэвтэр хомсдол сэтгэцийн өвчтэй бага насны Э.Ц-г биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хүч хэрэглэхээр заналхийлж, хутга тулган айлган сүрдүүлж хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь хохирогчийн ээжийн төрсөн эгчийн хүүхэд нь бөгөөд хохирогчийг оюуны хомсдол буюу сэтгэцийн эмгэгтэй гэдгийг мэднэ. Уг гэмт хэргийн улмаас хохирогч нь үтрээний үрэвсэл, бэлгийн замын халдварт трихомонус өвчтэй болсон байна. Гэмт хэрэг үйлдэхдээ хутга тулган айлган сүрдүүлж, хүч хэрэглэж үйлдсэн байна. Гэмт хэрэг үйлдэгдэхэд хүүхдэд тавих хараа хяналт сул, өөрийн гэсэн амьдрах орон гэргүй хүний хашаанд түр амьдардаг зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Г.П-д 17 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүхээс шүүгдэгч Г.П-ийн үйлдэлд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдсонгүй. Харин гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэнийг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцож ял оногдуулжээ.

Эрүүгийн хэргийн дугаар: 1706000000134

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 844, 2017.12.13

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Э.В, 1989 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 28 настай, эрэгтэй, бага боловсролтой, мэргэжилгүй, ажилгүй, ам бүл 2, ээжийн хамт Баянзүрх дүүргийн ... дугаар хороо ... байрны ... орцны жижүүрийн 00 өрөөнд оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Х, 6 нас 10 сартай, ам бүл 2, ээжийн хамт тодорхой оршин суух хаяггүй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Э.В нь 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Баянзүрх дүүргийн ... дугаар хороо ... байрны ... орцны жижүүрийн 00 өрөөнд гэр бүлийн хамаарал бүхий дагавар охин 6 настай Б.Х-г өөрийн эрхшээлдээ байгааг далимдуулан бэлгийн замын халдварт өвчин халдааж, хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Хохирогчийн эх Б нь хохирогчийг 4 сартай байхад эцгээс нь салсан бөгөөд тогтмол архи уудаг, амьдрах

гэр оронгүй хүүхдээ хаана тааралдсан газраа үлдээдэг байсан байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй охиноо 4 сартай байхад танилцаж, 6 жил шахуу хамт амьдарч байгаад салсан байдаг. Уг гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл нь архи дан согтуурах явдлаас гадна гэр оронгүй, тэнэмэл байдал юм. Иймээс охиныг улсын асрамжид авсан байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Э.В-д 18 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүх хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэнийг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцож ял оногдуулжээ.

ТҮҮВЭР СУДАЛГАА-13

Эрүүгийн хэргийн дугаар: 1809034060849

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 94, 2019.01.24

Шийдвэрлэсэн шүүх: Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Н.Э, 1992 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Ховд аймагт төрсөн, 26 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, “Дородус” ХХК-д будагчин ажилтай, ам бүл 5, эхнэр, 3 хүүхдийн хамт Сүхбаатар дүүргийн ... хороо Хандгайтын ... тоотод оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Л, 8 настай.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Н.Э нь 2018 оны хавар удаа дараа дагавар охин 8 настай Б.Л-ийн аманд бэлэг эрхтнээ хийж, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Шүүгдэгч нь биеэ зөв авч явах нийгэм, гэр бүлийн харилцаанд тогтсон ёс суртахууны хэм хэмжээг ноцтой зөрчсөн, гэр бүлийн гишүүдийн нандин холбоо харилцаа, нийгэмд зөв амьдрах зан төлөвшил хэвшээгүй зэрэг нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Э-д 13 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэжээ. Хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүгдэгч Н.Э-д эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзсэн байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 1811027650895

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 94, 2019.01.28

Шийдвэрлэсэн шүүх: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн М.С, 1989 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Өвөрхангай аймгийн Сант суманд төрсөн, 29 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, ажилгүй, ам бүл 3, эхнэр, хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ... хороо ... тоотод оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.А, 12 настай, ам бүл 3, ээж, хойд аавын хамт амьдардаг.

Хэргийн товч утга: Шүүгдэгч М.С нь 2018 оны 8 дугаар сараас 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Чингэлтэй дүүргийн 4, 5, 6-р хорооны нутаг дэвсгэрт ... улсын дугаартай “Тоёото приус” маркийн автомашинд хохирогчийг удаа дараа хүчиндэж, жирэмсэн болгосон.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Шүүгдэгчийг эцэг эх, найз нөхөд, эхнэр хүүхэд, нутгийн хүмүүс нь ийм гэмт хэрэг үйлдэх хүн биш, мал маллаж байгаад хотод ирж гэр бүл зохиогоод эхнэр, хүүхдээ ажил сургуульд нь зөөдөг төлөв томоотой хүн гэж мэдүүлсэн байдаг. Гэтэл шүүгдэгч бэлгийн дур хүслээ хангах гэсэн сэдлээр бага насны хүүхдийг таксинд суухад өдөж хоргоосон ёс зүйгүй үйлдэл гаргасан боловч энэ гэмт хэрэгт хохирогчийн буруутай буюу таксины жолоочид утасныхаа дугаарыг өгсөн яриад дуудах болгонд уулзсанаас гадна, эцэг эхийн хараа хяналт сул, шилжилтийн үед эцэг эх, сургуулийн зүгээс бэлгийн харилцааны талаар мэдлэг олгодоггүй, тухайн хүүхдийн төлөвшил хүмүүжил зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгчид 12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүхээс эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзсэн.

Эрүүгийн хэргийн дугаар: 1706013680324

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
1578, 2018.11.20

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн
Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.О, 1981 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Архангай аймгийн Эрдэнэмандал суманд төрсөн, 38 настай, эрэгтэй, бага боловсролтой, жолооч мэргэжилтэй, ажилгүй, ам бүл 6, эхнэр, 4 хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ... хороо Туулын ... тоотод оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн О.Л, 13 настай.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.О 2016 оны 7 дугаар сараас 2017 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд удаа дараа өөрийн гэртээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай өөрийн дагавар охин 13 настай О.Л-ыг хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Охиноо гэмт хэрэгт өртчихвий, хохирогч болчихвий гээд хамгаалаад явж байх ёстой эцэг хүн нь удаа дараа хүчиндэж, зодож байсан нь үнэхээр харамсалтай. Энэ гэмт хэргийн хувьд охин анх 2016 оны 7 дугаар сард хүчиндүүлээд ээждээ хэлсэн байдаг ба ээж нь аавтай нь хэрэлдэж зодуулсан учир түүнээс болоод дахин хэлж байгаагүй бөгөөд 5 дахь өдөр хичээлээ тараад ирэх болгонд ийм зүйл болдог гэжээ. Хүүхдэдээ тавих хараа хяналт сул, гэр бүл салж өөр хүнтэй суусан, хүүхдийнхээ үгэнд итгээгүй, нөхөр нь би юу гэж тэгэх вэ? охиноо эрхлүүлсэн гэхээр итгэснээс охин нь 12 настайгаасаа бүтэн жил гаран гэмт хэргийн хохирогч болжээ.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгчид 18 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Энэ гэмт хэргийн улмаас хохирогч О.Л нь гэмтлийн дараах дарамтад эмгэгтэй болсон ба уг эмгэг нь олон улсын өвчний 10 дугаар ангилалд ордог. Гэмтлийн дараах дарамтад эмгэг нь тухайн хүнд гэмтэл учруулсан мөчөөс бий болсон сэтгэлийн дарамт бүхий үйл явдал, нөхцөл байдалд өгөх хариу урвалыг хэлнэ гэж шинжээч эмч мэдүүлжээ. Ингэж гэмт хэргийн дараах үлдэц хор уршгийг тодорхойлж, хүчиндүүлэх гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдэд сэтгэл заслын эмчилгээ хийх зайлшгүй шаардлагатайг харуулсан нь маш зүйтэй сайн жишиг тогтоох зүйл болсон байна гэж үзэж байна. Шүүхээс эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзсэн байна.

**ТҮҮВЭР
СУДАЛГАА-16**

Эрүүгийн хэргийн дугаар: 201611000346

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
12, 2017.01.11

Шийдвэрлэсэн шүүх: Дорнод аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Н.Э, 1978 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 39 настай, эрэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, жолооч мэргэжилтэй, “Дорнын их гэгээ” ХХК-д жолооч ажилтай, ам бүл 3, эхнэр, хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ... хороо ... тоотод оршин суух, урьд нь Сонгинохайрхан дүүргийн

шүүхийн 1996 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 4 тоот таслан шийдвэрлэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 94 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 жилийн хорих ялаар шийтгүүлж, тогтоол биелүүлэхийг 2 жилийн хугацаагаар хойшлуулсан, Нийслэлийн шүүхийн 1996 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн таслан шийдвэрлэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 239 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 1 жил 6 сарын хорих ялаар, 112 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 2 жилийн хорих ялаар тус тус шийтгүүлж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 37 дугаар зүйлд зааснаар ялыг нэмж нэгтгэн 3 жил 6 сарын хорих ялаар, мөн хуулийн ерөнхий ангийн 38 дугаар зүйлд зааснаар энэ тогтоолоор оногдуулсан 3 жил 6 сарын хорих ял дээр Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 1996 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 4 тоот таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан 2 жилийн хорих ялаас 1 жилийн хорих ялыг нэмж нийт 4 жил 6 сарын хорих ялаар шийтгүүлж, Баянзүрх дүүргийн шүүхийн 1998 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 365 тоот захирамжаар 7 сар 2 хоногийн ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 1999 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 9 тоот таслан шийдвэрлэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 239 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 3 жилийн хорих ялаар шийтгүүлж, 2002 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр суллагдсан, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Х, 14 насанд хүрээгүй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Н.Э нь 2016 оны 7 дугаар сарын 20-21-нд шилжих шөнө Дорнод аймгийн Баяндун сумын ... дүгээр багийн нутаг

“Цагаан чулуутын адаг” гэх газарт оршин суух иргэн Ч.Б-ийн гэрт бага насны буюу 14 насанд хүрээгүй Б.Х-г хүч хэрэглэж, хүчиндэхийг завдсан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Шүүгдэгч танил ахтайгаа архи ууж яваад хохирогчийн өвөөгийн ирж цуг архи уусан байдаг. Ингээд бүгд унтацгаасан бөгөөд шөнө бага насны хүүхэд унтаж байсан орон дээр гарч бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийж байхад эмээ нь сэрж гэрэл асааснаар энэ гэмт хэрэг туйлдаа хүрээгүй байдаг. Энэ гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг харахад архи согтууруулах ундааг эмээ, өвөө, таньдаг, мэддэг хамаагүй нийлж хэтрүүлэн хэрэглэдэг, хүүхдэдээ тавих хараа хяналт сул, хайхрамжгүй байдлаас болж бага насны хүүхэд хохирсон байна.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.3, 60 дугаар зүйлийн 60.3-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар шүүгдэгчид 4 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэжээ. Хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүгдэгчийг анх удаа гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж, ял хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцсон, мөн гэмт хэргээ туйлд нь хүргээгүй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шүүх ял оногдуулсан байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 201519000499

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
75, 2016.02.22

Шийдвэрлэсэн шүүх: Төв аймгийн сум дундын
Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын
иргэн Н.Э, 1997 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр
Улаанбаатар хотод төрсөн, 17 настай, эрэгтэй,
бүрэн бус дунд боловсролтой, мэргэжилгүй,
Төв аймгийн Эрдэнэ сумын МСҮТ-д 1 дүгээр
курст сурдаг, ам бүл 3, эмээгийн дээд дүүгийн
хамт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг,
Хандгайтад оршин суух, урьд ял шийтгүүлж
байгаагүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол улсын
иргэн У.У, 7 настай.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Н.Э нь 2015 оны
8 дугаар сарын 20-ны шөнө Төв аймгийн Эрдэнэ
сумын ... дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах
Си Эй Эй Си ХХК-ны ажилчдын байранд 7
настай, эмэгтэй, У.У-г бага насны буюу биеэ
хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан
хүчиндэж, бэлэг эрхтэн рүү нь хуруугаа хийж,
бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Хохирогчийг
2 хүүхдээ харуулах зорилгоор аав, ээжээс нь
асууж амралтын газраа авчирсан байдаг ба
хүмүүст амралтын өрөө хүлээлгэж өгөх хооронд
гэмт хэрэг үйлдэгдсэн байдаг. Гэмт хэрэг үйлдсэн
этгээд нь газ үнэртэж мансуурдаг ба тухайн үед
газ үнэртэж мансуурсан болсон явдлыг санахгүй
байна гэдэг. Үүнээс үзэхэд, бага насны хүүхдэд
тавих хараа хяналт сул, танихгүй, итгэж
болохгүй хүмүүст хүүхдээ үлдээх, мансуурах,
донтох байдал нь нөлөөлжээ.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар шүүгдэгчид 15 жил 1 сарын хугацаагаар хорих ял, мөн хуулийн 125 дугаар зүйлийн 125.2 дахь хэсэгт зааснаар 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар Н.Э-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 125 дугаар зүйлийн 125.2-т зааснаар 5 жил 1 сарын хугацаагаар оногдуулсан хорих ялыг мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-т зааснаар оногдуулсан 15 жил 1 сарын хугацаагаар хорих ялд буюу хөнгөн ялыг хүндэд багтааж, Н.Э-ийн биечлэн эдлэх ялыг 15 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар тооцжээ. Хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүгдэгчийн үйлдэлд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх үндэслэл байхгүй. Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлийн 56.1.4 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, 56.1.6 дахь хэсэгт заасан бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж ялыг хүндрүүлэн үзжээ.

**ТҮҮВЭР
СУДАЛГАА-18**

Эрүүгийн хэргийн дугаар: 1811009840532

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
755, 2018.10.25

Шийдвэрлэсэн шүүх: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ж.Б, 1981 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Төв аймагт төрсөн, 37 настай, эрэгтэй, бүрэн дунд

боловсролтой, тогооч мэргэжилтэй, эрхэлсэн ажилгүй, ам бүл 4, эхнэр, 2 хүүхдийн хамт, Баянзүрх дүүргийн ... хороо ... дугаар гудамжны ... тоотод оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Е, 8 настай, ам бүл 6, аав, ээж, эгч, дүүгийн хамт амьдардаг.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Ж.Б нь Чингэлтэй дүүргийн ... хороо, Сургуулийн ... дугаар гудамжны ... тоотод 2018 оны 2 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө найз Ч.Б-нд хонож байхдаа түүний 8 настай охины бэлэг эрхтэнд гарын хуруугаа хийх, аманд нь бэлэг эрхтнээ хийх зэргээр бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Шүүгдэгч нь хохирогчийн аавтай цуг ажилладаг бөгөөд эхнэртэйгээ муудалцсан гэж тогтмол ирж хамт пиво уудаг бөгөөд хохирогчийн гэрт хонодог байжээ. Энэ гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл нь гэр орондоо байнга архи дан согтуурах явдал, хүүхдэдээ тавих хараа хяналт байхгүй, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглээд “тасарч унадаг” байдал, найз нөхдөө буруу таньж нөхөрлөдөг явдал, бага насны хүүхэдтэй ярилцах ойлгох явдал буюу хайр халамж дутагдах явдал юм.

Оногдуулсан ял: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгчийг 12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэжээ. Хорих ялыг нээлттэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: Шүүхээс шүүгдэгчид ял оногдуулахдаа анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг эрүүгийн

хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцсон ба мөн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, түүний хувийн болон эрүүл мэндийн байдлыг харгалзан түүнд оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад тусгаарлаж эдлүүлэхээр шийдвэрлэжээ. Бага насны хохирогч нь хүчирхийлэлд өртсөнөөс хойш сонгомол дуугүйрэл эмгэгтэй болсон байна.

**ТҮҮВЭР
СУДАЛГАА-19**

Эрүүгийн хэргийн дугаар: 2014250000998

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо:
330, 2015.03.16

Шийдвэрлэсэн шүүх: Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Б, 1981 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Завхан аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн, 33 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн ажилгүй, ам бүл 3, эх, эгчийн хамт, Баянзүрх дүүргийн ... хороо Монелийн ... дугаар гудамжны ... тоотод оршин суух, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Г.М, 8 нас 11 сартай, эмэгтэй. Монгол Улсын иргэн Л.М, 7 нас 11 сартай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Б нь 2013 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Баянзүрх дүүргийн ... дүгээр хороо ... гэх газар бага насны буюу 8 настай, эмэгтэй Г.М-ыг “Зам заалгая” хэмээн хуурч мэхлэн өөрийн ... улсын дугаартай Тоёото чейзер-100 маркийн автомашинд суулган Баянзүрх дүүргийн ... хороо, Улиастайн голын

орчим аваачиж, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан айлган сүрдүүлж, хүч хэрэглэж түүний бэлэг эрхтнийг нь долоож тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан. Мөн 2014 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 14 цагийн үед Баянзүрх дүүргийн ... дүгээр хороо ... гэх газар бага насны буюу 7 настай, эмэгтэй Л.М-ыг “Гэрт чинь хүргэж өгье” хэмээн хуурч мэхлэн өөрийн ... улсын дугаартай Тоёото чейзер-100 маркийн автомашинд суулган Баянзүрх дүүргийн ... хороо, Улиастайн голын орчим аваачиж, биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан айлган сүрдүүлж, хүч хэрэглэж хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бэлгийн дур хүслээ хангах гэсэн сэдэлтээр бага насны хичээлээ тараад явж байгаа хүүхдүүдийг хүчирхийлсэн уг этгээд нь эрхэлсэн ажилгүй сэлгүүцэж явдаг, эцэг, эхүүд сургуулийн насны хүүхдэдээ тавих хараа хяналт сул буюу ганцаараа гэр, сургууль хоёрын хооронд явдаг нь энэ гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлжээ.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Б.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар 16 жилийн хугацаагаар хорих ял, мөн хуулийн 125 дугаар зүйлийн 125.2 дахь хэсэгт зааснаар 9 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэжээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар Б.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 125 дугаар зүйлийн 125.2 дах хэсэгт зааснаар оногдуулсан 9 жилийн хорих ялыг, мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дах хэсэгт зааснаар оногдуулсан 16 жилийн хорих ял дээр нэмж нэгтгэн, биечлэн эдлэх ялыг 25 жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосон байна.

Дүгнэлт: Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нар байнгын түгшүүр айдастай, сэтгэл зүйн цочролтой, сэтгэл заслын эмчилгээг удаан хугацаагаар хийлгэх шаардлагатай гэж Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс тодорхойлолт ирүүлсэн бөгөөд хохирогч Г.М-ийн хууль ёсны төлөөлөгч 3840000 төгрөг, хохирогч Л.М-ийн хууль ёсны төлөөлөгч 5000000 төгрөг сэтгэл санааны хохирол буюу цаашид хийх эмчилгээнд нэхэмжилснийг шүүх шүүгдэгчээс гаргуулж, хууль ёсны төлөөлөгч нарт олгох шийдвэр гаргажээ. Мөн шүүгдэгчийн тээврийн хэрэгслийг төрийн өмчлөлд шилжүүлжээ. Шүүгдэгчийн үйлдэлд ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзсэн байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 1806007340262

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 1726, 2018.12.17

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Б, 1975 оны 2 дугаар сарын 3-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 43 настай, эрэгтэй, дээд боловсролтой, төмөр замын оператор мэргэжилтэй, Улаанбаатар төмөр замын замын ... дугаар ангийн сэв шалгагч ажилтай, ам бүл 2, эхнэрийн хамт Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, ... дугаар хороолол, ... гудамжны ... дугаар байрны ...тоотод оршин суудаг, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Т.Э, 13 нас, 8 сартай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Б 2017 оны 7 дугаар сард Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, Гацууртын зусланд байрлах иргэн Б.Я-ийн байшинд хохирогч Т.Э-г унтаж байхад нь буюу эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байгааг далимдуулан бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн, мөн 2017 оны 7 дугаар сард Баянгол дүүргийн 2 дугаар хороо, ... дугаар байрны орчим автомашин дотор хохирогчийг хүчиндсэн, 2017 оны 11 дүгээр сард Баянгол дүүргийн ... дугаар байрны орчим автомашин дотор хохирогчийг хүчиндсэн, 2017 оны 12 дугаар сард Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гацууртын зусланд автомашин дотор хохирогчийг хүчиндсэн, 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт хохирогчийг хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бага насны хүүхдэдээ тавих эцэг, эхийн анхаарал сул, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгодоггүй, хүмүүжүүлэх, нэр төрөө эрхэмлэх, цэвэр ариун, шударга байх талаар ойлголт өгдөггүй /хүүхдээ зөнгөөр нь өсгөж байна/, биеийн байдал, эрүүл мэндийн байдлыг ажигладаггүй, эмэгтэйчүүдийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулдаггүй байдал нөлөөлсөн байна. Тухайлбал, хохирогч бэлгийн бойжилт бүрэн олоогүй боловч онгон хальсны хуучин урагдалттай, шүүгдэгч хүч хэрэглээгүй, хүч хэрэглэхээр заналхийлээгүй байхад өөрөө бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрч, улмаар хэд хэдэн удаа орсон байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Б.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх зааснаар 13 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

Эрүүгийн хэргийн дугаар: 1806042201151

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 70, 2019.01.04

Шийдвэрлэсэн шүүх: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Б.Х, 1972 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 46 настай, эрэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, мужаан мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл 3, эгч, дүүгийн хамт Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо ... гудамжны ...тоотод оршин суудаг, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Л.А, 6 настай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Б.Х 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо, ... гудамжны ...тоот хашаанд хохирогч 6 настай охины бэлэг эрхтэнд хуруугаа хийсэн, бэлэг эрхтнийг оролдож, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бага насны хүүхдэдээ тавих эцэг, эхийн анхаарал сул байдал нөлөөлсөн байна. Тухайлбал, хохирогчийн эх ажилтай байсан тул бага насны 2 хүүхдээ дүүдээ харуулахаар үлдээсэн, гэтэл дүү нь би гар

утсандаа батарей авахаар явлаа, хүүхдүүдийг хашаанд орхисон гэж утсаар хэлээд явсан байна. Улмаар ээж нь гэртээ ирэх хооронд охин хүчиндэх гэмт хэргийн халдлагад өртсөн.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Б.Х-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх зааснаар 15 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

ТҮҮВЭР СУДАЛГАА-22

Эрүүгийн хэргийн дугаар: 201725020827

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 127, 2019.02.01

Шийдвэрлэсэн шүүх: Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ш.О, 1978 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Баянхонгор аймгийн Баянцагаан суманд төрсөн, 41 настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо ... гудамжны ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Ө.С, 12 нас, 9 сар, 22 хоногтой, эмэгтэй, сурагч, шүүгдэгчийн дагавар охин.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Ш.О Сүхбаатар дүүргийн ... дугаар хороо, Гүнжийн амны задгай

тоотод 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2017 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд хохирогч дагавар охин Ө.С-д хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, бага насны хүүхдэдээ тавих анхаарал сул байдал нөлөөлсөн байна.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Ш.О-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх зааснаар 18 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхдээ 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 2-д заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буюу 2015 оны Эрүүгийн хуулийг зөв хэрэглэжээ.

ТҮҮВЭР СУДАЛГАА-23

Эрүүгийн хэргийн дугаар: 201318000149

Шүүхийн шийтгэх тогтоолын дугаар, огноо: 123, 2013.10.25

Шийдвэрлэсэн шүүх: Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүгдэгчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Т.Г, 1979 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Увс аймгийн Өндөрхангай суманд төрсөн, 34 настай, эрэгтэй, боловсрол, мэргэжилгүй, ам бүл 3, 2 хүүхдийн хамт Дархан-Уул аймгийн Дархан

сумын ... дугаар баг, ... хэсэг, ... оршин суух, гэмт хэрэг үйлдэх үедээ Сэлэнгэ аймгийн Хушаат сумын иргэн Ж.Ц-ийнд мал маллаж байсан, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Монгол Улсын иргэн С.А, 1992 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Увс аймгийн Хяргас суманд төрсөн, 21 настай, эрэгтэй, боловсрол, мэргэжилгүй, ам бүл 4, аав, 2 дүүгийн хамт Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ... дугаар баг ... гэх газар оршин суух, гэмт хэрэг үйлдэх үедээ Сэлэнгэ аймгийн Хушаат суманд эгчийндээ мал маллаж байсан, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай.

Хохирогчийн хувийн байдал: Монгол Улсын иргэн Э.Ц, 13 настай, эмэгтэй.

Хэргийн товч утга: Шүүгдэгч Т.Г Сэлэнгэ аймгийн Хушаат сумын нутагт айлд мал маллаж байхдаа 2011 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2013 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд тухайн айлын 13 настай охин Э.Ц-г удаа дараа хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэлж ураг авхуулсан, мөн шүүгдэгч С.А Сэлэнгэ аймгийн Хушаат сумын нутагт айлд мал маллаж байхдаа 2013 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 13 настай охин Э.Ц-г хүчиндсэн.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл: Бага насны хүүхдэдээ тавих анхаарал сул, хайхрамжгүй байдал нөлөөлсөн байна. Тухайлбал, хохирогчийн ээж, хот болон аймаг, сум явахдаа бага насны охиноо өөрийн малыг малладаг залуугийн хамтаар хоёуланг нь үлдээж явдаг байсан.

Оногдуулсан ял: Шүүгдэгч Т.Г-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар 18 жилийн хугацаагаар

хорих ялаар, шүүгдэгч С.А-д мөн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт зааснаар 15 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсэн.

Дүгнэлт: Шүүгдэгчид оногдуулсан ял нь гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон бөгөөд шударга ёсны зарчимтай нийцэж байна.

ТАВ. ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧИДТЭЙ ХИЙСЭН ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

5.1. ШҮҮГЧИДТЭЙ ХИЙСЭН ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг шүүхээс хянан шийдвэрлэхэд гардаг хүндрэл, бэрхшээл, оногдуулж буй ялын төрөл, хэмжээний талаар Нийслэлийн дүүргүүдийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчидтэй урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу ярилцлага хийв. Үүнийг нэгтгэн давтагдсан дарааллаар нь авч үзвэл:

1. Дүүргүүдийн шүүхийн ачаалал хэтэрхий их тул гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг. Тухайлбал, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 10 шүүгчтэй бөгөөд хагас жилийн байдлаар 1400 орчим гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн, дээр нь зөрчил, магадлан гээд ажил их байдаг.
2. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн тухайд хохирогч хүүхдийг шүүх хуралд авчирч мэдүүлэг авдаг, зарим тохиолдолд шүүгдэгчийг тусгаарладаг, гэхдээ л хохирогч хүүхдүүд шүүгдэгчтэй уулзах, тааралдах тохиолдол байдаг нь хэцүү санагддаг. Хүүхдүүд бүлтгэнээд л, айгаад л, ярьж чадахгүй байдал ажиглагддаг.
3. Хууль ёсны төлөөлөгчийн асуудал хүндрэлтэй, ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн байдаг тул ээжийг нь тогтоохоор нэхэмжлэх зүйлгүй, гомдол, саналгүй гэдэг. Энэ нь хууль ёсны төлөөлөгч буруу тогтоогдсон, мэдүүлгээсээ буцах тохиолдлыг бий болгодог.
4. Нотлох баримтыг устгах явдал цөөнгүй гардаг. Тухайлбал, хүүхдээ жирэмсэн болсныг мэдээд эм уулгаж ураг зулбуулдаг, эсвэл эмнэлэгт дагуулж очоод үр хөндүүлдэг, ДНК-ийн шинжилгээ хийх боломжгүй ургийг устгалд оруулчихсан

байдаг, мөн зулбуулаад ургийг хаячихсан гэдэг. Энэ нь шүүгдэгчийн гэм бурууг тогтооход сөргөөр нөлөөлдөг.

5. Энэ төрлийн гэмт хэрэгт сэтгэл санааны хохирол тооцож олгосон практик байхгүй. Учир нь хэчнээн сэтгэл санаагаар хохирсон сэтгэцийн эмгэгтэй гэж дүгнэлт гарсан байлаа ч сэтгэл санааны хохирлыг хэрхэн, хэдэн төгрөгөөр эмчлэх талаар нотлох баримт цуглуулах боломжгүй. Монгол Улсад энэ төрлийн эмчилгээ явуулдаг байгууллага, сэтгэл зүйч байхгүй, тогтсон үнэлгээ байхгүй учир сэтгэл санааны хохирол төлүүлэх боломжгүй.
6. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт завдсан этгээдэд оногдуулах ялын доод хэмжээг зааж өгөөгүй нь зөв гэж ойлгож байна. Учир нь ялыг ялгамжтай оногдуулах боломж бүрдүүлдэг. Завдсан тохиолдлуудад шүүгдэгчийн гэмт үйлдэл, хувийн байдал, нийгмийн хор аюул нь бүгд өөр өөр байдаг.
7. 2015 оны Эрүүгийн хуульд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ял, гэмт хэргийн хүрээ хязгаар оновчтой, эрэгтэй хүүхэд хохирогч болсон тохиолдолд хүчиндэх гэмт хэргээр зүйлчлэх, ялын ялгамжтай оногдуулах боломжтой зэрэг олон асуудал оновчтой хуульчлагдсан гэж шүүгчид хэлж байсныг дурдах нь зүйтэй.

5.2. ПРОКУРОРУУДАЙ ХИЙСЭН ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

Дүүргүүдийн Прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокуроруудтай бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт хяналт тавихад гарч буй хүндрэл, оногдуулж буй ялын талаар урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу ярилцлага хийв. Үүнийг нэгтгэн давтагдсан дарааллаар нь авч үзвэл:

1. Дүүргийн мөрдөгчдийн мэдлэг, ур чадвараас шалтгаалан бага насны хүүхдийн ярьсан зүйлийг найруулж, өөрийн хэллэгээр болгож бичдэгтэй холбоотойгоор хүүхдийг бэлгийн

харилцааны талаар сайн мэддэг, том хүн шиг ярьсан байна гэжбуруутгадаг.

2. Гэмт хэргийн онцлогоос шалтгаалж нотлогдвол зохих зүйл буюу гэмт хэрэг, хэзээ, хаана үйлдэгдсэн болохыг тогтооход хүндрэл үүсдэг. Тухайлбал, бага насны хүүхдүүд хаана гэдгээ мэддэггүй, он, сар, өдөр мэдэхгүй зун, өвөл гэж мэдүүлдэг, олон удаагийн хүчиндсэн үйлдэлтэй бол давтамж буюу тоогоо мэдэхгүй зэргээс хамааран хүндрэл үүсэж, өмгөөлөгч нарын хүсэлтээр зарим үйлдлийг хэрэгсэхгүй болгох тохиолдол их байдаг.
3. Хохирогчид гэр бүлийн зүгээс дарамт үзүүлдэг учир мэдүүлгээ буруу өгөх, би хэрэггүй хэлсэн байна хэмээн шаналж зовох, амиа хорлох оролдлого хийх зэргээр сэтгэл зүйн дарамтад ордог.
4. Өмгөөлөгч олдохгүй, хууль ёсны төлөөлөгч тогтооход хүндрэл учирдаг.
5. Бага насны хүүхэд дарамт, шахалт, сэтгэл зүйн байдлаасаа болж мэдүүлгээсээ их буцдаг. Ар гэрийн зүгээс хэл ам их гаргадаг, хэрэгт нөлөөлөх гэж оролддог, нөхрөө, ах дүүсээ ялаас чөлөөлөх гэж бага насны хүүхдийн эрх ашгийг орхигдуулдаг.

5.3. МӨРДӨГЧИДТЭЙ ХИЙСЭН ФОКУС ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

Нийслэлийн мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, дүүргүүдийн Цагдаагийн хэлтсийн мөрдөгчидтэй бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг мөрдөн шалгахад гарч буй хүндрэл, оногдуулж буй ялын талаар урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу ярилцлага явууллаа. Үүнийг нэгтгэн давтагдсан дарааллаар нь авч үзвэл:

1. Гэмт хэрэгт холбогдсон этгээд нь ихэвчлэн ар гэрийн хүмүүс байдаг учир хохирогчид өмгөөлөгч олдохгүй, олдсон нь үнэтэй өмгөөлдөг, хууль ёсны төлөөлөгчөөр тогтооход хүндрэл тулгардаг.

2. Бага насны буюу 14 насанд хүрээгүй хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд дуугүйрэл, хямрал, ганцаардал зэрэг сэтгэцийн эмгэгтэй болсон байдаг тул мэдүүлэг авахад хүндрэл үүсдэг. Нэг удаа ээждээ, эгчдээ ярьсан гээд өргөдөл өгдөг дахиад асуухаар ярихгүй дуугүй байх тохиолдол их гардаг тул мэдүүлэг авахад бэрхшээлтэй байдаг.
3. Энэ төрлийн хүчиндэх гэмт хэрэг нь ахуйн хүрээнд дагавар хүүхэд, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хооронд үйлдэгддэг учир үйлдэгдсэн даруйд бус хугацаа алдаж цагдаагийн байгууллагад мэдэгддэг нь шинжилгээ хийлгэх, нотлох баримт бүрдүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлдөг.
4. Эцэг, эх, ар гэрийн нөлөөнд орж бага насны хүүхэд мэдүүлгээсээ буцах, буруу зөрүү ярих тохиолдол их гардаг.
5. Өмнө нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг харьцангуй бага бүртгэгддэг байсантай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийг эмэгтэй мөрдөгчид шалгадаг байсан бол одоо мөрдөгчийн хүйс харгалзахгүй шалгаж байгаа учир эмэгтэй хүүхэд ичих асуудал тулгарч байна. .
6. Сүүлийн үед хүүхдүүд эрт бэлгийн харьцаанд орох болсон бөгөөд өөрсдөө тохиролцож бэлгийн харьцаанд орж байгаад эцэг, эхдээ мэдэгдэх эсвэл жирэмсэн болохоороо бусдад хүчиндүүлсэн гэх тохиолдол их гарч байна. Үүнийг шалгахад хүндрэл их байдаг.
7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай, тэдгээрийн хамгаалалтын талаар их ярьдаг боловч бодит байдал дээр хамгаалах талаар ямар ч алхам байдаггүй. Ар гэрээс нь тусгаарлах шаардлага гардаг.
8. Мөрдөгчийн ажлын ачааллаас шалтгаалж гэмт хэргийг гүйцэт, бүрэн дүүрэн шалгах боломж цаг хугацааны хувьд хомс байдаг.
9. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч сэтгэл санааны хохиролд их хэмжээний мөнгө нэхэмжилдэг, хохирлоо мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулах сонирхолтой байдаг учир мөрдөгчийг хэл амаар доромжлох асуудал их гардаг.

ДУГНЭЛТ

Судалгааны үр дүнд үндэслэн дор дурдсан дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдэж, хүүхэд хамгааллын төрийн бодлого тодорхойлогдож, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа эрчимжиж байгаа хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурахгүй байна.
2. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, Монгол Улс дахь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн нийт гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жин өсөх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг нэмэгдэх хандлагатай байна. Харин сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилттэй холбоотойгоор бага насны хүүхдийг алах гэмт хэргийн гаралт тогтворжих хандлагатай байна.
3. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээг удирдлага болгон хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэж ирсэн бөгөөд Эрүүгийн хуулийг илт буруу хэрэглэж, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулсан байдал байхгүй байна.
4. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж, 2002 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт дунджаар 22.2 жилийн хугацаагаар хорих эсхүл цаазаар авах ял оногдуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт дунджаар 14.25 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байгаа нь ялын бодлого 7.95 жилээр зөөлөрсөн байна.
5. 2002 оны Эрүүгийн хуульд заасан хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогыг 2015 оны Эрүүгийн хуультай харьцуулан үзвэл нэг удаагийн үйлдлээр хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 4.75 жилээр зөөлөрсөн,

гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 1,5 жилээр чангарсан, удаа дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 3.7 жилээр суларч, бүх насаар хорих ял оноогоогүй, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулсан хорих ялын бодлого 4.4 жилээр чангарсан байна. Нийт оногдуулсан ялын бодлогыг авч үзвэл хорих ялын бодлого 0.7 жилээр чангарсан, цаазаар авах ялын орлуулан хэрэглэхээр хуульчилсан бүх насаар хорих ялыг хэрэглээгүй байна.

6. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуульд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 125 дугаар зүйл/-т тооцож байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд энэхүү үйлдлийг хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжид хуульчилснаар хүчиндэх гэмт хэргийн улсын хэмжээний статистик тоо нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын бодлого 6.3 жилээр чангарчээ.
7. 2015 оны Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүнийг алсан, хүчиндсэн бол зүйлчлэлийн хувьд хүндрүүлэхээр заасан боловч шүүхийн практикт гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн зарим тохиолдолд хохирогч гомдолгүй, хохирлыг барагдуулсан, нэхэмжлэх зүйлгүй, гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, гэмшсэн гэж тухайн зүйл, хэсэгт заасан харьцангуй хөнгөн ялыг оногдуулах хандлагатай байна.
8. Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь 1) гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн таагүй орчин, 2) эцэг эхийн хараа хяналт сул байдал, 3) хүүхэд хамгааллын тогтолцоо бүрэн бүрдэж, үйл ажиллагаа нь оновчтой бус 4) ахуйн хүрээний архидалт, 5) нийтийн сүлжээний хяналтгүй байдал 6) гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал (боловсролын түвшин, эрхэлсэн ажилгүй, хувь хүний төлөвшил, ёс суртахуун), 6) хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг байна.

9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан хэрэгжүүлж, Эрүүгийн хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг”, Зөрчлийн тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчих” зөрчлийг бие даасан байдлаар хуульчилж, гэр бүлийн хүрээнд удаан хугацаанд үргэлжилдэг хүчирхийлэлтэй тэмцсэний үр дүнд 2015 оноос хойш үйлдэгдэж, шүүхээр шийдвэрлэгдсэн бага насны хүүхдийг алах гэмт хэргүүдийн дотор удаан хугацаанд үргэлжилсэн хүчирхийлэл, онц харгис хэрцгий аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурах хандлага ажиглагдаж байна.
10. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болж байна. Нөгөө талаар хохирогч хамгааллын асуудал тулгамдсан хэвээр байна.
11. Насанд хүрсэн хүнийг алах явцдаа болон үйлдсэн хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор бага насны хүүхдийг алсны улмаас гэр бүлийн бусад гишүүдийг асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй болсон тохиолдолд асран хамгаалагч тогтоох, тэжээн тэтгэх, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, сэтгэл санааны хохирлыг тогтоох зэргийг асуудал хүндрэлтэй хэвээр байна.
12. Шүүгч, прокурор, мөрдөгчидтэй хийсэн фокус ярилцлагын үр дүнгээс үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хяналт тавих, шүүхээс хянан шийдвэрлэхэд хууль ёсны төлөөлөгчийг бодитойгоор тогтоох, нотлох баримтыг устгах, нотлох баримтгүй болгох, хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тогтоох, бага насны хүүхдээс тайлбар мэдүүлэг авах аргачлал тогтоогүй, хохирогч хэргийн бодит байдлыг тайлбарлаж чаддаггүй, өмгөөлөгч олдоггүй, хохирогчийн аюулгүй байдлыг хангах зэрэг хүндрэл, бэрхшээл тохиолддог болох нь харагдаж байна.

ЗӨВЛӨМЖ

Нэг. Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг бэлгийн харьцаанд орох үйлдлээс ангид ялын бодлогын хувьд ялгамжтай байдлаар дор дурдсан агуулгаар хуульчлах, Тухайлбал,

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх

1. Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хүчээр бэлгийн харьцаанд орсон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:
 - 3.1. арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;
 - 3.2. бүлэглэж;
 - 3.3. гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;
 - 3.4. хохирогчийг жирэмсэн болгож;
 - 3.5. хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;
 - 3.6. хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;
 - 3.7. урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;
 - 3.8. харгис хэрцгий аргаар;

3.9. хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
5. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.

-Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

-“Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно.

2. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг 20 жилээр тогтоох байдлаар Эрүүгийн хуулийн 1.10 зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах;
3. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох, өршөөл, уучлал үзүүлж, ялаас чөлөөлөх, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээ хэрэглэхгүй байхаар хуульчлах;
4. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсан үйлдэлд оногдуулах ялын доод хэмжээг Эрүүгийн хуульд хуульчлах;

5. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохдоо ялтан зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж, ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй болохыг тодорхойлох шалгуурыг тодорхой болгох;
6. Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялыг шударгаар оногдуулах;
7. Бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн болон хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий мөрдөгч, прокурор, шүүгч бүхий дагнасан тогтолцоо бий болгох боломжийг судлах /Juvenile justice system/;

Хоёр. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгаснаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй эсэх талаар суурь судалгаа хийх;
2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөх эрсдэлийн судалгааг жил бүр хийж, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхдөө судалгааны үр дүнг ашиглах;
3. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх;
4. Бага насны хүүхдийг хүчиндэх болон алах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд шүүхээс бүх насаар хорих ял оногдуулахад анхаарах;
5. Хүүхэд гэмт хэрэгт хохирох, ялангуяа хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жинг

бууруулах чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

6. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
7. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, батлан хамгаалах яам хамтран гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, гэр бүл салалтаас үүсэх үр дагаврын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутан, хугацаат цэргийн алба хаагч нарт сургалт явуулах ажлыг тогтмолжуулах;
8. Хүүхдийн эрхийн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахад чиглүүлэх, ажлын үр дүнг тооцож, ажиллах;
9. Садар самуун явдал, биеэ үнэлэх, хардалт, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээнт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернэт орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах;
10. Бага насны хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрх бүхий байгууллага, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, гэр бүлийн гишүүдэд цаг алдалгүй хандах талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар мэдээлэл хүргэх;

11. Энэ төрлийн гэмт хэргийг түгээмэл үйлдэж буй 19-25 насны бүрэн дундаас доош боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилгүй, ял шийтгэл эдэлж байсан, тэнсэгдсэн, ял хойшлогдсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, гэмт хэргийн хор уршиг, эрүүгийн хариуцлагын талаарх болон зан үйлд нөлөөлөх сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулах;
12. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж суллагдсан хүнд тавих хяналтыг сайжруулах, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх;
13. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг эрүүл мэндийн үзлэг, хүүхдийн хөгжлийн ерөнхий байдлын судалгаанд тогтмол хамруулах;

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
2. Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. УБ., 2002.№5
3. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
4. Зөрчлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №5
6. Хүүхдийн эрхийн тухай хууль //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №9
7. Хүүхэд хамгааллын тухай хууль //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №9
8. Гэр бүлийн тухай хууль //Төрийн мэдээлэл. УБ., 1999. №30
9. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт

Хоёр. Ном сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

1. Бат-Очир Л, Гантулга С, Энхболд Б. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг. УБ., 2011
2. Баярсайхан Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012
3. Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2011
4. Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018
5. Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ., 2011
6. Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургаал/. УБ., 2009
7. Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. /Ялын тухай сургаал/. УБ., 2014
8. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. /Хамтын бүтээл/ Улсын Дээд Шүүх. УБ., 2010
9. Нарангэрэл С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. ерөнхий анги. УБ., 1999
10. Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2009
11. Совд Г.Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002
12. Үзмээ С. Хүчиндэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал магистрын ажил. Дотоод хэргийн их сургууль. 2012
13. Монголын криминологичдын холбоо. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. УБ., 2017

14. Монголын криминологичдын холбоо. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. УБ., 2018

Гурав. Судалгааны материал

1. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлын алба. “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал”. УБ., 2019
2. Иргэдийн Аллианс төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Хүчингийн гэмт хэргийн эрх зүйн орчин” судалгааны тайлан. УБ., 2008
3. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Хүчингийн гэмт хэргийн хуульчлагдаагүй төрөл” судалгааны тайлан. УБ., 2008
4. Хүний Эрхийн Үндэсний Комисс. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа”. УБ., 2007
5. Хүний эрх хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин”. УБ., 2002
6. НҮБ-ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Дэлхийн зөн Монгол байгууллага. “Хүн худалдах гэмт хэрэг ба охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг”. УБ., 2007
7. Хүүхдийг ивээн сан. Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ-2018. УБ., 2019
8. Монголын эмэгтэйчүүдийн сан, Дотоод хэргийн их сургууль, Хүйсийн тэгш эрхийн төв. “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс” судалгааны тайлан. УБ., 2019
9. Хөгжлийн академи төрийн бус байгууллага. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгаа. УБ., 2017
10. Монголын эмэгтэйчүүдийн сан, Дотоод хэргийн их сургууль, Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллага. “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс” судалгаа. УБ., 2019
11. Улсын Ерөнхий Прокурорын газар. “Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” судалгаа. УБ., 2019

Дөрөв. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл

1. Б.Батзориг. “Гэмт хэргийн бодит тоон үзүүлэлтийг тогтооход нөлөөлж болох хүчин зүйлс”// “Гэмт явдалтай тэмцэх асуудал”. УБ., 2002., №1
2. С.Гантулга. “Хүчиндэх гэмт хэргийг төсөөтэй зарим гэмт хэргүүдээс ялган зүйлчлэхэд анхаарах асуудал”//“Гэмт явдалтай тэмцэх асуудал”. 2014., №1 (47)

3. Б.Оюун-Эрдэнэ, “Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал”, Proceedings of the Mongolian Academy of Sciences Vol. 52 No 3 (203) 2012
4. С.Тунгалагтамир. “Төрөөс хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлууд” Хүүхэд хөгжлийн орчин үеийн асуудлууд, Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018
5. Б.Энхболд. ”Монгол Улсын Эрүүгийн хууль дахь нийгмийн ёс суртахууны эсрэг зарим гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал./Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ., 2010., №3
6. Lochner, L. (2011a), “Education Policy and Crime”, in P. Cook, J. Ludwig and J. McCrary, eds., Controlling Crime: Strategies and Tradeoffs, University of Chicago Press, Chicago
7. Hasan Buker (2011). “Formation of self-control: Gottfredson and Hirschi’s general theory of crime and beyond”. 16 (3)

Тав. Цахим эх сурвалж

1. [http:// www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [http:// www.un.org](http://www.un.org)
3. [http:// www.unodc.org/india](http://www.unodc.org/india)
4. [http:// www.csrindia.org](http://www.csrindia.org)
5. [http:// www.mha.nic.in](http://www.mha.nic.in)
6. [http:// www.humanrights.mn](http://www.humanrights.mn)
7. [http:// www.chrd.org.mn](http://www.chrd.org.mn)
8. [http:// www.ifrro.org](http://www.ifrro.org)
9. [http:// www.shuukh.mn](http://www.shuukh.mn)
10. [http:// www.nso.mn](http://www.nso.mn)
11. [http:// www.1212.mn](http://www.1212.mn)
12. Global childhood report 2019- Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report

